

“Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөл

# ТА ӨӨРӨӨ БАГШ

4-5 настай хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан багц гарын авлага

*(Дахин сайжруулсан гурав дахь хэвлэл)*

Улаанбаатар хот  
2017 он

Дэлхийн Банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх Сангаас Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамтай хамтран хэрэгжүүлж буй "Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь" төслийн хүрээнд хэвлүүлэв.

Уг бүтээлийн агуулга, үзэл санааг зохиогчид хариуцах бөгөөд ямар ч нөхцөлд Дэлхийн Банк болон Хүүхдийг Ивээх Сангийн байр суурийг илэрхийлэхгүй болно.

## ТА ӨӨРӨӨ БАГШ

Засан сайжруулсан:	Г.Монголхатан Д.Гэрэлтуяа Б.Даваасамбуу С.Мөнхжаргал
Зураач:	Б.Баярмагнай
Дизайнер:	З.Ганхуяг
Цаасны хэмжээ:	175x250
Хэвлэлийн хуудас:	12.33

"Би Си Ай" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

## ӨМНӨХ ҮГ

Хүндэт эцэг эх, асран хамгаалагч танаа

*Хүний чадвар, зан чанар, нийгэмд эзлэх байр суурийн 85% нь 5 хүртэлх насанд нь төлөвшин бүрэлддэг.*

Бидний хүүхэд өсөж том болохдоо, бие сэтгэлээр эрүүл, сурч мэдэх хүсэл эрмэлзэлтэй, бусадтай зохицон амьдрах чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, сонголт хийж чаддаг, тохиолдох саад бэрхшээлийг даван туулдаг, тулгарсан асуудлаа шийдвэрлэдэг, өөрийн гэсэн байр суурьтай иргэн болж төлөвших учиртай юм. Хүүхдээ ингэж өсгөхийн тулд янз бүрийн мэдлэг эзэмшүүлэх гэхээсээ илүүтэй:

- тэдний төрөлхийн суралцах хүсэл эрмэлзэл, дур сонирхлыг бадраах
- тэдэнд орчинтойгоо идэвхтэй танилцаж, өөрөө оролдож туршиж учир холбогдлыг нь олж нээх боломж олгох
- Бие даах чадвартай болоход нь **дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.**

Олон жилийн турш багш нар **"Хүүхдийн 5 хүртэлх нас хамгийн чухал"** гэж үзсээр ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд бага насны хүүхдийн талаарх судалгааны ажил дэлхий нийтэд эрчимжиж, тэдний хөгжлийн онцлог, боломжийн талаар шинэ нотолгоо, мэдлэг, мэдээлэл бий болсоор байна. *Тухайлбал:*

- Сургуулийн өмнөх (Хоёр наснаас сургуульд элсэх хүртэл<sup>1</sup>) насанд хүүхдийн тархи маш эрчимтэй хөгждөг бөгөөд уян хатан чанартай байдаг;
- Суралцах орчин, түүнчлэн ойр дотны харилцаа нь тэдний хөгжил, төлөвшилд чухлаар нөлөөлдөг;
- Хүүхэд боловсролын нэг түвшнээс нөгөө түвшинд (цэцэрлэгээс сургуульд) шилжих шилжилтийг зөв хийх нь тэдний суралцах үйлд эерэг нөлөө үзүүлж, насан туршийн амьдралын суурь болдог.

### **Хүүхдийн хөгжилд 5 хүртэлх нас яагаад хамгийн чухал үе вэ?**

#### **Хүний тархины хөгжлийн хамгийн эрчимтэй үе нь БАГА НАС юм.**

- Янз бүрийн мэдлэг, чадвар эзэмших үе нь бага нас;
- Гурван настай хүүхдийн тархи насанд хүрсэн хүнийхээс 2 дахин идэвхтэй;
- Бага насан дахь харилцаа нь хүүхдийн тархины хөгжилд шууд нөлөөлдөг;
- Бага насандаа олж авсан **туршлага** хүүхдийн тархины цаашдын хөгжилд шийдвэрлэх нөлөөтэйг тархины талаарх судалгаа нотолжээ;

<sup>1</sup> Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4.1.1. заалт

### **Бага насны хүүхдийн тархины хөгжилд юу сөргөөр нөлөөлдөг вэ?**

- Хоол тэжээлийн дутагдал
- Хүүхэдтэй харилцахгүй байх
- Хүчирхийлэх, хүчирхийлэл дарамттай орчинд байлгах
- Сэтгэлийн хямралд оруулах, үл хайхрах зэрэг болно.

### **Хүүхэд хэрхэн суралцдаг вэ?**

- Даган дуурайх нь хүүхдийн суралцах гол үйл явц болдог.
- Хүүхэд хайр халамж мэдэрч, тайван, амгалан, чөлөөтэй, хөдөлгөөний хязгаарлалтгүй нөхцөлд идэвхтэй суралцдаг.
- Хүүхэд бодит амьдралын бүхий л хүрээнд томчуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хамтран оролцсоноор илүү хурдтай суралцдаг.
- Хүүхэд бусадтай бодол санаагаа солилцож байж хорвоо ертөнцийн талаарх мэдлэгээ бүтээдэг.
- Хүүхэд сонирхсон, сэтгэлийг нь хөдөлгөсөн зүйлсийг удаан хугацаанд мартдаггүй.
- Аливаа зүйлд өөрийн дур сонирхлоор оролцвол илүү бүтээлчээр суралцдаг.
- Хүүхэд бүхий л мэдрэхүйнхээ (харах, үнэрлэх, сонсох, амтлах, хүрэлцэх) тусламжтайгаар таньж мэдвэл илүү сайн суралцдаг.

## **2 – 5 настай хүүхдийн хөгжлийн онцлог**

### **2 нас – “Би, би өөрөө, минийх”**

- Харандаа барьж, юмны дүрс төсөөг гаргах гэж оролдоно.
- Үндсэн өнгө (улаан, хөх, шар) ба нарийн авиа, дууны өндөр намыг ялгаж эхэлнэ.
- Авиа дууны аянд тохируулан хялбар хөдөлгөөн хийнэ.
- Үгийн нөөц нь 250-300 орчимд хүрнэ.

### **3 нас – Хүний амьдралын хамгийн баяр баясгалантай үе**

- Гол онцлог нь гэр бүлийн доторх харилцаа, тухайлбал эцэг эхийн хооронд үүсэх харилцаанд тун соргог ханддаг явдал юм. Хэрүүл маргаан, орилоон хашхираан бүү хэл өчүүхэн үгийн зөрөө хүүхдийн сэтгэлийг хямруулж, тэднийг дүнсгэр, ууртай эсвэл зөрүүд болгодог байна.
- Заримдаа өөрөө өөртэйгөө ярьж, түүнийгээ үйл хөдөлгөөнөөр илэрхийлнэ.

- Тоглоомоос сэтгэлийн асар их баяр баясгалан олж авна. Тоглоомоо хуваалцах, өөрийн ээлжээ хүлээх, сольж тоглох зэрэг дадал эзэмшинэ.
- Зураг зурах тун дуртай. Эхлээд улаан, хөх, цагаан, шар өнгийг мэдэрнэ.
- Эцэг эхдээ хязгааргүй хайртай, өөртөө ч сэтгэл хангалуун байна.
- Магтаалын үг сонсохын тулд бүхнийг хийнэ.
- Юмны өнгө мэдрэх, ялгах чадвар аажмаар сайжирна. Үгэнд амархан орно.

#### **4 нас -Хамгийн ярвигтай үе “Уяанаас алдуурсан нас” ч гэж нэрлэдэг.**

- Тоглож байхыг нь харахад сүрдүүлэг, хашхираан, хатуу шаардлага, маргаан голлож байх нь ажиглагдана.
- Харилцааны гол хэлбэр нь өөрийгөө магтах, бие биедээ гайхуулан ярих зан.
- Төрөл бүрийн буу зэвсэг, машин техникийн нэрийг амархан тогтооно.



#### **5 нас -Тайван тааламжтай үе**

- Нөхөрсөг, өөрийн хийж чадах зүйлээ сонгон авч хийнэ.
- Гэр бүлийнхэндээ их хайртай.
- Туршлагатай эцэг эхийн нөлөөгөөр хүний сайн чанарыг өөртөө шингээн тусгаж авах, өөрийн болгох бүрэн боломжтой.
- Үе тэнгийнхэн рүүгээ тэмүүлэх нь ихэснэ.
- Бодож санаснаа өөрийн үгээр чөлөөтэй илэрхийлэх гэж оролдоно.
- Их сониуч.
- “Хөхөө хөхөж байхад нь хүмүүжүүлж чадахгүй бол хүрз барьсан хойно нь хүмүүжүүлж чадахгүй” гэж бидний өгүүлэн ярилцдаг нь иймхүү учир шалтгаантай аж.

*Хүний хөгжлийн хамгийн их өөрчлөлт гарах бага насанд нь ухаалаг хөрөнгө оруулалтыг хамтдаа хийхийн учир эцэг эх, асран хамгаалагч танд энэхүү зөвлөмжийг толилууллаа.*

ТА БҮХЭНД АМЖИЛТ ХҮСЬЕ.

### 4-5 насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан багц хөтөлбөрийн танилцуулга

	
<p><b>Эцэг эхийн гарын авлага</b></p>	<p><b>Хүүхдэд зориулсан гарын авлага</b></p>
<p><b>Бүтэц</b></p>	
<ol style="list-style-type: none"> <li>1. Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог</li> <li>2. Хүүхэдтэйгээ ажиллахад танд туслах зөвлөгөө</li> <li>3. Хүүхдэд бэлтгэж өгөх сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт</li> <li>4. Хүүхдийн эзэмшвэл зохих чадвар, түүнийг дэмжих дасгалын хураангуй</li> <li>5. 96 өдрийн дасгал</li> <li>6. Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдээ гэр бүлийн орчинд сургах арга барил эзэмшсэн байдлын үнэлгээ</li> <li>7. Хүүхдийн хөгжлийн ажиглалт, баримтжуулалт (Хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох үнэлгээний хуудас)</li> </ol>	<p>Энэхүү дэвтэрт тоглох, ажиглах, ярилцах, зурж урлах, тоолох, хөдөлмөрт оролцох, турших, дуу, шүлэг сурах, үлгэр зохиол сонсох, ярих зэрэг үйлийг давтамжтайгаар өдөр тутам хийж гүйцэтгэхээр оруулсан.</p>
<p><b>Ашиглах заавар</b></p>	
<ol style="list-style-type: none"> <li>1. Та хүүхэдтэйгээ ажиллахаас өмнө зөвлөмж болон хүүхдийн дасгал ажлын дэвтэртэй сайтар танилцана.</li> <li>2. “Та өөрөө багш” зөвлөмжийг ашиглан 96 өдрийн (222 цаг) дасгалыг хүүхэдтэйгээ хамтран хийнэ.</li> <li>3. Та өдөрт нэг удаагийн дасгалд 30 - 40 минутыг зарцуулна.</li> <li>4. Өмнө үзсэн дасгалыг дараа өдөр нь асууж, ярилцан бататгана.</li> <li>5. Та сургалт эхлэхийн өмнө, хойно үзүүлэлтийн дагуу хүүхэд юу сурч мэдсэн, ямар чадвар эзэмшсэнийг үнэлж, гарч байгаа ахиц, өөрчлөлтийг тэмдэглэнэ. Хэрэв “Хангалтгүй” байвал хүүхэдтэйгээ дасгалыг хамтран дахин хийж “Хангалттай сайн” түвшинд хүргэх учиртай.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Та тухайн өдрийн дасгалыг хийлгэхийн өмнө хүүхэдтэйгээ хамтран шаардлагатай хэрэглэгдэхүүнээ бэлтгэнэ.</li> <li>2. Хүүхдийн өдөр тутам хийж гүйцэтгэх дасгалуудтай танилцана.</li> <li>3. Хүүхэд сурсан дуугаа дуулах, шүлгээ унших, үлгэр зохиолыг ярих, ажиглах, зурж урлах, тоглоход нь дэмжиж тусална.</li> <li>4. Хүүхэд тухайн өдрийн дасгалыг өдөртөө багтаан хийхэд анхаарч тусална.</li> <li>5. Та хүүхдийн сайн мэддэг зүйлсээр дасгалыг баяжуулж болно.</li> <li>6. Хүүхэд нэг үйлийг олон дахин давтан гүйцэтгэхэд чадвар нь улам сайжирсаар байдаг онцлогтой тул багцад байгаа ном, тоглоомыг өдөр бүр ашиглаарай.</li> <li>7. Хүүхэд тоглох явцдаа бүтээлчээр ажиллан, шинэ зүйлийг сурч байдаг тул Та тэдний сонирхлыг харгалзан үзэж байгаа сэдэвтэй тохирох ном, тоглоомоос сонгон ашиглана.</li> </ol>


**САНАМЖ**

Хүүхэд дасгалаа гүйцэтгэх явцад анхаарлыг нь сарниулах, саад болох зүйлийг гаргахгүйг хичээнэ. Тухайлбал, хүүхдэд урьдчилан цайг нь уулгах, бие засуулах, дасгалыг гүйцэтгэхтэй ямар нэг ажил давхцуулахгүй, өөр зүйл хийлгэхгүй байх хэрэгтэй.

	
<p>Та зарим дуу, бүжиг, шүлэг, үлгэр зохиол, хөгжимт хөдөлгөөн бүхий цахим хэрэглэгдэхүүнийг “Та өөрөө багш” зөвлөмжийн дагуу ашиглаарай.</p>	<p>Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрөөр хүүхэдтэйгээ хамт хичээллэхэд зарим үед хүндрэл бэрхшээл тулгарч байвал сонсдог номыг нэмэлт хэрэглэгдэхүүн болгож хэрэглээрэй.</p>

**Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн нэмэлт хэрэглэгдэхүүн ном, тоглоомын багц**

Сургуулийн номын санд байрлах “Миний номын өргөө”-нд байрлах “Ном, тоглоомын багц”-ын нэмэлт хэрэглэгдэхүүнийг өдөр бүрийн хичээлд ашиглана.

	
<p><b>Ашиглах заавар</b></p>	
<p>Ном, тоглоомын багцад байгаа тоглоом бүрийг та өдөр тутмын хичээлдээ ашиглана. Багцад байгаа аль ч тоглоомыг хүүхэдтэйгээ тоглуулахдаа зааврын дагуу тоглуулахаас гадна та хичээлтэйгээ уялдуулан хэрэглэж болно. Өөрөөр хэлбэл: таны хүүхэдтэйгээ хичээллэсэн 1 өдрийн хичээл дээр өнгийг ялгах даалгавар байсан бол багцад байгаа тоглоомуудыг өнгөөр нь нэрлүүлж, ялгуулж болно. Эсвэл орон зайн байрлал, том жижгийн хэмжээг танин мэдүүлэх агуулга бүхий хичээлдээ тоглоомоо ашиглахдаа тоглоомын эд ангиудыг томоос жижиг рүү, жижгээс том руу өрж байрлуулах, нэрлүүлэх, тоолуулах зэргээр ашиглах боломжтой.</p>	<p>Ном, тоглоомын багцад байгаа ном бүрийг та өдөр бүрийн хичээлд хүүхэдтэйгээ ашиглана. Тухайлбал: Тухайн өдрийн хичээлд байгаа эх зохиол, шүлэг, оньсого, зүйр цэцэн үгийг тогтоож, хамтдаа ярилцсаны дараа хүүхэдтэйгээ багцад байгаа номноос уншиж, “Та өөрөө багш” номноос танилцсан эх зохиолоос юугаараа ялгаатай байгаа, ямар үйл явдлыг тусгасан талаар ярилцаж, хүүхдийн харьцуулах, танин мэдсэн зүйлээ сэргээн санах сэтгэхүйн үйлийг дэмжин хөгжүүлэх үр дүнтэй.</p>

## **БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСУУЛТАД ХАРИУЛАХ ҮЕД ТАНЫ БАРИМТЛАХ ЗУРГААН ДҮРЭМ**

### **1. Хүүхэд асуулт тавихад инээхгүй байх**

Томчууд хүүхэд юм асуухад инээх эсвэл ямар сонин асуулт вэ? гэсэн хандлагаар хандах нь хүүхдийн сэтгэлийг шархлуулж, цаашид юм асуух хүсэл сонирхолгүй болгодог. Хүүхдүүд заримдаа сонин асуулт асуудаг ч үнэн хэрэгтээ ихэнх нь аливаа юмны мөн чанарыг ойлгох зорилготой байдаг. Ямар ч асуулт тавьсан анхааралтайгаар хариулах хэрэгтэй.

### **2. Асуултад шууд хариулах**

Хүүхэд асуулт асуувал тухайн үед нь шууд хариулах хэрэгтэй. Энэ нь тухайн үед сайн хариулж чадахгүй байсан ч хэсэг хугацааны дараа зөв хариулт өгснөөс чухал байдаг. Мэдэхгүй бол номноос харж байгаад хэлье гээд хүүхдийн асуултыг хүлээн авч байгаагаа илэрхийлэх хэрэгтэй. Завгүй үедээ “Дараа нь” гэдэг үгээр амыг нь таглаад таг мартдаг явдал бий. Энэ нь олон давтагдаад ирвэл хүүхдийн асуулт асуух сонирхол алга болох нь мэдээж. Бүр томчуудад итгэхээ больдог. Тиймээс үнэхээр завгүй болоод дараа нь гэж хэлсэн бол заавал амласнаа биелүүлээрэй.

### **3. Хүүхдийн оюун ухааны хөгжилд тохирсон хариулт өгөх**

Хүүхдийн асуултад хэдийгээр шинжлэх ухааны зөв хариулт өгсөн ч гэсэн тэр нь тэдний ойлгох чадвараас хэтэрвэл нэмэр болохгүй.

2 - 4 настай хүүхэд нь хийсвэр төсөөлөлтэй (Өөрөөр хэлбэл аливаа юмыг хүнтэй адилхан амьд байдаг гэж боддог) байдаг учраас жишээ нь: “Яагаад сар намайг дагаад ирэв ээ?” гэх асуултад “Сар чамд хайртай учраас юм болов уу?” гэх мэтээр хуурмагаар хариулж болох юм. Харин 5-6 насны хүүхдэд өөрт нь аль ойрхон, бодит жишээ татан тайлбарлаж өгөөрэй.

### **4. Хүүхэд юу бодож байгаад асуулт асуув гэдгийг олж мэдэх**

“Тэнгэр яагаад хөх юм бэ?”, “Солонго яагаад гардаг вэ?” гэж байгалийн сайхан болон гайхамшигтай зүйлийг хараад сэтгэл хөдлөлөө илэрхийлж асуух нь олон байдаг. Тийм үед шинжлэх ухааны үндэстэй хариулт хүсэж байгаа биш юм. Тиймээс “Нээрээ ямар гоё юм бэ?”, “Үнэхээр гайхалтай байна шүү” гэх мэтээр адилхан сэтгэл хөдлөлөө илэрхийлэх нь илүү сайхан хариулт болж ч мэднэ.

Мөн хүүхэд эрхэлж хүссэнээ биелүүлэх гэж асуух тохиолдол байдаг. Хэчнээн хариулсан ч салж өгөхгүй асуугаад, урваганаад байвал тийм гэсэн үг юм. Тийм үед хүүхдийнхээ сэтгэл санааг ойлгож, зөөлөн эелдгээр хариулж, хүссэнийг биелүүлж өгөх нь чухал.



## **5. Зарим үед хүүхдээс өөрөөс нь асууж үзэх**

Хүүхдийн асуултад заримдаа “Чи юу гэж бодож байна?” гэж буцааж асууж үзэх нь бас хэрэгтэй зүйл. Энэ нь хүүхэд өөрөө эргэцүүлж бодох чадварыг хөгжүүлэхэд болон тухайн зүйлийн талаар хэр зэрэг мэдэж байна гэдгийг мэдэж авахад нэмэртэй. 3 настай охин ээжээсээ “Эрэгтэй хүүхэд, эмэгтэй хүүхэд хоёр ямар ялгаатай юм бэ?” гэж асуухад сандарсандаа “Чи юу гэж боддог вэ?” гэжээ. Гэтэл охин “Хөвгүүд өмдтэй, охидууд юбкайтай шүү дээ” гэж хариулсан жишээ ч байдаг. Хүүхдийн юунаас үүдэж асууж байгааг мэдвэл тохирсон хариулт олдох ёстой. Яаж хариулахаа мэдэхгүй эргэлзсэн үедээ эргүүлээд асуугаад үзээрэй.

## **6. Хүйстэй холбоотой асуулт асуувал...**

Тэд эрэгтэй, эмэгтэй хүйстэй холбоотой санаанд ч оромгүй зүйл асуухад зарим эцэг эх загнадаг. Хэдийгээр хүйстэй холбоотой боловч хүүхдийн хувьд “Шувуу яагаад тэнгэрээр нисдэг вэ?” гэдэгтэй ижил асуулт байдаг. Хүүхэд таны асуултад сэтгэл нь ханах, том болоод худлаа байсан байна гэсэн сэтгэгдэл төрүүлэхгүй байхыг анхаарч үнэн зөвийг хялбараар ярьж өгөөрэй.

## Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдээ гэр бүлийн орчинд сургах арга барил<sup>2</sup> эзэмшсэн байдлын үнэлгээ

Аймаг, сум..... Овог, нэр.....

д/д	Ерөнхий шалгуур	Үнэлгээ			
		Хөтөлбөрийн өмнө		Хөтөлбөрийн дараа	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Та хүүхдийнхээ хөгжлийн онцлогийн талаар мэдэх үү?	☺	☺	☺	☺
2	Та хүүхдийнхээ хөгжлийн талаар шаардлагатай мэдээллийг бусадтай хуваалцдаг уу?	☺	☺	☺	☺
Хүүхдийн эрүүл мэндэд анхаардаг эсэх					
3	Та хүүхдээ сумын эмнэлгээс зохион байгуулж байгаа дархлаажуулалтад бүрэн хамруулдаг уу?	☺	☺	☺	☺
4	Та хүүхдээ урьдчилан сэргийлэх үзлэг (нүд, шүд, арьс, чих, хамар хоолой гэх мэт)-т хамруулж, зөвлөгөө авдаг уу?	☺	☺	☺	☺
5	Таны хүүхэд гар угаах дэс дарааллыг мэдэх үү?	☺	☺	☺	☺
6	Таны хүүхэд зөв бие засдаг уу?	☺	☺	☺	☺
7	Таны хүүхэд хувцсаа товчилж, гутлаа үдэж чадах уу?	☺	☺	☺	☺
Хүүхдийн оюун ухааны хөгжлийг дэмждэг эсэх					
8	Таны хүүхэд овог, нэрээ хэлж чаддаг уу?	☺	☺	☺	☺
9	Таны хүүхэд гэрийн хаягаа мэдэх үү?	☺	☺	☺	☺
10	Та хүүхэдтэйгээ дотно ярилцдаг уу?	☺	☺	☺	☺
11	Таны хүүхэд гэр бүлийнхээ гишүүдийн утасны дугаарыг мэдэх үү?	☺	☺	☺	☺
12	Та хүүхдэдээ шүлэг цээжлүүлж, үгийг зөв хэлэхэд тусалдаг уу?	☺	☺	☺	☺
13	Та хүүхэдтэйгээ хамтдаа тоглодог уу?	☺	☺	☺	☺
14	Та хүүхдэдээ үлгэр ярьж, ном уншиж өгдөг үү?	☺	☺	☺	☺
15	Та хүүхдэдээ тоглоом, хичээлийн хэрэглэл, ном авч өгдөг үү?	☺	☺	☺	☺
Хүүхдийнхээ нийгэмшихүйн хөгжлийг дэмждэг эсэх					
16	Танай хүүхэд авьяастай юу?	☺	☺	☺	☺
17	Та хүүхдээ үнэлэхдээ бусдын сайн, муу талтай харьцуулдаг уу?	☺	☺	☺	☺
18	Та хүүхдээ айлгаж сүрдүүлэхээс зайлсхийдэг үү?	☺	☺	☺	☺

<sup>2</sup> Монгол улсын Боловсролын тухай хууль Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг 46.2.4.

4-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад зориулав.

19	Та хүүхдэдээ ахмад хүмүүс, найзтайгаа мэндлэхийг зааж сургасан уу?	☺	☺	☺	☺
20	Танай хүүхэд бусдаас тусламж хүсэж, бусдад тусалдаг уу?	☺	☺	☺	☺
21	Та хүүхдээ бусад хүүхэдтэй тоглохыг дэмждэг үү?	☺	☺	☺	☺
22	Та хүүхдэдээ хүмүүстэй мэндлэх, хүндлэх талаар зааж өгдөг үү?	☺	☺	☺	☺
Хүүхдийнхээ сурах хандлагыг төлөвшүүлдэг эсэх					
23	Та хүүхэдтэйгээ ном, эрдмийн талаар ярилцдаг уу?	☺	☺	☺	☺
24	Та шийдвэр гаргахдаа хүүхдийнхээ хүсэл, сонирхлыг харгалздаг уу?	☺	☺	☺	☺
25	Та хүүхдэдээ тохирсон даалгавар өгдөг үү?	☺	☺	☺	☺
26	Таны хүүхэд эцэг эх, гэр бүлээсээ хол олон цагаар тусдаа байж чаддаг уу?	☺	☺	☺	☺

Та дараах асуултад «Тийм», «Үгүй» гэсэн хариултын аль нэгийг сонгоно.  
«Тийм» гэсэн хариултад 1, «Үгүй» гэсэн хариултад 0 оноо тавина.

Та «Тийм» гэсэн хариултыг «1 оноо» гэж тоолоорой.

































д\д	Эерэг онооны тоо	Үнэлгээ
1	20-26	Хангалттай
2	10-19	Дунд зэрэг
3	0-9	Хангалтгүй

Хэрэв та 20-26 оноо авсан бол танд баяр хүргэе.

**Та хүүхдийнхээ хөгжлийн түвшинг тодорхойлоорой.**

1. Хүүхдийн хөгжлийн түвшинг дараах чиглэл тус бүрээр шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлоорой. Тухайлбал:
  - Хөдөлгөөн, эрүүл мэнд
  - Зан чанар, харилцаа
  - Хэл яриа
  - Байгаль, нийгмийн орчин
  - Математикийн энгийн төсөөлөл
  - Хөгжим, дүрслэх урлаг
2. Та хүүхдийнхээ хөгжлийн түвшинг хөтөлбөрийн хэрэгжилтийн өмнө, төгсгөлд тодорхойлж үнэлээрэй.
3. Та хүүхдийн хөгжлийг үнэлэхдээ асуултын ард байгаа дугуй дүрсийг будна. Ингэхдээ “Тийм” гэвэл улаан, “Үгүй” гэвэл шар өнгийг сонгоно.
4. Хэрэв хүүхэд тухайн зүйлийг хараахан сурч эзэмшээгүй байвал өдөр тутмын амьдрал, ажил хөдөлмөрийн явцад хамтран давтаарай.
5. Хүүхдийг үнэн зөв үнэлэх нь цаашдын хөгжилд сайнаар нөлөөлнө гэдгийг санаарай.

























### Нэг. Хөдөлгөөн, эрүүл мэнд

д/д	Асуултууд	Үнэлгээ	
		Хөтөлбөрийн өмнө	Хөтөлбөрийн дараа
1	Янз бүрийн хөдөлгөөнийг (алхалт, гүйлт, үсрэлт, харайлт, шидэлт, тэнцвэр) хийж гүйцэтгэж чаддаг уу?		
2	Хөдөлгөөнийг орон зайд зохицуулан хийж чаддаг уу?		
3	Бие даан хувцсаа өмсөж, тайлж чаддаг уу? (товчлох, цахилгаан татах, гутлаа үдэх)		
4	Өөртөө үйлчлэх энгийн хөдөлмөр хийхийг оролддог уу? (хамрын алчуур, гарын алчуур, оймсоо угаах....)		
5	Шүр, товч хэлхэх, оёх, нэхэх үйлийг гүйцэтгэж чаддаг уу?		
6	Харандаа, халбагаа зөв барьдаг уу?		
7	Шагайгаар тоглодог уу?		
8	Ирмэгүүдийг давхцуулан цаасан болон даавуун нугалбар хийж чаддаг уу?		
9	Хоол идэхийн өмнө, бие зассаны дараа гараа угаадаг уу?		
10	Шүдээ угааж, амаа зайлдаг уу?		
11	Сайн зажилж, тайван хооллож чаддаг уу?		
12	Ямар хүнсний зүйл хүний биед сайн, мууг мэдэх үү? (хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн)		
13	Гэмтэж бэртэх, аюултай зүйлээс болгоомжилж чаддаг уу?		
14	Хамрын алчуураа зөв хэрэглэж чаддаг уу?		
15	Хичээлийн хэрэглэгдэхүүн, тоглоом, бусад зүйлээ цэвэр нямбай, гамтай хэрэглэдэг үү?		
16	Аав, ээж, гэр бүлийн гишүүдийн утасны дугаарыг мэдэх үү?		

"Улаан" өнгөөр будсан дугуй дүрсээ тоолоорой.

1. 13-16 оноо - "Хангалттай"
2. 8-12 оноо - "Дунд зэрэг"
3. 6-7 оноо - "Хангалтгүй"

**Хоёр: Зан чанар, харилцаа**

д/д	Асуултууд	Үнэлгээ	
		Хөтөлбөрийн өмнө	Хөтөлбөрийн дараа
1	Найз нөхөдтэйгөө тоглохдоо нөхөрсөг байж чаддаг уу?		
2	Насанд хүрэгчдийн өгсөн заавар, зөвлөгөөг дагаж биелүүлдэг, бусдын тоглоом, эд зүйлсийг хэрэглэхдээ зөвшөөрөл авдаг уу?		
3	Бусадтай тоглоом, эд зүйлээ хуваалцдаг уу?		
4	Бусдыг хайрлан, тусалж, асарч халамжлах, аргадаж чаддаг уу?		
5	Гэр бүлдээ баримталдаг ёс, заншлыг дагаж мөрддөг үү?		
6	Дүрэм, журам зааврыг дагаж биелүүлдэг үү?		
7	Эхэлсэн ажлаа дуустал нь хийдэг үү?		
8	Аав, ээжийн эрхэлдэг ажил, гэрийн хаягаа хэлж чадах уу?		
9	"Баярлалаа", "Уучлаарай", "Зүгээр", "Болох уу?" гэсэн үгийг хэрэглэдэг үү?		
10	Бусад хүний таатай, таагүй байгааг мэдэрч, зохицон харилцаж чаддаг уу?		
11	Ахмад хүмүүс, үе тэнгийнхэнтэйгээ мэндэлж хүндэлдэг үү?		
12	Хүмүүсийн баяртай, гунигтай, айсан, гайхсан байгааг мэддэг үү?		

**"Улаан"** өнгөөр будсан дугуй дүрсээ тоолоорой.

1. 9-12 оноо - **"Хангалттай"**
2. 6-8 оноо - **"Дунд зэрэг"**
3. 4-5 оноо - **"Хангалтгүй"**

## Гурав: Байгаль, нийгмийн орчин

д/д	Асуултууд	Үнэлгээ	
		Хөтөлбөрийн өмнө	Хөтөлбөрийн дараа
1	Амьтдыг онцлог шинжээр нь ялган таньдаг уу?	😊	😊
2	Байгалийн үзэгдэл, юмсын талаар ярьж чадах уу? (бороо, солонго, цас, навч, аянга, манан, салхи, сүүдэр гэх мэт)	😊	😊
3	Эд юмсын адил ба ялгаатай талыг хэлж чадах уу?	😊	😊
4	Юмсын шинж чанарыг сонирхон, энгийн туршилт хийж чаддаг уу? (тараг, ээдэм, эээгий)	😊	😊
5	Ургамлын онцлог шинж, ургалтад агаар, ус, гэрэл, дулаан хэрхэн нөлөөлдгийг мэдэх үү?	😊	😊
6	Жилийн дөрвөн улирлын талаар илэрхийлэн ярьж чадах уу?	😊	😊
7	Номыг зөв тавьж хэрэглэдэг үү?	😊	😊
8	Ном, хичээлийн хэрэглэгдэхүүнийг нэрлэж, хурааж цэгцэлж чаддаг уу?	😊	😊
9	Дэвтрийг эхний хуудаснаас эхлэн дарааллаар хэрэглэдгийг мэдэх үү?	😊	😊
10	Хүмүүсийн ажил мэргэжлийн тухай ярьж чадах уу?	😊	😊
11	Орчноо цэвэр байлгадаг уу? (хогоо хогийн саванд хийх)	😊	😊
12	Бохирдсон усыг хүнсэнд хэрэглэж болохгүйг мэддэг үү?	😊	😊

**"Улаан"** өнгөөр будсан дугуй дүрсээ тоолоорой.

1. 9-12 оноо - **"Хангалттай"**
2. 6-8 оноо - **"Дунд зэрэг"**
3. 4-5 оноо - **"Хангалтгүй"**

## Дөрөв: Хэл яриа

д/д	Асуултууд	Үнэлгээ	
		Хөтөлбөрийн өмнө	Хөтөлбөрийн дараа
1	Байгалийн дуу чимээ, амьтдын дуу авиаг сонсоод ялгаж чаддаг уу?		
2	Ойролцоо дуудлагатай үгийг ялгаж сонсож чаддаг уу?		
3	Үлгэр, домог, зохиолыг ойлгон ярьж чаддаг уу?		
4	Зургийн үйл явдлыг ярьж чадах уу?		
5	Зургийг үйл явдлын дарааллаар байрлуулж, зохиомжлон ярьж чаддаг уу?		
6	Зургийн дагуу юмсыг тодорхойлон ярьдаг уу?		
7	Шүлэг уншиж, оньсого, аман наадам, түргэн хэллэг, зүйр цэцэн үг, ерөөл магтаалыг хэлж чаддаг уу?		
8	Зураасыг гүйцээн зурж чаддаг уу?		
9	Төрөл бүрийн зураас зурж чаддаг уу? (цэг, ташуу, махир, тахир, нуман зураас)		

"Улаан" өнгөөр будсан дугуй дүрсээ тоолоорой.

1. 8-11 оноо - "Хангалттай"

2. 5-7 оноо - "Дунд зэрэг"

3. 3-4 оноо - "Хангалтгүй"



**Тав: Хөгжим, дүрслэх урлаг**

д/д	Асуултууд	Үнэлгээ	
		Хөтөлбөрийн өмнө	Хөтөлбөрийн дараа
1	Үндсэн өнгийг мэдэж, хэрэглэж чаддаг уу?	☺	☺
2	Усан будаг ашиглан бийр, гар хурууны мөр толбоор зурж чадах уу?	☺	☺
3	Хялбар аргаар зурж чадах уу? (хавсарч, .... )	☺	☺
4	Төрөл бүрийн дүрс, зураас ашиглан зураг зурж чадах уу?	☺	☺
5	Бэлэн дүрс, зургийг төрөл бүрийн будгаар хүрээнээс гаргалгүй будаж чаддаг уу?	☺	☺
6	Өнгө дүрсийг нэрлэх, зураас, нугалаасыг дагуулан урж, хайчилж чаддаг уу?	☺	☺
7	Төрөл бүрийн материал ашиглан эд юмсыг зохион бүтээдэг үү?	☺	☺
8	Эд зүйлсийн хэлбэр дүрсийг нэрлэж, дүрс бүтээдэг үү?	☺	☺
9	Цаасыг хайчилж, бүтээл хийж чадах уу?	☺	☺
10	Төрөл бүрийн материал ашиглан (харандааны зоргодос, торгоны өөдөс, ноос, шигтгээ, шүр) наамал хийж чаддаг уу?	☺	☺
11	Баримлын шавраар дүрс болон амьтан, эд юмсыг бүтээж чадах уу?	☺	☺
12	Үлгэрийн баатрын дүрд хувирч, жүжиглэн тоглодог уу?	☺	☺
13	Хүмүүсийн ажил хөдөлмөрийг дуурайн тоглодог уу?	☺	☺
14	Дуу дуулж чадах уу?	☺	☺
15	Хөгжмийн аялгуунд бүжиглэж чадах уу?	☺	☺
16	Хөгжмийн хэмнэлээр алгаа ташиж, товшиж чадах уу?	☺	☺

**"Улаан"** өнгөөр будсан дугуй дүрсээ тоолоорой.

1. 13-16 оноо - **"Хангалттай"**

2. 8-12 оноо - **"Дунд зэрэг"**

3. 6-7 оноо - **"Хангалтгүй"**

### Зургаа: Математикийн энгийн төсөөлөл

д/д	Асуултууд	Үнэлгээ	
		Хөтөлбөрийн өмнө	Хөтөлбөрийн дараа
1	Бодит юмсыг 10 хүртэл оноож тоолох, ялган нэрлэж чадах уу?	😊	😊
2	Юмсын хэлбэр дүрс, олон цөөн, өнгийг ялгаж чаддаг уу?	😊	😊
3	Нэмэгдүүлж, хорогдуулж бодлого бодож чаддаг уу? (10-ын дотор)	😊	😊
4	Юмсыг тоолоод тохирох тоотой нь холбож чаддаг уу?	😊	😊
5	Тоог 2 буюу хэд хэдэн бага тоо болгон задалж чадах уу?	😊	😊
6	Баруун, зүүн, урд хойд зүгийг нэрлэж, юмсын байрлалыг тодорхойлдог уу?	😊	😊
7	12 жилийг таньж, өөрийн болон дотны хүмүүсийнхээ төрсөн жилийг нэрлэж чаддаг уу?	😊	😊
8	Шингэн, бутармаг зүйлсийг тохирох хэрэгсэл (халбага, аяга, шанага)- ээр хэмжиж чаддаг уу?	😊	😊
9	Юмсыг өгөгдсөн дарааллын дагуу үргэлжлүүлэн байрлуулж, зүй тогтлыг олж чаддаг уу?	😊	😊
10	Эд юмсыг хэмжээгээр нь ялгаж чаддаг уу? (том жижиг, хүнд хөнгөн, зузаан нимгэн)	😊	😊
11	Уламжлалт хэмжүүрийг ашиглаж чаддаг уу? (хуруу, сөөм, төө, тохой, алд, дэлэм)	😊	😊

“Улаан” өнгөөр будсан дугуй дүрсээ тоолоорой.

1. 8-11 оноо - “Хангалттай”
2. 5-7 оноо - “Дунд зэрэг”
3. 3-4 оноо - “Хангалтгүй”

4-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад зориулав.

### ХҮҮХДЭД БЭЛТГЭЖ ӨГӨХ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

д/д	Нэр төрөл	Тоо ширхэг
1	Өнгийн харандаа	1 хайрцаг
2	Пламастр	1 хайрцаг
3	Балын харандаа	2 ширхэг
4	Харандаа үзүүрлэгч	1 ширхэг
5	Нимгэн дэвтэр	2 ширхэг
6	Зургийн дэвтэр	4 ширхэг
7	Өнгийн цаас	1 боодол
8	Хайч	1 ширхэг
9	Цавуу,скоч	Тус бүр 2 ширхэг
10	Шугам, шоо	1 ширхэг
11	Усан будаг	1 хайрцаг
12	Бийр	2 ширхэг
13	Баримлын шавар	1 хайрцаг
14	Хулдаас, баримлын шавар зүсэгч	2 ширхэг
15	Савх	20 ширхэг

## ХҮҮХДИЙН ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ ЧАДВАР, ТҮҮНИЙГ ДЭМЖИЖ БҮЙ ДАСГАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Гэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх 96 өдрийн хичээл тус бүрт байгаа дасгалын тоо түүнд агуулагдаж байгаа хөгжлийн чиглэлийг доорх хүснэгтэд багтаасан. Эцэг эх та энэ хүснэгтээс хичээл бүр дээр хүүхдийн суралцах эх зохиол, шүлэг, дуу, бүжиг, зүйр цэцэн үгийг мэдэж авахаас гадна хичээлд хэрэглэгдэх хайчилбар, наадаг зураг, цахим хичээл зэрэг хичээлийн хэрэглэгдэхүүнээ урьдчилан бэлтгэх боломжтой.

### 96 ӨДРИЙН ХИЧЭЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ЗАДАРГАА

№	Сэдэв	Дасгалын тоо	Хөгжлийн чиглэл					Нэмэлт дасгалууд												
			Хөдөлгөөн, эрүүл мэнд	Зан чанар, харилцаа	Хэл яриа	Байгаль нийгмийн орчин	Математикийн энгийн төсөөлөл	Хөгжим, дүрслэх урлаг	Тоглоом	Шүлэг, аман наадам	Зохиол домог	Дуу	Бүжиг, хөгжимг дасгал	Онцлого	Зүйр цэцэн үг, түргэн хэллэг	Хайчилбар	Наадаг цаас	Цахим хэрэглэгдэхүүн	Баталгал	Хөдөлмөр
1	Миний ном	2			*										*					
2	Номын хавчуурга	2						*	1											
3	Хичээлийн хэрэглэл	2			*	*											*			
4	Харандаа	3	*					*												*
5	Өнгийн харандаа	3						*	1										*	
6	Дүрс	3				*	*									*				
7	Миний танилцуулга	3			*			*	1											*
8	Би	3		*				*											*	
9	Цэвэр гар	3	*							1										
10	Тоо тоолол-1	3					*												*	
11	Манайхан	3			*			*	1											
12	Алунгоо эхийн домог	3		*			*			1										
13	Миний нүд	3	*											1						
14	Миний чих	3	*																	
15	Миний шүд	3	*		*				1											
16	Миний гар хуруу	3	*					*											*	
17	Мэндлэх ёс	3		*	*															
18	Миний аяга	3			*	*			1											*
19	Миний тоглоом	3					*		1											
20	Миний хувцас	3			*			*			1					*				
21	Манай үндэсний хувцас	2			*			*			1					*				
22	Дээл	3	*		*				1								*	*		
23	Оймс	2						*												*
24	Миний гутал	2	*	*						1										
25	Тоо тоолол-2	3					*		1							*				
26	Цэвэрч хүү	2	*	*							1									
27	Тусч хүүхэд	2		*				*	1			1					*			*

4-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад зориулав.

№	Сэдэв	Дасгалын тоо	Хөгжлийн чиглэл						Нэмэлт дасгалууд										
			Хөдөлгөөн, эрүүл мэнд	Зан чанар, харилцаа	Хэл яриа	Байгаль нийгмийн орчин	Математикийн энгийн төсөөлөл	Хөгжим, дүрслэх урлаг	Тоглоом	Шүлэг, аман наадам	Зохиол домог	Дуу	Бүжиг, хөгжимт дасгал	Онъсого	Зүйр цэцэн үг, түргэн хэллэг	Хайчилбар	Наадаг цаас	Цахим хэрэглэгдэхүүн	Бататгал
28	Залхуу хүүхэд	2	*	*			*			1									
29	Ажигч хүүхэд	3					*											*	
30	Хог хаягдал	2	*		*											*			
31	Болно болохгүй зүйл	2	*															*	
32	Миний аюулгүй байдал	2	*																
33	Миний хоол	3			*										*				*
34	Бууз	2						*											
35	Лууван	3						*				1							*
36	Байцай	2					*	*					1						
37	Жимс	2			*		*												*
38	Алим	2					*	*	1						*				
39	Ус	3				*				1									
40	Цагаан идээ	2				*	*												
41	Айраг	2					*					1							
42	Тараг	2			*	*			1										*
43	Ааруул	2				*													
44	Бөмбөг	2	*						1										*
45	Хөгжилтэй тоолол	3					*												
46	Сэнс	2						*	1										
47	Дээс	2	*					*				1							
48	Шагай	2					*		1										
49	Та битгий уурлаарай	2	*						1					*					
50	Бөмбөлөг хөөргөж тоглох	2	*					*	1									*	
51	Унага	2						*				1							
52	Шүр хэлхэх	2	*					*											
53	Миний найз	1		*	*					1				*					
54	Эвтэй тоглоё	3		*							1						*		
55	Дугуйтай жаал	2		*				*		1									
56	Ажил мэргэжил	2			*														
57	Яаралтай тусламж	2	*																
58	Хөдөлмөрийн багаж	3	*			*						1							
59	Зураач	3						*		1									
60	Нисгэгч	2	*				*	*				1							
61	Жолооч	2						*					1						
62	Малчин	2					*	*			1					*			
63	Тээврийн хэрэгсэл	2			*			*											
64	Онгоц	2						*											*
65	Завь	2				*			1										

4-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад зориулав.

№	Сэдэв	Дасгалын тоо	Хөгжлийн чиглэл						Нэмэлт дасгалууд											
			Хөдөлгөөн, эрүүл мэнд	Зан чанар, харилцаа	Хэл яриа	Байгаль нийгмийн орчин	Математикийн энгийн төсөөлөл	Хөгжим, дүрслэх урлаг	Тоглоом	Шүлэг, аман наадам	Зохиол домог	Дуу	Бүжиг, хөгжимт дасгал	Онъого	Зүйр цэцэн үг, түргэн хэллэг	Хайчилбар	Наадаг цаас	Цахим хэрэглэгдэхүүн	Баталгал	Хөдөлмөр
66	Сониучхан	2				*														
67	Улирал	2			*					1										
68	Нар ба сүүдэр	3				*				1	1						*			
69	Цас	3			*				1											
70	Салхи	3	*	*			*		1				1							
71	Мөчир	2		*	*			1		1				*						
72	Навч	3			*		*				1					*		*		
73	Цэцэг	3			*		*					1								
74	Мөөг	2			*					1						*				
75	Амьтад	3			*													*		
76	Амьтдын цэцэрлэг	2	*			*				1					*					
77	Бамбарууш	2	*			*			1				1							
78	Гэрийн тэжээвэр амьтан	2		*			*	1												
79	Хоточ нохой	2		*			*		1											
80	Тоочин гөлөг	2				*														
81	Туулай	2					*												*	
82	Бор туулай	2					*		1											
83	Өндөг ба тахиа	3			*	*							1			*				
84	Загас	2			*		*									*				
85	Шувууд	2				*				1						*				
86	Эрвээхий	2		*	*					1										
87	5 хошуу мал	2		*					1											
88	Ишиг	2	*			*				1	1					*				
89	Миний бүтээл	2					*						1							
90	Бүтээлчээр сэтгэе	2					*													
91	Соронз	2			*		*													
92	12 жил	2				*	*				1					*				
93	Бяцхан ном	2	*				*	1												
94	Цүнх	2					*													
95	Сурагч	3	*			*				1	1									
96	Би чадна	3	*				*	1			1									
	Нийт	226						15	14	14	14	4	4	4	4	13	8	12	9	

**Зорилго:**

- Хүүхэд номтойгоо хэрхэн ажиллахыг мэдэх, номоо хайрлаж гамнахыг ойлгох
- Хүүхэд “Би чадна” дасгал ажлын дэвтрийн таних тэмдгийг таних, ялгах, ойлгож хэрэглэдэг болоход бэлтгэх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Ном, тоглоомын багц
- Хайчилбар №1

**Дасгал 1.**

1. Та “Би чадна” дасгал ажлын дэвтрийг хүүхдэдээ танилцуулж, нэрийг нь тогтоолгоорой.
2. “Би чадна” дасгал ажлын дэвтрийг ажиглуулан номын нүүр, хавтас, нуруу, хуудас нь аль болох, гарчиг, таних тэмдэг, зураг, дугаар зэргийг нэрлэж тайлбарлаарай, хавсралтаас номын хөтөч таних тэмдгийг хайчилж аваад хүүхэдтэйгээ хамтдаа ижилсүүлж тоглоорой.
3. Номоо үзэхийн өмнө гараа угаах, хуудсыг нугалж, урахгүй, хуруугаа норгож эргүүлэхгүй байх гэх мэтээр цэвэр нямбай, ариг гамтай хэрэглэхийг зааж өгөөрэй.
4. Та хүүхдэдээ өдөр бүр ном, тоглоомын багц дахь тоглоомоо ашиглан суралцана, тоглоно гэдгийг хүүхдэдээ тайлбарлаарай.
5. Номыг газар тавьдаггүй, дээгүүр нь гишгэх юмуу алхдаггүй, номоор гал ноцоохыг цээрлэдэг, хүн ном дурсгавал хоёр гардан хүндэлж аваад духаа хүргэж адис авдаг, энэ нь “Номын буян их, надад шингэх болтугай” гэсэн хүндэтгэх сэтгэл гэсэн ардын эрхэм ёсыг тайлбарлан ойлгуулж үлгэрлээрэй.

**Дасгал 2.**

Хүүхдэд дасгалыг гүйцэтгэхийг заасан таних тэмдгүүдийг сайтар тайлбарлан өгч нүдлүүлээрэй.

	<p>Асууж ярилцах, турших дасгал</p>
	<p>Зүйр цэцэн үг, ерөөл магтаал, оньсого, үлгэр, зохиолтой танилцах дасгал</p>
	<p>Тоолох, хэмжих дасгал</p>
	<p>Зурах, будах, зохион бүтээх, шавраар урлах дасгал</p>
	<p>Тоглоом, дасгал хөдөлгөөн</p>
	<p>Сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх дасгал</p>

**САНАМЖ**

- Та хүүхэдтэйгээ эелдэг, найрсаг харилцаарай.
- Номын хөтөч зургийг ажиглуулан тогтоолгоорой.



## НОМЫН ХАВЧУУРГА

### Зорилго:

- Хүүхэд номын хавчуургыг бүтээх, ашиглаж сурах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- 5x25 см хэмжээтэй туузан цаас 1 ширхэг цаас
- Бичгийн болон өнгийн цаас
- Цавуу, хайч

### Дасгал 1.

1. Та хүүхдээр зураг дээрх номын хавчуурга хийх аргачлалыг ажиглуулаад ярилцаарай.
2. Аргачлалын дагуу номын хавчуурга бүтээхэд туслаарай.

### “Номын хавчуурга” хийх дараалал

Өнгийн цаасыг захаас нь нугалан 5x25 см хэмжээтэй хайчилж, туузан цаас бэлтгэнэ. Энэ нь номын хавчуурга болно.

- Бэлтгэсэн туузан цаасан дээрээ 3 см-ын диаметртэй дугуй дүрсийг хүүхдээр хайчлуулж, доош нь цувуулан багтах хэмжээгээр нь наалгана.
- Эцэг эхчүүд нь хүүхдийнхээ хийсэн “Номын хавчуурга”-ыг скочдон бүрж, бат бэх болгож өгнө.
- Хийсэн номын хавчуургаа ашиглаж, нэрлэсэн номын хөтчийн дүрсийг олж тоглоно.

Зураг дүрсээр чимэглэхэд тусалж өгөөрэй. Хүүхдээр номын хавчуургыг яаж хийсэн тухай нь яриулж, магтан урамшуулаарай.

### Дасгал 2.

1. Хүүхэд хийсэн номын хавчуургаа ашиглаж нэрлэсэн номын хөтчийн дүрсийг олж тоглоно.
2. Номын хавчуургыг хэрхэн ашиглах аргад суралцана.

### САНАМЖ

- Номыг гартаа зөв харуулж барих, хуудсыг эхнээс нь нэг нэгээр нь эргүүлж үзэх, нойтон, хиртэй гараараа номоо барихгүй байх, хавчуурга хэрэглэж хэвшүүлээрэй.
- Хүүхдийн хийсэн “Номын хавчуурга”-ыг хатуу картонон цаасан дээр нааж өгвөл бат бэх болохыг анхаараарай.

## ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ

### Зорилго:

- Хүүхэд хичээлийн хэрэглэлтэй танилцах, зориулалтаар нь хэрэглэх
- Хүүхэд хичээлийн хэрэглэлийг ялгах, ангилах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хавсралт - Наадаг зураг №1
- Ном, тоглоомын багц
- Цүнх, өнгийн ба балын харандаа, харандаа үзүүрлэгч, пламастр, зургийн дэвтэр, өнгийн цаас, хайч, цавуу, шугам, усан будаг (хуурай шахмал, шахдаг 2 төрөл) бийр (бөөрөнхий, хавтгай 2 төрөл), баримлын шавар, хулдаас, шавар зүсэгч, савх

### Дасгал 1.

1. Та хүүхдээр хичээлийн хэрэглэлийг нэрлүүлээрэй.
2. Хичээлийн хэрэглэл тус бүрийн үүрэг, зориулалт, яаж хэрэглэдэг тухай ярилцаарай.
  - Балын харандаа ба пламастраар цаасан дээр зуруулж ялгааг тайлбарлуулах;
  - Зургийн дэвтэр номтой адил хавтас, хуудастай байдаг тухай танилцуулах;
  - Зургийн дэвтрийн эхний хуудаснаас эхлэх, дунд нь хуудас үлдээхгүй байх зэргээр хэрхэн ашиглахыг тайлбарлах;
  - Хичээлийн хэрэглэлийг цүнхэнд эмх цэгцтэй хийлгэж хэвшүүлээрэй.

### Дасгал 2.

1. Хүүхдээр дасгалын зургийг сайтар ажиглуулаад, хичээлийн хэрэглэлд хамааралтай болон хамааралгүй зургийг нэрлүүлээрэй.
2. Хавсралтад байгаа наадаг зурагнаас шар дугуй дүрсийг сонгон авч хичээлийн хэрэглэлд хамааралгүй зургийн дэргэдэх дугуй дүрс дотор наах, яагаад шар өнгийн дугуй дүрсийг наасан тухай асууж ярилцаарай.

### САНАМЖ

Дасгал ажлын дэвтэр, ном, тоглоомын багцаа өдөр бүр ашиглан шинэ зүйлд суралцана гэдгийг ойлгуулаарай.

## ХАРАНДАА

### Зорилго:

- Гар хурууны хөдөлгөөнийг сайжруулах дасгал хийх, хүрэнээс гаргахгүй зурах, будах
- Харандааг зөв барьж сурах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №1 - Харандаа барих (зохиомж)
- Харандаа барих аргачлал
- Харандаа үзүүрлэгч
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Зургийн дагуу гарын дасгалыг хамтдаа хийгээрэй.
  - A. Бүх хуруугаа нийлүүлэн бариад дараа нь зэрэг салгаарай.
  - B. Долоовор болон дунд хуруугаараа ширээн дээгүүр алхах мэт хөдөлгөөн хийгээрэй.
  - V. Жижиг бөмбөлгийг хуруугаараа өнхрүүлээрэй.
  - Г. Хуруугаа нэг нэгээр нь ээлжлэн салгаарай.
2. Цахим сургалтын хэрэглэгдэхүүн болон зургийг ажиглуулж, харандааг яаж барихыг ярилцаад зөв бариулж сургаарай.
  - A. Эрхий, долоовор хуруу тэнийн бусад гурван хуруу нугаларч дугуйрсан байна.
  - B. Эрхий, долоовор хурууны завсар харандааг хавчиж барина.
  - V. Эрхий хурууг харандааны зүүн талд тавина (Хэрэв солгой бол харандааны баруун талд тавина). Дунд хурууны эхний үе дээр харандаа байрлана. Долоовор хуруугаар харандааг дээрээс нь түшиж барина.
  - Г. Харандааг налуу байрлалаар хэт чанга биш сулавтар барина.

### Дасгал 2.

Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг аргачлалын дагуу будах

### Дасгал 3.

Харандаа үзүүрлэх

### САНАМЖ

- Харандааг амандаа хийхгүй байхыг сануулаарай.
- Зөв бариулж сургаарай.

## ӨНГИЙН ХАРАНДАА

### Зорилго:

- Хүүхэд шүлэгнээс өнгийг нэрлэх, шүлгээ цээжлэх
- Хүүхэд цэгийг холбож зурах, зургаа будах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн харандаа, харандаа үзүүрлэгч

### Дасгал 1.

1. Дараах шүлгийг уншиж өгч, ярилцаад тогтоолгоорой.

*Г.Нямаа*

### ӨНГИЙН ХАРАНДАА

Урт автобусыг  
Улаанаар зурлаа  
Хөнгөн тэргийг  
Хүрнээр будлаа  
Ачааны машин  
Ногоон билээ  
Аавын барьдаг  
Хар байлаа  
Сүүний машиныг  
Шараар зурлаа  
Хүүхдийн тэргийг  
Хөхөөр будлаа

Харин тэгтэл  
Нэг юм дутлаа  
Хамгийн чухлыг  
Мартсан байлаа  
Цагаан будгаар  
Зуръя гэтэл  
Цаасан дээр минь  
Тодрохгүй байлаа  
Ээжээ та  
Хар цаас өгөөч  
Эмнэлгийн машин  
Зуръя гэлээ.

### Дасгал 2.

Шүлэгт гарсан тээврийн хэрэгслийг цэгээр холбож зураад, өнгийн харандаагаар будуулаарай.

### Дасгал 3.

Харандаагаа үзүүрлээрэй.

### САНАМЖ

- Харандааг амандаа хийхгүй байхыг сануулаарай.
- Усан будгаар зурахдаа усаа тохируулж найруулахыг зөвлөөрэй.

**Зорилго:**

- Хүүхэд дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг нэрлэх, таних, ялгах
- Дүрсээр эд зүйлс бүтээж тоглох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хавсралт - Наадаг зураг №2
- Савх 20 ширхэг
- Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсүүд
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

1. Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг танилцуулах
2. Эцэг эхчүүд бэлтгэсэн дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсүүдээ давхцуулан ажиглуулж, хүүхэдтэй онцлогийг судлан ярилцана (Өнхрүүлэх, өнцгийг тоолох... гэх мэт).

**Дасгал 2.**

1. Та хүүхдээр зургийг ажиглуулж, нэрлүүлээд ямар дүрстэй адил төсөөтэйг яриулаарай.
2. Зурагтай адил төстэй дүрсийг хавсралтад байгаа наалддаг зураг №2 –оос авч дөрвөлжин нүд дотор наагаарай. Тухайлбал: Өнхрүүшийн зургийн доорх дөрвөлжин нүд дотор дугуй дүрс наах гэх мэт.

**Дасгал 3.**

Та хүүхдээр зураг дээрх байшин, гэр, майхан, хашаа, цонхыг ажиглуулж, савхаар дүрслүүлээрэй.

- Тэдгээрийг хэдэн савхаар бүтээсэн байгааг тоолуулна.
- Хүүхдээр савхаар дүрсэлж болох зүйлсийг бүтээлгэж, яриулна.

**САНАМЖ**

- Та дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсүүдийг хатуу (картон) цаасаар хийж, урьдчилан бэлтгээрэй.
- Савх нь хүүхдийн гар хурууны жижиг булчинг хөгжүүлж, бичиж сурах бэлтгэл болдог тул байнга тоглуулаарай.

## МИНИЙ ТАНИЛЦУУЛГА

### Зорилго:

- Хүүхэд өөрийгөө танилцуулах, зурах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цаас, балын болон өнгийн харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхдэдээ “Билгүүн хүү”-гийн өөрийгөө хэрхэн танилцуулсныг зургийн дагуу дараах дараалал, загвараар уншиж ярьж өгөөрэй.
  - Энэ бол би. Намайг Баатарын Билгүүн гэдэг.
  - Би 5 настай, эрэгтэй
  - Би туулай жилтэй.
  - Би аав, ээж, ахтайгаа дөрвүүлээ амьдардаг.
  - Миний аавыг Баатар, ээжийг Цэцэг гэдэг.
  - Харин энэ бол миний ах Дөлгөөн.
  - Би машин, шагай, бөмбөгөөр тоглох дуртай.
  - Миний хамгийн дуртай хоол бол бууз.
  - Би цагаан өнгийг илүү сонирхдог.
  - Би “.....”, “.....” хүүхэлдэйн кинонуудад дуртай.
  - Би ахтайгаа телевизийн “.....” нэвтрүүлгийг сонирхон үздэг.

### Дасгал 2.

“Би” сэдвээр өөрийгөө зурах

## МИНИЙ ТАНИЛЦУУЛГА

### Дасгал 3.

Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой.

*Ж.Дашдондог*

#### БИ

Би хоёр нүдтэй  
Хараа сайтай  
Хоёр нүдтэй  
Тэртээх барааг айлын өвөөд  
Тэрхэн дор нь ялгаад хэлнэ.  
Тэвнийг эмгэнд, зүүг эгчид  
Түргэн дор нь сүвлээд өгнө.  
Энэ  
Хэний нүд вэ?  
Хэний ч гэж дээ  
Миний л нүд дээ...

#### САНАМЖ

- Та хүүхдийн биеийн өндөр, жинг намар, хавар, төрсөн өдрөөр нь хэмжиж, зурагт хуудас дээр тэмдэглээрэй.
- Өмнөхөөсөө хэр өсөж том болсныг нь хэлж өгөөрэй.

ӨДӨР

8

БИ

### Зорилго:

- Хүүхэд хүмүүсийн сэтгэл хөдлөлийг нүүрний хувирлаар таних, ялгах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа

### Дасгал 1.

1. Зургийг ажиглуул. Аль нь инээн баярлаж, уурлаж, айж, гайхаж, дуулж, уйлж байгаа дүр болохыг ялгуулаад, ямар үед ийм сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлдгийг ярилцаарай.
2. Инээн баярлаж, уурлаж, айж, гайхаж, дуулж, уйлахад хүний нүд, хөмсөг, ам, хамар хэрхэн өөрчлөгддөгийг ажиглуулаарай.

### Дасгал 2.

1. Хүний нүүрний хувирлыг олон хувилбараар зуруулаарай.

### Дасгал 3.

“Би” шүлгээ уншиж, бататгаарай.



**Зорилго:**

- Хүүхэд гар угаах дарааллыг мэдэх, зөв дарааллаар угааж хэвших

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №7 “Гараа угаана даа” дуу
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

Хүүхдээр зургийг сайтар ажиглуулж, нэрлүүлээрэй. Хооллохын өмнө, тоглож наадах, бие зассаны дараа, хурга, ишиг зэрэг мал амьтанд хүрсний дараа, гэр, хашаа хороогоо цэвэрлэж, аав ээждээ тусалсны дараа гараа яагаад заавал угаах тухай ярилцаарай.

**Дасгал 2.**

Хүүхдээр зургийг ажиглуулж, гар угаах арга, дарааллыг ярилцаарай. Аргачлалын дагуу гараа угааж үзүүлээд, хүүхдээр дагуулан хийлгээрэй. Хэрхэн угааж байгааг ажиглаж, туслаарай.

**Дасгал 3.**

Дараах дууг сонсгоод зааж сургаарай. Бичлэгийг давтамжтай сонсгож утга санааг нь ярилцаарай. Дууны үгийг мөр мөрөөр, бадаг бадгаар нь зөв, тод хэлж цээжлүүлнэ.

*Үг З.Болдбаатар*

*Ая Ч.Алтансүх*

**ГАРАА УГААНА ДАА**

Өглөө босоод гараа угаана даа  
 Өнгийн савангаар хөөсрүүлж үрнэ дээ  
 Цэцэрлэгт очоод гараа угаана даа  
 Цэвэрхэн гартай цайгаа ууна даа  
 Халтар гар муухай шүү  
 Хавийн хүүхдүүд шоолно доо  
 Бохир гар заваан шүү  
 Бушуу түргэн угаая даа  
 Цэвэрхэн гоёхон гартай  
 Сэргэлэн багачууд хөөрхөн дөө  
 Үргэлж гараа угаадаг  
 Үеийн найзууд сайхан даа  
 Багшийн зааснаар гараа угаана даа  
 Бие засаад дахиад угаана даа

## ЦЭВЭР ГАР

Тоглоом тоглоод гараа угаана даа  
 Тойрч ширээндээ хоолоо иднэ дээ  
 Халтар гар муухай шүү  
 Хавийн хүүхдүүд шоолно доо  
 Бохир гар заваан шүү  
 Бушуу түргэн угаая даа  
 Цэвэрхэн гоёхон гартай  
 Сэргэлэн багачууд хөөрхөн дөө  
 Үргэлж гараа угаадаг  
 Үеийн найзууд сайхан даа  
 Унтаж босоод гараа угаана даа  
 Шингэн савангаар хөөсрүүлж үрнэ дээ  
 Хичээл давтаад гараа угаана даа  
 Гэртээ очоод дүүдээ заана даа  
 Халтар гар муухай шүү  
 Хавийн хүүхдүүд шоолно доо  
 Бохир гар заваан шүү  
 Бушуу түргэн угаая даа  
 Цэвэрхэн гоёхон гартай  
 Сэргэлэн багачууд хөөрхөн дөө  
 Үргэлж гараа угаадаг  
 Үеийн найзууд сайхан даа

## МЭДЭЭЛЭЛ

Хумсаа идэх, мэрэх нь 5 хүртэл ба түүнээс дээш насныханд өөртөө итгэлгүйн улмаас гол төлөв үүсэж тохиолддог үзэгдэл. Дүүгээсээ ээж, ааваа харамлах, дарангуйлал, дэндүү төгс байдлыг шаардах, салах, хагацах, найз нөхөд дундаа таарамжгүй байх гэх зэрэг сэтгэл санааны хямралтай холбоотой.

Хүүхэд тайвшрахын тулд хуруугаа хөхдөг хэдий ч нөгөө талаараа удаан хугацаанд ганцаараа байх, гэрийн тухгүй орчин, хэн нэгнийг дуурайх зэрэг тавгүй байдлын илэрхийлэл юм.

**Авах арга хэмжээ:**

- Хүүхдэд сатаарах өөр зүйл олж өгөх, тавгүйтүүлэх орчноос хол, тайван байлгах;
- Хумсаа идэх, мэрэх, хуруугаа хөхөх нь эрүүл мэндэд хортойг ойлгуулах;
- “Хумсаа идэхээ боль”, “Гараа амнаасаа ав” зэрэг үгийг хэлэхгүй байх;
- Хумсаа идэж, мэрж, хуруугаа хөхөж байгаа үед нь анхаарлыг өөр зүйлд хандуулах (Нэг аяга ус аваад ир. Тэр тоглоомыг аваад ир.) зэргээр ажиллах нь чухлыг анхаараарай.

## ТОО ТООЛОЛ

### Зорилго:

- Хүүхэд 5 хүртэл эд юмс, тоглоомоо оноож тоолох, 1-5 тооны цифрийг таних, ялгах
- Хүүхэд зургийг ажиглаж, аль нь хамгийн гол үүрэгтэй цоож болохыг олох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

- Та хүүхэдтэйгээ хамт гэртээ байгаа эд зүйлсийг оноож тоолоорой. Жишээ нь гэрт байгаа 5 аягыг эгнүүлж тавиад, тоолоорой.
- Хүснэгтэд цифртэй тохирсон дугуй дүрсийг зурж тоолоорой.

### Дасгал 2.

- Зураг дээр байгаа хэлхээтэй дөрвөн цоожны алийг нь онгойлговол бүгд салах вэ? Мөнхөө хүүд цоожоо онгойлгоход нь туслаарай.

### Дасгал 3.

- Ая Ч.Алтансүх “Гараа угаана даа” дууг давтах

### САНАМЖ

Хүүхдэд арван хоёр жилийн нэр, дарааллыг тогтоолгож тоглуулаарай.

## МАНАЙХАН

### Зорилго:

- Хүүхэд шүлэгт “үндэс, иш, мөчир” гэсэн үг ямар утгаар орсон тухай ойлгох, өөрийн гэр бүл дээрээ тайлбарлах
- Гэр бүлийн модоо бүтээж, тайлбарлаж танилцуулах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын болон өнгийн харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой. “Үндэс, иш, мөчир” гэсэн үгийн утгыг тайлбарлаарай.

## МАНАЙХАН

Өвөө эмээ минь үндэс юм  
 Аав, ээж минь иш юм  
 Эгч, ах, бид 3 мөчир юм  
 Хайртай гэр бүл минь  
 Мөнх байх мод юм

### Дасгал 2.

1. Дараах асуултын дагуу ярилцаарай.
  - Чи гэртээ хэн, хэнтэйгээ амьдардаг вэ?
  - Танай гэрийнхэн ямар ажил хийдэг вэ?
2. Гэр бүлийн зураг дээр хэн, хэн байна вэ? Зураг дээр хэн, хэнийг дүрсэлснийг ажиглуулж ярилцаарай.
3. “Гэр бүл”-ийн модыг бүтээж хэн, хэн хаана байгааг тайлбарлаарай.
4. Хүү (охин) -доо нэрийнх нь бэлгэдлийг ярьж өгөөрэй.

### Дасгал 3.

“Манай гэр бүл” сэдвээр зураарай.

## САНАМЖ

- Хүүхдийнхээ асуултыг анхааран сонсож хариулаарай.
- Хүүхэдтэйгээ идэвхтэй ярилцаарай.

## АЛУНГУА ЭХИЙН ДОМОГ

### Зорилго:

- Хүүхэд үлгэр домог сонсох, ярих, хүндлэх
- 1-5 цифрийг цэг холбож зурах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн болон балын харандаа

### Дасгал 1.

Дараах домгийг уншиж өгөөд ярилцаарай.

## АЛУНГУА ЭХИЙН ДОМОГ

Бидний өвөг дээдэс Чингис хааны өвөг Добумэргэний гэргийг Алунгуа гэнэ. Энэ эмэгтэй хүүхдүүддээ эвтэй явахыг сургасан нь монгол хүн бүрд сургаал болон үлджээ. Нэгэн өдөр Алунгуа эх таван хөвгүүнээ зэрэгцүүлэн суулгаж, хүн бүрд нэг сум мод (нарийн мөчир) өгөөд хугал гэжээ. Хөвгүүд тун амархан хугачиж орхив гэнэ.

Бас таван тийм модыг нийлүүлэн баглаад, хугал гэж өгвөл тэд тавуулаа дараалан оролдоод хугалж чадсангүй. Иймд Алунгуа эх:

“Та таван хөвгүүн хоорондоо эв муутай явбал тэр ганц, ганцхан сум мод мэт хүнд хялбар дийлэгдэнэ. Харин та нар эв эеэ нэгтгэвэл, тэр багласан сум мод мэт хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно.” гэж сургажээ.

### Дасгал 2.

Дасгалын зургийг ажиглуулан, юмсыг олон тооны нэрээр нэрлүүлээрэй. (Баглаа сум, баг тамирчид, салаа цэрэг, боодол лаа гэх мэт.)

### Дасгал 3.

Та хүүхдэдээ 1-5 тоог нэрлэж, цэгийн дагуу гүйцээж бичихэд туслаарай.

Хулан найздаа тоо заажээ.

Хонгороо найз нь сайн сурчээ.

Хоёр найзын сурсан тоог

Харин чи нямбай бичээрэй.

### САНАМЖ

- Эв зетэй байхын давуу талыг тайлбарлан ойлгуулаарай.
- Цифрийг зааврын дагуу цэвэр нямбай бичээрэй

**Зорилго:**

- Хүүхэд нүдээ хамгаалах аргад сурах
- Хүүхэд зөв ба хориглох тэмдэг тэмдэглэгээг хэрэглэх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

Хүүхдүүдийн юу хийж байгаа үйлдлийг ажиглуулаарай. Хориглох ба “зөв” тэмдгийг танилцуулаарай.

А. Зөв үйлдэлтэй зургийн дэргэдэх дугуй дүрсэнд “зөв” тэмдэглэгээг зурах


Б. Буруу үйлдэлтэй зургийн дэргэдэх дугуй дүрсэнд “хориглох” тэмдэглэгээг зурах

**Дасгал 2.**

Нүдээ хэрхэн хамгаалж болохыг асуугаарай. Хүүхэдтэйгээ хамт зааврын дагуу нүдний дасгал хийгээрэй.

**МЭДЭЭЛЭЛ**

Гэрийнхээ зай хэмжээнд тохирох телевизорыг сонгох нь чухал. 26 инчийн телевизорыг хамгийн ойрдоо 1 метрээс багагүй, холдоо 2 метрээс ихгүй зайнаас үзэхэд тохиромжтой.



## МИНИЙ НҮД

### Дасгал 3.

Хэл зүгшрүүлэх дасгалыг тайлбарлан хэлж, сурахад нь туслаарай.

Нүдний сормуус

Модны шилмүүс



### САНАМЖ

Элс, шороо, тоос зэрэг нь ихэвчлэн доод, дээд зовхинд ордог. Энэ үед нүдээ нухаж, арчиж хэрхэвч болохгүй. Гадны биетийг алчуур, хөвөнгөөр авах гэж оролдох бүр ч хэрэггүй. Хэрэв оролдсон тохиолдолд эвэрлэг бүрхүүл буюу нүдний гадна талын тунгалгийг гэмтээх аюултай. Үүний оронд хэдэн секунд нүдээ анивчихад нулимстай хамт гадагшилдаг.

**Зорилго:**

- Хүүхэд хүний яриа, амьтан, гол горхи, шувууд зэрэг байгаль орчны дуу чимээг сонсох, ялгаж нэрлэх, чимээг дуурайн дуугарах
- Хүүхэд зөв ба хориглох тэмдэг тэмдэглэгээг таних, ялгах, хэрэглэх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүний 5 дугаар бичлэг Ш.Цэнд-Аюуш “Чих” зохиомж
- Дуугардаг тоглоом, жижиг алчуур

**Дасгал 1.**

Та хүүхэдтэйгээ хамт дараах тоглоомоор тоглоорой.

**Чимээ чагнаа**

- Хүмүүс ярилцах, хурга, ишиг майлах, үнээ мөөрөх, нохой хуцах, шувууд жиргэх, бороо шаагих, салхи исгэрэх дуу чимээг нэрлүүлнэ.
- Дуу чимээ хаанаас сонсогдож байгааг асууж яриулна.
- Дараа нь хүүхдийн нүдийг алчуураар зөөлөн боогоод сандалд суулгаж, тоглоом, жижиг зүйлсийг дуугаргаж хаанаас ямар чимээ гарч байгааг заалгаж хэлүүлнэ.

**Дасгал 2.**

- Цахим сургалтын хэрэглэгдэхүүний 5 дугаар бичлэг Ш.Цэнд-Аюуш “Чих” зохиомжийг үзүүлж, ярилцаарай.

**Дасгал 3.**

Зургийг ажиглуулаад хүүхдүүдийн хийж буй үйлдэл зөв, буруу аль нь болохыг ярилцан хориглох ба зөв тэмдгийг зураарай.

**САНАМЖ**

- Нүд боож тоглох үед хүүхдийг сандал дээр суулгаарай.
- Хүүхэд дуугарч буй зүгийг зөв хэлж байгаа эсэхийг анхаараарай.



## МИНИЙ ШҮД

### Зорилго:

- Хүүхэд шүдээ угаах аргыг сурах, угааж хэвших
- Хүүхэд шүлгийн утгыг ойлгож цээжлэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №6 «Миний эрүүл мэнд»
- Шоо, хүү
- Оо, сойз, аяга
- Өнгийн харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Хүүхэдтэйгээ хамт “Шүдээ хамгаалцгаая” хөлөгт тоглоомоор тоглоорой. Хөлөгт шүдэнд сайн, муу зүйлсийг байрлуулна. Дараах зааврын дагуу тоглоно.

Шоо орхиод 6-ийн тоо буухаар тоглоомоо эхэлнэ. Шоогоо орхиод буусан нүдний тоогоор урагшаа нүүнэ. Шүдэнд сайн хүнсний зүйлийн зурагт буувал цэнхэр сумны дагуу нүд алгасч урагшилна. Харин шүдэнд хортой зүйлийн зураг дээр таарвал улаан сумны дагуу буцаж ухарна. Хорхой идсэн шүдний зураг таарвал өнжинө. Түрүүлж барианд ирсэн нь хожно.

### Дасгал 2.

“Шүд угаах аргачлал”-тай зургийг ажиглуулаад ярилцаарай. Цахим хичээлээ үзээрэй.

- Сойзоо доороос дээш угаана.
- Сойзоо шүдэндээ налуу байрлуулж дээрээс доош угаана.
- Сойзоо нааш цааш нь хөдөлгөж угаана.
- Сойзоо дээрээс нь доош хөдөлгөж угаана.
- Сойзоороо эргэлдэх хөдөлгөөн хийнэ.
- Сойзоо хөндлөн бариад нааш, цааш хөдөлгөж угаана.

### Дасгал 3.

Хүүхдэдээ шүлгийг уншиж өгөөд тогтоолгоорой. Байнга угааж арчилдаг хүүхдийн шүд эрүүл, цагаан харагдаж, инээхэд нь хамт инээж эзэндээ баярлаж байдаг гэх мэтээр шүлгийн утга санааг ярилцаарай.

Б.Пүрэвдолгор

**БАЯРЛАНА ДАА**

Сайхан цагаан шүдээ  
 Сайн гэгч нь угаалаа  
 Сайхан үнэртэй оогоор  
 Сойздон сойздон угаалаа  
     Инээхэд минь инээдэг  
     Ижилхэн цагаан шүд минь  
     Эзгий ааруул иддэг  
     Эзэн наддаа баярлана даа  
 Жижигхэн цагаан шүдээ  
 Жигдхэн сайн угаалаа  
 Жимсний амттай оогоор  
 Сойздон сойздон угаалаа  
     Идэхэд минь урамтай  
     Эрүүл цагаан шүд минь  
     Үргэлж арчилж байдаг  
     Эзэн наддаа баярлана даа

**МЭДЭЭЛЭЛ**

Шүдний оо авахдаа үүнийг анхаараарай.  
 Улаан тэмдэглэгээ = Байгалийн гаралтай+химийн элемент агуулсан.  
 Хар тэмдэглэгээ= Бүгд химийн элементээс бүтнэ.  
 Цэнхэр тэмдэглэгээ= Байгалийн гаралтай+эмчилгээний зориулалттай.  
 Ногоон тэмдэглэгээ= Байгалийн гаралтай бүтээгдэхүүнээр хийсэн.

## МИНИЙ ГАР, ХУРУУ

### Зорилго:

- Хялбар аргаар зурж, бүтээх
- Өөртөө үйлчлэх хөдөлмөр хийх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Будгийн харандаа, усан будаг, бийр, алчуур, ус найруулах сав
- Чулуу

### Дасгал 1.

1. Хүүхдээр зураг дээр өгөгдсөн мөр, толбыг ажиглаж цэг, шулуун, тахир, муруй зураасаар «амилуулан» мөр толбыг яаж уран зураг болсонг яриулаарай.
2. Гар, хөлийн дардсыг ашиглан янз бүрийн амьтны дүрс бүтээлгээрэй.

### Дасгал 2.

Та хүүхдэдээ гарын алчуурыг хэрхэн угаахыг биечлэн зааж, үзүүлж, дагуулан угаалгаарай. Хүүхэдтэйгээ гарын алчуур бохир байх эрүүл мэндэд хортой талаар ойлгуулж дараах чиглэлээр ярилцаж тайлбарлаарай.

- Бохир алчуураар өвчин дамжиж халдварлана. Хүн бүр өөрийн алчууртай байдаг.
- Гарын алчуурыг бохирдмогц угааж солих хэрэгтэй гэх мэт ярилцаарай.

Хүүхдэдээ хамрын алчуур угаасан дарааллаар гарын алчуурыг угаахыг сануулж хамтран угаагаарай.

### Дасгал 3.

Б.Пүрэвдолгор

### "БАЯРЛАНА ДАА" Шүлгийг давтаарай

#### МЭДЭЭЛЭЛ

1. Хүүхдийг заавал баруун гараараа зурж дүрслэхийг шаардах хэрэггүй. Хүний тархины баруун тал үнэрлэх, өнгө ялгаруулах болон харж мэдрэх гэх мэт үүргийг гүйцэтгэдэг байхад зүүн тархи ярих, бичих, тоо бодох, ойлгох, анализ хийх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Харин солгой хүмүүсийн баруун тархи илүү идэвхтэй ажилладаг. Тийм ч учраас тэдний дундаас ихэвчлэн жүжигчин, уран бүтээлч, зохиолч болон зураачид төрдөг байна.
2. Бохир алчуураар өвчин дамжиж халдварлана. Хүн бүр өөрийн алчууртай байдаг. Иймээс бусдын алчуур хэрэглэдэггүй тухай ярьж өгөөрэй.

## МЭНДЛЭХ ЁС

### Зорилго:

- Бусдыг хүндлэх, мэндлэх
- Өөртөө үйлчлэх хөдөлмөр хийх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хамрын алчуур
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Хүмүүсийн бие биенээ хүндлэн хайрлах нь мэндлэхээс эхэлдэг. Хүүхдэдээ хүмүүс өглөө бүр, өдөр болгон, уулзах бүртээ хоорондоо мэндэлж, хүндэтгэж байгаагаа илэрхийлдэг тухай дараах мэдээллийн дагуу ярьж өгөөрэй.

1. Дүү хүн ахмад хүнтэй уулзвал:

“Та сайн байна уу?” гэж мэндэлдэг.

2. Нэг хэсэг уулзаагүй бол:

- “Та амархан сайн байна уу?”, “Та амар амгалан байна уу?”
- Сайн байна аа. Амархан сайн байна уу?
- Сайн байна аа. Таны лагшин тунгалаг байна уу?
- Сайн байна аа. Сонин сайхан юу байна?
- Тайван сайхан байна аа.
- Таны ажил алба бүтэмжтэй сайн байна уу? гэж мэндэлдэг.

3. Хэрэв өдөр бүр уулздаг бол:

- “Тавтай нойрсов уу?”
- Тавтай унтлаа. Сонин сайхан юу байна?
- Тайван сайхан байна.
- Тавтай нойрсоорой.
- Баярлалаа. Та тавтай сайхан амраарай.

4. Дөрвөн улирлын байдлаар мэндэлбэл:

#### Хаврын улиралд:

Онд тарган орж

Сайхан хаваржиж байна уу?

#### Зуны улиралд:

Бие амар, сүрэг мэнд

Тавтай сайхан зусаж байна уу?

#### Намрын улиралд:

Мал сүрэг тарган тавтай

Сайхан намаржиж байна уу?

#### Өвлийн улиралд:

Өвөлжөө бууц дулаан

Өнтэй сайхан өвөлжиж байна уу?

**Дасгал 2.**

1. Хүүхдээр дасгалын зургуудыг ажиглуулаад нэрлүүлээрэй.

2. Хүүхэдтэйгээ монголчууд хүний үйлдэн бүтээж буй хөдөлмөрийг ерөөж, мэндчилэх ёстойг ярилцаж, хэлүүлж сургаарай. Жишээлбэл:

Сааль сааж байх үед:

- Үнээ сүүтэй болог
- Саасан сав дүүрэг!

Оёдол үйл хийж буй хүнд:

- Үйл бүт! Үйл уран болог!

Шатар, даам тоглож байгаа хүмүүст:

- Хожил хоёр тийшээ!

Эдгээр ерөөлийг хүлээн авч хариуд нь:

- Тэр ерөөл бат орших болтугай!  
Ерөөл шингэж байг гэх зэргээр хариу билэгддэг.

**Дасгал 3.**

Та дараах аргачлалын дагуу хамрын алчуурыг нь зөв эвхэж хэвшүүлээрэй.

- Алчуураа дэлгэж тавиад голоор нь тэнцүү нугална.
- Дахин голоор нь нугалж дөрвөлжин болгоно.
- Дээрх хоёр үйлдлийг давтан хийж, жижиг дөрвөлжин болгоно.
- Нугалсан алчуурын задгай хэсгийг нээж хамраа цэвэрлэнэ.
- Бохирдсон хамрын алчуурыг угаалгаарай.

**САНАМЖ**

1. Хүүхдээрээ мэндчилгээний үгийг дотно, итгэлтэй, тод өнгөөр, инээмсэглэн хэлүүлж сургаарай.
2. Та хүүхдийнхээ хамрын алчуур зөв хэрэглэхэд анхаараарай.
  - Өдөр бүхэн хамрын алчуурыг сольж, хэрэглүүлнэ.
  - Ханиах найтаахад бохирдсон гадаргыг дотор нь оруулан нугална.
  - Хамрын алчуурыг угаасны дараа заавал халуун индүүгээр индүүдэж хэрэглэнэ.
  - Алчуурыг халаас болон зориулалтын уутанд хийж хадгална.
  - Нусаа нийхдээ хүчтэй биш, хамрынхаа нүхийг ээлжлэн алчуураар зөөлөн дарж, нүдээ аних нь эрүүл мэндэд тустай.
  - Хамрын алчуураар амаа таглаж, хүнгүй зүг рүү харж ханиаж, найтаавал зохино.

## МИНИЙ АЯГА

### Зорилго:

- Хүүхэд зургийг ажиглаж бусдаасаа ялгаатай байгаа зүйлийг олох, эд юмсын ерөнхий нэрийг мэдэх
- Хүүхэд аяганы шинж чанарыг нэрлэх, ялгах, шинжийг тоочин ярих

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. “Юу илүү байна вэ?” зургийг ажиглаж тэдгээрээс аль нь илүү байгааг олоод балын харандаагаар тойруулан зураарай. Үлдсэн зургуудыг «Хоол цайны хэрэгсэл» гэж нэрлэдгийг хэлж өгөөрэй.
2. Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой.

#### Аяга

Шаазан аяга

Цавгүй аяга

Цагаан өнгөтэй

Цэвэр аяга

Бор өнгөтэй

Бөмбөгөр аяга

Хоол аягалахад

Сайхан аяга

### Дасгал 2.

- Аяганы хээг гүйцээж зуруулаарай.
- Хүүхэдтэйгээ хамт дараах загвараар үг баяжуулан тоглоорой.
- Шаазан аяга, төмөр (алт, мөнгө, зэс, гууль, хөнгөн цагаан) аяга, модон аяга, хуванцар аяга, шилэн аяга, цаасан аяга, чулуун аяга гэх мэт.

## МИНИЙ АЯГА

### Дасгал 3.

1. Бохирдсон аягыг угаах ажилд оролцуулаарай.

Хүүхдэд аягатай холбоотой цээрлэх ёсыг зааж сургаарай. Зочинд амсар нь эмтэрхий аяганд цай хийж барих, цай идээ барихдаа амсрыг нь хуруугаараа дарах, бялхаах, асгаж цутгах, харшуулан дуугаргах, зориуд хагалах, шавхруу үлдээх, аяганы амсар зуух, аягалж өгсөн цайг амсахгүй тавих, аягандаа савх хатгаж тавих, аягатай хоолоо зайлж уух гэсэн цээрлэх ёсыг тайлбарлаж өгнө.

### САНАМЖ

Хүүхэдтэйгээ аяганы адил тоглоом, хувцас, хичээлийн хэрэглэлийн тухай ярилцаж, хүүхдийн үгийн нөөцийг нэмэгдүүлэн, ярих чадварыг дэмжээрэй.

## МИНИЙ ТОГЛООМ

### Зорилго:

- Хүүхэд хөлөгт тоглоомоор наадахдаа тоглох дүрмийг мэдэх, баримтлах, хожил хожигдлыг ойлгож ухаарах
- Хүүхэд 6-9 хүртэлх цифрийг таних, бичих

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Тоглоомын хөлөг, шагай

### Дасгал 1.

Та хүүхэдтэйгээ хамт дараах тоглоомоор тоглоорой.

#### Унага

(Хөлөгт тоглоом)

#### Тоглоомын хэрэглэгдэхүүн:

- Есөн буудалтай хөлөг
- Дөрвөн хар, дөрвөн цагаан шагай

#### Тоглоомын дүрэм:

- Хэн түрүүлж эсрэг талаа нүүдэлгүй болгож хаасан буюу жиргэсэн нь хожно.

#### Тоглоомын явц:

Хоёр тоглогч есөн буудалтай хөлөг дээр дөрвөн цагаан, дөрвөн хар унага барьж наадна. Тоглогчид дөрөв, дөрвөн унагаа хөлгийн сул буудалд хар цагаанаар нь ээлжлэн байрлуулж дуусаад шулуун зураас буюу зэлний дагуу сул буудалд ээлжилж нүүнэ. Хэн түрүүлж өөрийн унагыг жиргэсэн, эсвэл эсрэг талаа нүүдэлгүй болгож хаасан нь хожно. Шулуун зураас буюу зэлний дагуух гурван буудалд ижил зүсмийн унага тавихыг жиргэх гэнэ. Тоглохоос өмнө жиргэж хожилцох уу эсвэл хааж хожилцох уу гэдгээ тохиролцож тоглоно. Дөрвөн цагаан, дөрвөн хар унагыг шагайгаар төлөөлүүлэн тоглож болно.

### Дасгал 2.

Та хүүхдэдээ 6-9 тоог нэрлэж, цэгийн дутууг гүйцээж бичихэд туслаарай.



**МИНИЙ ТОГЛООМ****Дасгал 3.**

Та хүүхдэдээ 6-9-ийн цирфийг хэлж өгөөд, гүйцээлгэн бичүүлээрэй.

Хулан найздаа тоо заажээ

Хонгороо найз нь сайн сурчээ

Хоёр найзын сурсан тоог

Харин чи нямбай бичээрэй.

**САНАМЖ**

Найзтайгаа хамтдаа тоглоомыг дүрмийн дагуу зөв тоглохыг нь дэмжээрэй.

## МИНИЙ ХУВЦАС

### Зорилго:

- Хүүхэд эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хувцсыг ялгах, хүүхдүүдийн хувцсыг тохируулж наах
- Хүүхэд хөлийн өлмий, өсгийгөөр ээлжлэн товших, хоёр хөлийг зэрэг дэвсэх хөдөлгөөн хийж, хөгжмийн аялгуунд бүжиглэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Наадаг зураг №3
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №9 - Товшоо дуу

### Дасгал 1.

Зургийг ажиглуулан ярилцаарай. Зурган дээрх хоёр хүүхдэд юу хэрэгтэй байгааг олж, хавсралт наадаг зураг №3-аас сонгож тохирох газар нь наагаарай.

### Дасгал 2.

Та доорх хувцасны зургийг ажиглуулж тоолуулаарай. Дүн тоотой тохирох цифрийг ижил өнгөөр будуулаарай.

### Дасгал 3.

Хүүхэдтэйгээ хамтран дараах хөгжимт хөдөлгөөнийг аргачлалын дагуу хийгээрэй.

#### Товшоо

(Хөгжимт хөдөлгөөн)

Та хүүхдэдээ аргачлалыг тайлбарлан өгч биечлэн хийж үзүүлээрэй. Дараа нь хуурцаг дээрх бичлэгийг дуурайн хийгээрэй.

#### Аргачлал:

Хоёр гарыг ташаанд авч цэх зогсоно. Хөгжмийн аянд хөдөлгөөнийг дуурайн хийнэ.

- Өсгий – Баруун хөлийг хажуу тийш өсгийгөөр тавина.
- Өлмий – Өсгийгөөр тавьсан хөлийг бага зэрэг дээш өргөн өлмийгөөр тавина.
- Товш товш – Хоёр хөлийг ээлжлэн 1-2 тоонд дороо дэвсэнэ.
- Өсгий товш – Өсгийг газар тавьж, дараа нь хоёр хөлийг ээлжлэн 1-2 тоонд дороо дэвсэнэ.
- Өлмий товш – Өлмийг газар тавьж, дараа нь хоёр хөлийг ээлжлэн 1-2 тоонд дороо дэвсэнэ.

## МАНАЙ ҮНДЭСНИЙ ХУВЦАС

### Зорилго:

- Хүүхэд дууг хөдөлгөөнтэй дуулах
- Хүүхэд монгол үндэсний хувцсаа таних, нэрлэх, ялгах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр

### Дасгал 1.

1. Та хүүхдэдээ “Манай хувцас” дуут бүжгийн бичлэгийг үзүүлж, хэрхэн бүжиглэж байгааг ажиглуулж, ярилцаарай. Хүүхэд бүжгийг дагаж хийхийг дэмжиж, бичлэгийг олон дахин үзүүлээрэй.

2. Бүжгийн бичлэгийг үзүүлэх боломжгүй бол дасгалын зураг дээрх бүжгийн хөдөлгөөнийг тайлбарлаж олон удаа давтаж хийлгээрэй.

*Үг, ая Д.Ичинхорлоо*

#### Манай хувцас

Бөмбөрцөг дэлхий хэлбэртэй  
Бүслүүр хавчаар тохирсон  
Бөөрөнхий дугариг тоорцог  
Толгой дээрээ дэгжин  
Мяндсан дурдан бүсээ  
Маягийг нь олж ороох нь  
Мянга олны үзэсгэлэн  
Манай монголын заншил  
Эцэг өвгөдийн хувцас  
Эрүүвчин захтай дээл  
Эргэн тойрон мөшгөөд  
Элбэг баян хувцас

### Дасгал 2.

Монгол үндэсний дээл, малгай, гутлыг олон хувцаснаас олоод дугуйлаарай.

**Зорилго:**

- Хүүхэд эцэг эхтэйгээ асуултын дагуу “Монгол дээл”-ийн тухай ярингаа шинэ үг тогтоох
- Монгол хүмүүс шинэ дээлээ мялааж ерөөдөг үгийг тогтоох, утгыг нь ойлгох, мялаалга үгийг уран унших

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №8- Дээлийн мялаалга ерөөл
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

Та дараах асуултын дагуу монгол дээлийн талаар ярьж, тодорхойлон яриулаарай.

- Ямар өнгөтэй дээл байна вэ?
- Ямар материалаар хийсэн бэ?
- Ямар, ямар хэсгээс бүтсэн байна вэ? (Дээлэнд зах, энгэр, урд, хойд, дотоод хормой, ар, ханцуй, нударга байдгийг нэрлүүлээрэй.)
- Хэний дээл бэ?
- Ямар улиралд өмсөхөд тохиромжтой вэ?
- Хэрхэн яаж өмсөх ёстой вэ?

**Дасгал 2.**

1. Дараах мялаалгыг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой.

**Дээлийн мялаалга**

Урд хормой дээр чинь  
 Унага, даага гишгэл  
 Хойд хормой дээр чинь  
 Хонь, хурга харайлга  
     Дотоод хормой дээр нь  
     Тос өөх наалд  
     Энгэр захыг нь  
     Эрдэм номоор мялаая  
 Эд нь хэврэг  
 Эзэн нь мөнх  
 Энэ жил даалимба  
 Ирэх жил чисчүү торго өмсөөрэй

2. Хүүхэдтэйгээ «Эд нь хэврэг, эзэн нь мөнх» гэсний учрыг тайлбарлан ярилцаарай.
3. Дээл бүсээ хэрхэн эвхэхийг зааж өгч, хамтарч эвхэж тавиарай.

### Дасгал 3.

Үг, ая Д.Ичинхорлоо “Манай хувцас” дууг давтаарай.

### САНАМЖ

- Шинэ үгийн утгыг тайлбарлаарай. Жишээлбэл: даалимба -нэгэн төрлийн даавуу, чисчүү - нэгэн төрлийн торго гэх мэт.
- Хүүхдэд монголчууд дээлээ дээдлэн, эвхэж дээш тавьдаг, бүсээ нар зөв тойруулан бүсэлдэг ёс заншлыг үлгэрлэн, зааж сургаарай.
- Дээл, хувцсаа эвхэж тавихыг хэвшүүлээрэй.

**Зорилго:**

- Хүүхэд зургийг ажиглаж юу нь ижил байгааг олох, будах
- Хүүхэд ариун цэвэр сахихын ач тусыг ойлгох, өөртөө үйлчлэх хөдөлмөрт оролцох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын болон өнгийн харандаа
- Хүүхдийн оймс, саван, ус, угаах сав

**Дасгал 1.**

Хүүхдээр хос оймсыг олж, будуулаарай.

**Дасгал 2**

Та хүүхдэд оймсоо хэрхэн угаахыг биечлэн зааж сургаарай.

1. Хөл, оймсоо тогтмол угааж, ариун цэврийг сахих нь эрүүл мэндэд тустай болохыг ойлгуулаарай.
2. Хүүхдэдээ өөрийнхөө оймсыг угаахад тусалж, угаах дарааллыг хэлж, дагуулан угаалгаарай. Тухайлбал:
  - Оймсыг гарын алган дээрээ тавиад, бага зэрэг савандана.
  - Дараа нь 2 гараараа хөөсрүүлэн үрж, хирийг нь арилгана.
  - Савандаж угаасан оймсыг цэвэр усаар булхан зайлж саванг арилгана.
  - Оймсыг сайтар мушгиж усыг шавхраад, дэлгэж хатаана гэдгийг зааж хийлгээрэй.

**САНАМЖ**

- Та хүүхдээрээ өөрийнх нь оймс, хамрын алчуур зэргийг угаалгаж байгаарай.
- Хүүхдийг цэвэрч нямбай байхад сургаж хэвшүүлээрэй.

## МИНИЙ ГУТАЛ

### Зорилго:

- Хүүхэд зохиолыг сонсох, өөрийн үгээр ярих
- Өөртөө үйлчлэх хөдөлмөр хийх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Гутлын загвар, үдээс

### Дасгал 1.

1. Зохиолыг уншиж өгөөд утгыг нь ярилцаарай.

*О.Цэндсүрэн*

### Гутал

Би хонхорт тогтсон усан дундуур гуталтайгаа тууллаа. Аав намайг дуудав. Гутлаа норголоо гэж загнах болов уу? гэж айсаар дэргэд нь очлоо. Аав огт зэмлэсэнгүй.

- За Доржоо хоёулаа үйлдвэр үзье гэхэд миний баярласныг хэлээд яах вэ. Би аавынхаа урдуур орж ямар үйлдвэр үзэх вэ гэхэд аав манайд гутлын үйлдвэр, гурилын үйлдвэр, хэвлэх үйлдвэр, төмрийн завод, тоосгоны үйлдвэр, цахилгаан станц, хүүхдийн хувцасны үйлдвэр, чихэр боовны үйлдвэр гээд л өчнөөн олон үйлдвэр бий. Хоёулаа өнөөдөр гутлын үйлдвэр үзье гэлээ. Бид хоёр эхлээд суурь машины дуу хүнгэнэсэн шир боловсруулах үйлдвэр үзэв. Арьс ширний үйлдвэрээс боловсруулан гаргасан ширээр энэ тасаг төрөл бүрийн гутал бидний хэрэглэдэг номын цүнхийг эсгэж байв. Өөр нэг тасагт гутлын түрий оёж байхад цаад тасагт нь уллаж байдаг ажээ. Бидний өмсдөг гутал ийм олон хүний гар дамжин бүтдэг байна гэж мэдэж авлаа. Аав бид хоёр гэр рүүгээ буцаж явлаа. Бидний замд зөндөө шалбааг тааралдав. Гэвч би усан дундуур гарсангүй.

Тайлбар: Аливаа хувцас үйлдвэрийн олон дамжлагаар бүтдэг, түүнд ажилчин хүн ажилладаг тухай мэдүүлж, хөдөлмөрийг хүндэтгэх үзэл төлөвшүүлнэ.

2. Та хүүхэдтэйгээ хамтран “Гутал”-ын төрөл нэрлэх тоглоомоор тоглоорой. Хүүхэд, ээж хоёр ээлжлэн хэлэх ба үг давтагдахгүй байхад анхаарна.

Жишээ үгс: Бойтог, буриад, зуны, өвлийн, хавар намрын, арьсан гутал гэх мэт.

**МИНИЙ ГУТАЛ****Дасгал 2.**

1. Дараах зургийн дагуу гутлаа үдэж сурахад нь туслаарай.

- Үдээсээ дээрээс доош, дороос дээш чиглэлээр, нүх үлдээлгүй үднэ.
- Үдээсний баруун талыг зүүн дээгүүр давуулан ороож дээш гаргана.
- Хоёр талыг битүү гогцоолдож бариад, баруун талыг зүүн дээгүүр давуулан ороож, үзүүрүүдийг татаж гаргалгүйгээр чангална.

Дээрх үйлдлийг сурснаар олон аргаар үдэж чаддаг болно.

**САНАМЖ**

- Хүүхдэдээ гутал гаднын шороо тоосонд дарагддаг, бохир зүйл дээр гишгэж байдаг тул гэртээ, ангидаа орж ирэнгүүт солих ёстойг хэлж хэвшүүлээрэй.
- Гутлаа цэвэрлэсний дараа гараа угаана гэдгийг хэлж зөвлөөрэй.



## ТОО ТООЛОЛ-2

### Зорилго:

- Хүүхэд тоглоом, эд юмсыг оноож тоолох, 1-9 хүртэл цифрийг бичих
- Хүүхэд шүлгийг цээжлэх, утгыг илэрхийлсэн хөдөлгөөнийг хийж, уран унших

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хавсралт - Наадаг зураг №4
- Өнгийн харандаа

### Дасгал 1.

Зургийг ажиглуулаарай. Бүжиглэж буй туулайнуудын тоотой тэнцүү лууванг хүснэгтийн дагуу хавсралтаас хайчилж, дэргэд нь наалгаарай.

### Дасгал 2.

Дүрсийг тоолоод 1-9-ийн цифрээс тохирохыг хүснэгтэд бичээрэй.

### Дасгал 3.

Дараах шүлгийг хүүхэдтэйгээ хамтарч уншаад, хөдөлгөөнийг хийгээрэй.

*Т.Жамьянсүрэн*

### Тоолж сурлаа

Тав хүртэл тоолж сурлаа  
 Таван хуруугаа  
 Нэрлэж тоглоё  
 Эрхий мэргэнийг нэг гэе  
     Долоовор хуруугаа хоёр гэе  
     Дунд хурууг гурав гэе  
     Ядам хурууг дөрөв гэе  
     Чигчий хурууг тав гэе  
 Таван хуруу ямар нэртэйг  
 Та нар цөм мэдэх нь энэ  
 Тав хүртэл тоолохыг  
 Дашрамд бас сурах нь тэр  
     Хуруугаа түргэн дараалж дараад  
     Хурдан зөв нэрлэж тоолцгооё

### САНАМЖ

- Хүүхдээрээ гарын алчуураа бохирдсон тухай бүрд нь угааж хэвшүүлээрэй.

## ЦЭВЭРЧ ХҮҮ

### Зорилго:

- Хүүхэд хувийн ариун цэврийг сахих, ач холбогдол, хор уршгийн тухай ярилцах
- Дуу дуулах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Хүүхдэдээ дасгалын 1, 2-р зургийг ажиглуулаарай.
2. Хоолоо идэхээр гэртээ орж ирсэн Болдоо, Батаа хоёрын үйлийг харьцуулан хэнийх нь зөв байгааг яриулаарай.
3. Хүүхэдтэй хамтран хооллох үед гэртээ баримтлах дүрмийг зохиогоорой.  
Тухайлбал:
  - Хоолны өмнө гараа савандаж угаах
  - Хоолны ширээ засах, хоол зөөхөд туслах
  - Хоолоо сайн зажилж, тайван хооллох
  - Хоолны аяга таваг хураах, угааж цэвэрлэх ажилд туслах гэх мэт.

### Дасгал 2.

Дараах дууг зааж хамтран дуулаарай. Дууны үгийг мөр мөрөөр, бадаг бадгаар нь зөв, тод хэлж цээжлүүлээрэй.

*Үг, ая Д.Хоролсүрэн*

#### Болохгүй

Гараараа идэж болохгүй шүү  
 Гадуур нь асгаж болохгүй шүү  
 Болохгүй, болохгүй шүү  
 Хуруугаараа идэж болохгүй  
 Хувцас руугаа асгаж болохгүй  
 Болохгүй, болохгүй шүү  
 Халбагадаад идвэл цэвэрхэн шүү  
 Хоолоо цэвэрхэн идэцгээ  
 Ля, ля, ля цэвэрхэн шүү

#### САНАМЖ

- Хүүхдэдээ хоолыг цэвэр нямбай идүүлж хэвшүүлээрэй.

## ТУСЧ ХҮҮХЭД

### Зорилго:

- Хүүхэдтэйгээ мэндлэх, талархах, хүндэтгэх, уучлалт хүсэх үгсийн тухай ярилцах, байнга хэлж хэвших
- Хүүхэд дууны утгыг ойлгон сонсож, даган дуулах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №10- «Тусч жаал» дуу
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхдэдээ, таны хүүхэд танд болон бусдад мэндлэх, талархал, хүндлэх, уучлалт хүсэх үгсийг хэлж хэвшсэн үү? гэсэн асуултыг өөрөөсөө болон хүүхдээсээ асууж ярилцаарай.
2. “Баярлалаа, уучлаарай” хөлөгт тоглоомыг тоглохдоо шоогоо орхиж, ямар зурган дээр бууснаас хамаараад талархлын эсвэл уучлалт хүсэх үгийг хэлнэ. “Баярлалаа, уучлаарай” гэсэн үгийг хэрэглээгүй тохиолдолд нэг алхам ухарч нүүнэ.
3. Хүүхдийг гэр ахуйн хөдөлмөрт оролцуулаад “хүү, охиндоо баярлалаа, гялайлаа”, “өндөр болоорой”, “тусч хүүхэд”, “эрдэмтэй хүн болоорой.”, “ажилсаг хүүхэд”, “ачтай сайн хүү” гэх мэтээр урамшуулж үлгэрлээрэй.

### Дасгал 2.

2.1. Дараах дууны бичлэгийг сонсгоорой. Дууг дахин давтан сонсгох, даган дуулуулах, хамт дуулах зэргээр зааж сургаарай.

Үг Т.Жамъянсүрэн

Ая Б.Цэнджав

#### Тусч жаал

Хөрш айлын өвөө маань  
Адуугаа хураагаад явж байна  
Хөөрхөн унагаа барихад нь  
Амдаж очоод тусална даа  
Өвгөн ааваас минь  
Өөрц юун  
Өвөө надад баярлана даа  
Сахалт айлын эмээ маань

**ТУСЧ ХҮҮХЭД**

Хувингаа бариад явж байна  
Саалийн үнээгээ саахад нь  
Тугалыг нь татаад тусална даа  
Эмгэн ээжээс минь  
    Ялгаа юун  
    Эмээ надад баярлана даа  
    Үеийн бяцхан нөхөд минь  
    Өндөр настанд туслаарай  
Өвөө эмээ хоёрт би  
Өөрийн хэрээр тусална даа  
Өвгөн ааваас минь  
Өөрц юун  
    Өвөө надад баярлана даа  
    Эмгэн ээжээс минь  
    Ялгаа юун  
    Эмээ надад баярлана даа

**САНАМЖ**

- Дууны үг, аялгууг зөв тогтоолгохын үндэс нь яаран дагаж дуулуулах биш, олон удаа, дахин давтан сонсгож, хүүхдийн чихэнд хоногшуулах явдал тул хэрэгжүүлээрэй.

## ЗАЛХУУ ХҮҮХЭД

### Зорилго:

- Хүүхэд эх зохиолыг сонсох, үйл явдлыг харуулсан зургийг ашиглаж ярих
- Хүүхэд хуруун хүүхэлдэйг хялбар аргаар хийж, жүжигчлэн тоглох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №13 - Ж.Дашдондог “Аргат бор” зохиол
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхдэдээ дараах зохиолыг уншиж өгөөрэй.

*Ж.Дашдондог*

#### Аргат бор

Нэг малчин айл байжээ. Тэднийх олон хүүхэдтэй юмсанжээ. Цөмөөрөө л ажилч хичээнгүй, харин хамгийн отгон нь нэлээд адтай аргатай жаал гэнэ. Тэгээд ч тэр үү, түүнийг Амарбаяр гэхээсээ Аргат бор гэлцэх нь олон. Нэгэн өглөө ээж нь:

- Сүү уух хүүхэд байна уу? гэхэд Аргат бор бусдаасаа түрүүлэн дуугарч:
- Би, Би! гэв.
- Өрөм, ааруул идэх хүүхэд байна уу? гэхэд Аргат бор бас л:
- “Би, Би” гэв.

#### Үд боллоо. Ээж нь хуушуур хайраад:

- Хуушуур хэн идэх вэ? гэтэл Аргат бор бусдаасаа урьтаж:
- “Би, Би” гэлээ.

#### Үдэш боллоо. Ээж нь тараг бүрээд:

- Хэн тараг уух вэ? гэтэл Аргат бор мөн л бусдаасаа өрсөж
- “Би, Би” гэв.

#### Унтахын өмнө ээж нь:

- Маргааш хэн хонины ээлжтэй билээ? гэтэл Аргат бор бусад руугаа харж:
- Ээжийн асуултад би л ганцаараа хариулаад байх юм. Бусад нь ганц ч гэсэн “Би, Би” гэхэд яадаг байна аа? гэтэл гэр дүүрэн инээлдэж гэнэ.

2. Зохиолын утга санааг харуулсан зургийн дагуу үйл явдлын дарааллаар нь яриулаарай.

## ЗАЛХУУ ХҮҮХЭД

3. Та хүүхэдтэй хамтран хийсэн хуруун хүүхэлдэйгээр “Аргат бор” зохиолыг хамтран жүжиглэн тоглоно.

- Хүүхэд хуруу гараа хөдөлгөж, дууныхаа өнгийг хувирган өгүүлж, сэтгэл хөдлөлтэй тоглохыг хэлж зөвлөөрэй.
- Та “Аргат бор”-ын ээжийн дүрээр хамтран тоглоно.

### Дасгал 2.

Та хүүхэдтэй хамтран хуруутай бээлий болон цаасаар хүүхэлдэй хийгээрэй.

#### Хуруун хүүхэлдэй

Цаасаар хуруун хүүхэлдэй хийх энэ арга нь хийхэд маш энгийн хялбар бөгөөд эвтэйхэн. Үүнийг хүүхдүүдтэйгээ хамтран хийхэд цаг ч бага орно. Хүүхэлдэйнүүдээ хүүхдүүдтэйгээ хамт тоглоход болон гэрийн театрт ашиглаж болно. Хүн, амьтан, шувуу, хүүхэлдэйн киноны баатар, тэр бүү хэл өөрсдийн зохиосон дүрдээ ч хувиргаж болох юм. Хүүхэлдэйн дүрсүүдийг зурж хайчлаад, хүүхдээр будуулаарай. Хүүхэлдэйгээ янз бүрийн зүйлсээр чимэглэж, харин үсийг ноосон утсаар хийж болно.



#### САНАМЖ

- Мал гэхээр манас гэх
- Мах гэхээр ухас хийх зүйр үгийн утгыг тайлбарлаарай.

## АЖИГЧ ХҮҮХЭД

### Зорилго:

- Хүүхэд зурагт юу дутуу байгааг олоод гүйцээж зурах
- Хүүхэд хүснэгт дэх цэгүүдийн байрлалыг ажиглаж тогтоох, тогтоосон цэгээ хүснэгтэд зурах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхэдтэйгээ зураг дээрх хүмүүст нэр өгөөд хэн ямар үйл хийж байгааг нэрлүүлээрэй.
2. Хүмүүсийн хийж байгаа үйлд дутуу зурагдсан зүйл байгаа эсэхийг асууж ярилцаарай. Жишээлбэл: Хурганы угж
3. Дутуу зүйлийг гүйцээн зурна.

### Дасгал 2.

Хүснэгтийн голд, зүүн дээд хэсэгт байрлах 4 цэгтэй 2 хэсэг зураг байна. Хүүхэд хүснэгтийг тус бүрийг 1 минут орчим хугацаанд ажиглана. Дөрвөлжин нүдэнд хэдэн цэг, хаана байрласныг анзаарч, сайн тогтоохыг сануулаарай. Тогтоосон цэгүүдийг хоосон хүснэгтэд дуурайлган зуруулахдаа ажигласан зургийг харуулахгүй байхад анхаарна уу.

### Дасгал 3.

Үг Т.Жамъянсүрэн, Ая Б.Цэнджав

### “Тусч жаал” дууг давтаарай

### САНАМЖ

- Хэрэв хүүхэд сайн тогтоогоогүйгээс болоод зурж чадахгүй бол 30 секунд харуулаад дасгалыг дахин хийлгээрэй.
- Сурах үйл ажиллагааны бүхий л хэлбэрүүд нь анхаарлын оролцоотойгоор явагдана.
- Энэ насны хүүхэд хурц өнгөтэй зүйлд анхаарлаа төвлөрүүлээд гол зүйлийг орхидог.

## ХОГ ХАЯГДАЛ

### Зорилго:

- Хүүхэд зураг харж, зохиож ярих, зохиолдоо нэр өгөх
- Хүүхэд байгаль орчинтой зөв зохистой харьцах, хогийг зориулалтын саванд хийх тухай ойлгох


### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хавсралт - Наадаг зураг № 5
- Цуврал зураг
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

- Цуврал зургийг хараад зохиож яриулаарай.
- Зохиолдоо ямар нэр өгөх тухай ярилцаарай.
- Хүүхдэд үйл явдал хэрхэн төгсөх тухай асууж, өөрөө бодох боломж өгөөрэй. Зохиолын төгсгөл хэсэг нь цэвэр, сайхан байгаль орчин байх ба хайрлах хамгаалах агуулгатай байх нь хамгийн чухал юм.

### Дасгал 2.

Аль хогийг ямар саванд хийх вэ? Тохирох зургийг хавсралтаас авч  дүрс дотор наагаарай.



## БОЛНО, БОЛОХГҮЙ ЗҮЙЛИЙН ТУХАЙ

### Зорилго:

- Хүүхэд “болно”, “болохгүй”-г мэдэх, зөв болон хориглох тэмдэглэгээг ялгах, тохируулж тэмдэглэх
- Хүүхэд эелдэг харилцааны үгсийг хэрэглэх, олон нийтийн газар баримталдаг дэг, дүрэм, журмыг мэдэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн харандаа

### Дасгал 1.

Та хүүхдэдээ найз нөхөдтэйгөө эвтэй тоглох, бусдаас тусламж хүсэхдээ эелдгээр гуйх, таньдаг хүмүүстэй инээмсэглэн мэндлэх, бусдын ая тухыг алдуулсан үед уучлал гуйх, хүмүүстэй хашгирч ярихгүй байх, хүмүүс рүү хуруу гараараа зангахгүй байх гэсэн зөв боловсон харилцааны талаар ярилцах, цэцэрлэг, сургууль гээд олон нийтийн газар биеэ зөв авч явах дэг, дүрэм, журам байдгийг таниулж ярилцаарай.

- Зургийг ажиглаад хүүхдүүдийн үйлдэл ямар байгааг асууж ярилцаарай.
- Хэн нь олон нийтийн газар мөрддөг дэг, дүрэм, журмыг сахиагүй, буруу үйлдэл хийж байгаа, хэн нь зөв үйлдэл хийж байгааг ялгаад дугуй дүрсэн дотор хориглох болон зөв тэмдэглэгээний аль тохирохыг зураарай.

### Дасгал 2.

Ж.Дашдондог “Аргат бор” зохиолыг давтаж, хийсэн хуруун хүүхэлдэйгээрээ тоглоорой.

## МИНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

### Зорилго:

- Хүүхэд аюултай зүйлээс болгоомжлох, хэрхэн аюулгүй харьцахыг мэдэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Зураг дээрх зүйлсийг ажиглуулж, нэрлүүлээрэй.
2. Хүүхдэдээ аюултай, болгоомжлох зүйлсийн талаар ярьж өгөх, учир шалтгаан, хэрхэн харьцахыг тайлбарлах. Хүүхдээр аюултай, болгоомжлох зүйлсийг дэргэдэх дүрс дотор (х) тэмдэг зуруулаад Яагаад? асуултын дагуу ярилцаарай.

### Дасгал 2.

Хүүхэдтэйгээ аюултай зүйлсээс хэрхэн болгоомжилж, өөрийгөө хамгаалах тухай ярилцаарай.

### САНАМЖ

- Халгай болон хортой ургамлаас болгоомжлохыг хэлж таниулаарай.
- Та хүүхдэдээ халуун зүйл, гал, цахилгаан хэрэгсэл, хурц иртэй зүйлсээс болгоомжлох тухай сануулаарай.

## МИНИЙ ХООЛ

### Зорилго:

- Хүүхэд хүнсний бүтээгдэхүүнийг бүлэг бүрээр нь төрөлжүүлэн ангилах, ерөнхий нэрийг хэлэх
- Хүүхэд энгийн хөдөлмөр хийх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Зурган карт, Хайчилбар №2
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхэдтэйгээ хамт гэр зөвлөмжийн хүнсний бүтээгдэхүүний зургийг харж ажиглуулан ярилцаарай. Олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэх нь хүний биед ач тустай гэдгийг тайлбарлаж хэлж өгөөрэй.
2. Хүнсний бүтээгдэхүүний ерөнхий нэрийг хэлж өгөөрэй.



### Дасгал 2.

Хавсралтаас бэлэн зургийг хайчилж аван гэр зөвлөмж дээр тохируулан наагаарай.

- Хүнсний ногоо
- Жимс жимсгэнэ
- Махан бүтээгдэхүүн
- Сүү цагаан идээ
- Талх нарийн боов

### Дасгал 3.

Хүүхдээ ногоо арилгах, угаах зэргээр гэр ахуйн хөдөлмөрт оролцуулаарай.

### САНАМЖ

- Муудсан ногоог хоолонд хийж болохгүйг мэдүүлээрэй.
- Буруу хадгалсан, муудаж, хуучирсан хүнсний бүтээгдэхүүн идэхгүй байхыг сануулаарайт

**Зорилго:**

- Хүүхэд асуултад бүтэн өгүүлбэрээр хариулах
- Хүүхэд баримлын шавраар тоглож, бүтээл хийх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Баримлын шавар, хутга, суурь хулдаас, алчуур
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

Та хүүхдээсээ дараах асуултыг асууж ярилцаарай. Хүүхдийг бүтэн өгүүлбэрээр хариулахад анхаараарай.

- Манайх гэртээ ямар, ямар хоол хийдэг вэ?
- Миний хүү/охин ямар хоолонд дуртай вэ?
- Чи хоол хийхэд яаж тусалдаг вэ?
- Бууз, хуушуурыг яаж хийдэг вэ?
- Миний хүү/охин бууз, банш чимхэж чадах уу?

**Дасгал 2.**

Буузыг аргачлалыг дагуу хамтран баримлаар хийгээрэй.

### Зорилго:

- Хүүхэд цаасыг тэгш хэмтэй нугалах, лууванг зурагт үзүүлсэн шиг зурж, зураасны дагуу хайчилж, наах
- Хүүхэд оньсого таах, гэээг, гэдэс гэдгээр юуг төсөөлүүлж байгааг ойлгож, тайлбарыг хэлэх
- Хүүхэд энгийн хөдөлмөрт оролцох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Улаан, улбар шар, ногоон өнгийн ам дөрвөлжин цаас
- Балын харандаа, цавуу, зургийн дэвтэр, хайч
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхдээрээ зураг дээрх аргачлалын дагуу «Лууван» наалгаарай.
  - Дөрвөлжин цаасны эсрэг хоёр ирмэгийг давхцуулан тэнцүү нугалуулна.
  - Битүү нугалаастай талд нь тал лууван зуруулна.
  - Зураасыг дагуулан хайчлаад дэлгэхэд бүтэн лууван гарна.
  - Луувангийн навчийг дээрх аргаар бэлтгэнэ.
  - Хаягдал өөдөс цаасыг ашиглан зүймэл наамал хийж болно.
  - Зүймэл наамал хийхэд эхлээд наах зүйлийнхээ дүрсийг зурна.
  - Хаягдал цаасыг жижиглэн урж бэлтгэнэ.
  - Дараа нь зургийг цавуудан дээр нь өөдөс цаасаа зургийн хүрээнээс гаргалгүй зүйж наана.

### Дасгал 2.

Оньсого таалгаж, тогтоолгоорой. Юуг “гэээг”, “гэдэс” гэж нэрлэсэн учрыг тайлбарлан ярилцаарай.

Гэээг нь ногоон

Гэдэс нь улаан тэр юу вэ? (лууван)

### Дасгал 3.

Хүүхдээр лууванг угааж, арилгах хөдөлмөр хийлгээрэй. Луувангийн амт, өнгө, үнэр, хэлбэр хэмжээний талаар ярилцаарай.

### САНАМЖ

- Хүүхэд хайчтай харьцах чадвар сул байдаг тул чихэр, жигнэмгийн боодол, уншсан сонин, сэтгүүл дээрх зургийн хүрээг дагуулан хайчлах дадлага хийлгээрэй.
- Хайчилсан зургаар нь наамал бүтээлгээрэй.

**БАЙЦАЙ****Зорилго:**

- Хүүхэд хүнсний ногоог оноож тоолох, дүн тоог хэлэх
- Хүүхэд харандааг зөв барих, хүрэнээс гаргахгүй будах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа

**Дасгал 1.**

- Эгнээ бүрд хэдэн ширхэг байцай, төмс, лууван ургасныг тоолуулан, дүн тоог хэлж бичүүлээрэй.
- Жаргал аав ээжтэйгээ хэдэн шуудай төмс, байцай, лууван хураасныг тоолуулж, дүн тоог □, ○ дүрсэн дотор бичүүлээрэй.

**Дасгал 2.**

Хүнсний ногоонуудыг будуулаарай.

**САНАМЖ**

- Хүрэнээс гаргалгүй будахыг сануулаарай.
- Хүүхдээр хүнсний ногоо зурах, шавраар барьж дүрслэх, хайчлан наах үйл хийлгээрэй.

**Зорилго:**

- Хүүхэд байрлал заасан үгийн утгыг ойлгох, эд юмсын байрлалыг нэрлэх
- Хүүхдийн үгийн баялгийг нэмэгдүүлэх

**Бэлтгэх зүйл:**


- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн харандаа

**Дасгал 1.**

Зургийг ажиглуулж амьтны байрлалыг дээр, доор, хажууд, ард урд, дотор завсар гэх мэтээр тодорхойлуулаарай.

**Дасгал 2.**

- “Жимс” гэдэг үгийг бусад тохирох үгтэй холбон баяжуулж тоглуулаарай.
- Жимсийг угааж, арилгаж хүнсэнд хэрэглэдэг тухай ярилцаарай.



**САНАМЖ**

- Өдөр тутмын ажил хөдөлмөрийн явцад хүүхдээр юмсыг аль нэгэн шинжээр адилтгах, бусдаас өөр зүйлийг нь ялгуулах, тоолуулах зэргээр ярилцаж байгаарай.

**Зорилго:**

- Хүүхэд эд юмсыг оноож тоолох, цифрт тохируулж, жимсийг наах
- Хүүхэд хэмнэлийг тодорхойлж сурах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Наадаг зураг №6
- Өнгийн харандаа
- Бөмбөр (Шилэн аяга), савх (халбага байж болно.)

**Дасгал 1.**

Та хүүхэдтэйгээ хамтран хавсралтаас авсан алим жимснүүдийг цифрт тохируулан нааж, наасан жимсээ тоолох үйлийг хамтдаа хийнэ.

**Дасгал 2.****Бөмбөрчин хүүхэд**

(Хөгжимт дасгал)

Зургийн дагуу хөгжмийн энгийн зэмсгээр тоглоно. “Алим” гээд баруун гараар бөмбөрөө цохиод, дахин “Алим” гэхэд зүүн гараар бөмбөрөө цохино. “Алимаа угаа” гэхэд 2 гараар зэрэг бөмбөрөө цохино. Дасгалын эхний хэсгийг бөмбөрөөр цохисон бол дараагийн хэсгийг савх болон халбагаар цохиж, төгсгөлд нь зэрэг дуугаргаж тоглож болно.

**САНАМЖ**

- Та хүүхдийнхээ ойлгохгүй байгаа үгийг тайлбарлан хэлж өгч байгаарай.



### Зорилго:

- Хүүхэд байгаль орчноо хайрлан хамгаалахад хүмүүсийн ямар үйлдэл болно, болохгүйг ялгах
- Хүүхэд орчны юмсыг ажиглаж, сонирхох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Хүүхдээр зургийг ажиглуулаарай. Хүмүүс юу хийж байгааг яриулна.
2. Зургийг ажиглуулаад “Болно”, “Болохгүй” үйлдлийг ялгуулаарай. “Болохгүй” үйлдлийн дэргэдэх дөрвөлжин нүдэнд “Х” хориглох тэмдэг тавиулаад учрыг ярилцаарай.
3. Хүмүүс хаанаас ус авдаг вэ? асуултаар булаг, гол горхи, нуур, худаг, цас, борооны усыг хэрэглэдэг тухай хүүхдээр яриулаарай.
  - Хүүхдэдээ усыг эрхэмлэн, бохир, сүүтэй шанага, саваар хутгах, гол горхины усанд хог хаях, хувцсаа угаахыг цээрлэдэг ардын зан заншлаас ярьж өгнө.
  - Усыг бохирдуулах, бохир ус хэрэглэх нь хүмүүс, амьтан, ургамалд хортой талаар ярьж ойлгуулна.

### Дасгал 2.

Хүүхдээр зургийг ажиглуулаад дараах асуултаар ярилцаарай.

- Хүүхдүүд юу хийж байна вэ?
- Танайх усыг яаж ашигладаг вэ? Усгүй бол яах вэ? гэх мэт.
- Зургийг ажиглуулаад “Болно”, “Болохгүй” үйлдлийг ялгуулаарай. “Болохгүй” үйлдлийн дэргэдэх дөрвөлжин нүдэнд “Х” хориглох тэмдэг тавиулаад учрыг ярилцаарай.

### Дасгал 3.

Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад тогтоолгоорой.

*А.Найгалмаа*

### Цасны ус

Өвөлтэй хамт  
Орсон цасыг  
Өвөртөө би  
Хийх гэтэл

Хайлж урсаад  
Ус болчихлоо  
Хачин юм аа  
Хачин юм

### САНАМЖ

- Усыг хайрлан гамтай хэрэглэх талаар ойлгуулж хамаагүй гоожуулж асгах, тоглох нь сайн биш гэдгийг хэлж өгөөрэй.

## ЦАГААН ИДЭЭ

### Зорилго:

- Хүүхэд шингэн зүйлийг аяга, халбагаар хэмжих
- Хүүхэд ээдэм хийх туршилт, энгийн хөдөлмөрт суралцах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Сүү, тараг
- Шанага, том, жижиг аяга, хоолны халбага

### Дасгал 1.

1. Хүүхдийн өмнө ширээн дээр том, жижиг аягыг тавьж өгнө. Савтай сүүнээс аяга тус бүрд сүүг дүүртэл хийлгээрэй.
  - Эхлээд сүүг амны том халбагаар хэмжиж, жижиг аяга руу хийлгэнэ.
  - Аягатай сүү хэдэн халбага болсныг асууж ярилцана.
  - Дараа нь том аяга руу сүүг мөн адил тоолуулж хийлгэнэ.
  - Хэдэн халбага сүү орсныг ярилцаж, хоосон нүдэнд тэмдэглээрэй.
2. Том, жижиг аяганд тус бүр хэдэн халбага сүү орсныг асууж, яагаад өөр хэмжээтэй орсныг ярилцаарай.
3. Та хүүхдээр шингэн зүйлсийг хэмжих хэрэгслүүдийг нэрлүүлээрэй.

### Дасгал 2.

1. Та хүүхэдтэйгээ ээдмийг яаж хийдэг тухай ярилцаад туршаарай.  
 Аяганд халуун сүү хийж, түүн дээрээ бага зэрэг тараг хийж, ээдүүлээрэй. Ээдсэн сүүгээ буцалгаж, ялгарч байгаа зүйлийг ажиглуулж, шар ус, ээдмийг тус тусад нь саванд хийж, амсаж үзүүлээрэй. Ээдмийг хатаавал эззгий болно гэдгийг хүүхэдтэйгээ ярилцаж, өдөр бүр ажиглуулаарай. Хэрэглэсэн сав, суулгаа хурааж цэвэрлэх үйлийг хамтдаа хийгээрэй.

### САНАМЖ

- Хүүхдэд хэмжигдэхүүний тухай ойлголтыг амьдралд ойрхон жишээн дээр ойлгуулахыг хичээгээрэй.
- Шингэн бутармаг зүйлийг хэмжихдээ асгахгүй байхыг анхааруулаарай.

**Зорилго:**

- Хүүхэд айраг бүлэх аман наадам хэлэх
- Хүүхэд "Айраг бүлэх" дууны бичлэгийг сонсох, дуулах,

**Бэлтгэх зүйл:**

- "Би чадна" дасгал ажлын дэвтэр
- Хөхүүртэй айраг

**Дасгал 1.**

1. Та хүүхдэдээ айраг хэрхэн бүлэхийг үзүүлж, өөрөө биечлэн зааж өгөөрэй.
2. Хүүхдээрээ дараах аман наадмыг наадуулж, айраг бүлүүлээрэй. Айргийг хэдэн удаа бүлснийг тоолуулаарай.

Айраг, айраг исгэе  
 Арав, арваар бүлье  
 Аав ээждээ тусалж

Ажил хөдөлмөр хийе гээд 1, 2, 3... гээд тоолж, бүлж болно.

**Дасгал 2.**

Дараах дууг сонсгоод зааж сургаарай. Бичлэгийг давтамжтай сонсгож, утга санааг нь ярилцаарай. Дууны үгийг мөр мөрөөр, бадаг бадгаар нь зөв, тод хэлж цээжлүүлээрэй.

*Үг Г.Ганболд  
 Ая Д.Балжинням*

**Айраг бүлэх**

Саамаа хийгээд  
 Айргаа бүллээ дээ  
 Тоолоод тоолоод  
 Тоогоо алдлаа даа  
     Саалийн цагтай  
     Уралдан бүллээ дээ  
     Тоолохгүй бүлж  
     Болдоггүй юм болов уу  
 Араг дээр гараад  
 Айргаа бүллээ дээ  
 Зэлний унага  
 Тоолдоггүйг мэдлээ дээ

**САНАМЖ**

- Хүүхдэдээ айраг бүлэхийн өмнө гарыг нь угаалгаж хэвшүүлээрэй.
- Хүүхдээр залхтал айраг бүлүүлэхээс татгалзаж, сонирхлоор нь туслуулаарай.

**Зорилго:**

- Хүүхэд сүү хэрхэн тараг болж байгааг мэдэх “бяцхан туршилт” хийх, таргаараа хүмүүсийг дайлах
- Хүүхэд сүү, тараг хоёрын хэмжээг харьцуулах, ээдэх, шар сүү, самрах гэсэн зэрэг үгийн утгыг хэлж тайлбарлах

**Бэлтгэх зүйл:**


- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Сүү, тарагны хөрөнгө
- Тогоо, шанага, хэмжээст сав, тагтай сав, амны том халбага
- Бүрсэн таргийг хучих алчуур

**Дасгал 1.**

1. Та хүүхдэдээ зургийн дагуу тараг бүрэх аргачлалыг тайлбарлан өгч, хамтран бүрээрэй.
  - Зөөлөн гал дээр хөөрүүлсэн 1,5 литр сүүн дээр 40-50 грамм (амны том халбагаар 4-5) тараг хийж, тасралтгүй самарч халаагаарай.
  - Энэхүү бүрж буй тарагны халууныг 36 хэм орчим (Хуруу дүрж үзэхэд сайн халсан байна.) халааж хөөсөртөл самарч, бэлтгэсэн саванд хийж таглаад дулаан хучлагаар хучиж, тавиарай.
  - Та 2-3 цагийн дараа бүрсэн тарагны хучлагыг авч, хүүхэдтэйгээ ажиглан ярилцаарай.
  - Бүрэлдсэн таргаа аягалж хэдэн аяга болсон, анх хэдэн аяга сүү байсан зэргийг харьцуулаарай.
  - Өөрийн бүрсэн таргаараа гэрийнхнээ дайлаарай.

**Дасгал 2.**

Тарагны шинж байдал, онцлогийн талаар дараах байдлаар ярилцаарай. “Ямар, ямар тараг байдаг вэ? нэрлээрэй” тоглоомоор тоглоорой. Ингэхдээ элгэн тараг, хонины тараг гэх мэтээр хэлэх бүрд урагш нэг алхана.



**МЭДЭЭЛЭЛ**

Тарган дахь кальци, уураг нь яс бэхжүүлдэг бөгөөд хүүхдийн өсөлтийг түргэсгэдэг шидтэй. Шүд хорхойтох, чулуу үүсэх, буйл үрэвсэхээс сэргийлэх шилдэг арга бол тараг уух гэнэ.

### Зорилго:

- Хүүхэд аарц шүүх, ааруул тавих ажилд оролцох
- Ааруулыг тоолох, ангилах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Айраг цагаа, аарц, ааруул, таглаатай шилэн сав
- Хувин, халбага, аяга, төрөл бүрийн хэв

### Дасгал 1.

1. Та хүүхдээ аарц шүүх, ааруул тавих ажилд оролцуулаарай.
  - Шилтэй айраг, хоормогноос саванд хийж буцалгана. Ямар үнэр гарч байгааг ярилцана. (Айраг, хоормог буцлахдаа гашуун цагаа болдгийг мэдүүлэх)
  - Буцалгаж хөргөсөн цагааг 3-4 давхар маарлаар шүүх, өнгө амтыг ярилцаж нэрлэнэ. (шар ус)
  - Маарланд шүүгдэж үлдсэн өтгөн аарцыг амсах, амт үнэр, өнгийг харж ярилцана.
  - Шүүгдсэн өтгөн аарцыг бөөрөнхийлөх, базах, хэвэнд хийх аргаар ааруул хэвлэнэ.

### Дасгал 2.

- Бөөрөнхийлсөн, базсан, хэвэнд хэвлэсэн аарцыг тавиур дээр дэлгэж тавин хатаана.
- Хийж гүйцэтгэсэн ажлаа дэс дараалан яриулаарай. Хүүхэдтэйгээ дэлгэц дээр ааруул өрөх явцад дараах дасгалыг хийж ярилцаарай. Үүнд:
- Нийт хэдэн эгнээ ааруул байгааг тоолуулах
- Хэдэн том, жижиг, зузаан, нимгэн, чихэртэй, чихэргүй, жимстэй, ямар хэлбэртэй ааруул тавьсныг тоолуулах
- Дэлгэцтэй ааруул хатсан эсэхийг харуулж эргүүлж тойруулан тавихад оролцуулаарай.
- **Айргийг** буцалгахад **цагаа**, цагааг шүүхэд өтгөн **аарц**, аарцыг хэвлэж хатаахад **ааруул** болдог дарааллыг яриулаарай.

### САНАМЖ

- Хүүхдийг аарц базах, чихэр, жимс холих, зүсэх, хэвлэх, дэлгэц дээр ааруул өрөх ажилд оролцуулж, магтаж урамшуулаарай.

## БӨМБӨГ

### Зорилго:

- Хүүхэд бөмбөг шидэж, өнхрүүлж, бай онож, өшиглөж тоглох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Бөмбөг
- Өнгийн харандаа

### Дасгал 1.

1. Та хүүхдээр зургийг сайтар ажиглуулж ярилцаарай.
2. Хамтдаа бөмбөгөөр тоглоорой. Тухайлбал:
  - Бөмбөгийг дээш шидээд унагалгүй барьж авах, алга ташаад барьж авах
  - Бөмбөгийг газар, хана, хашаа, шонд ойлгон барьж авах
  - Бөмбөгөөр харилцах, бие биедээ шидэж, өнхрүүлж дамжуулах
  - Бөмбөгийг хол зайд өшиглөх, өшиглөсөн бөмбөгийг хаах
  - Бөмбөгөөр хол, ойрын зайд бай онох
  - Бөмбөгийг сагсны цагаригт шидэж оруулах гэх мэт.

### Дасгал 2.

Бөмбөгийг хамгийн хялбар, ойрхон замаар хаалганд оруулах замыг тодруулж зуруулаарай.

### САНАМЖ

- Хүүхдэдээ бөмбөгөөр тоглохдоо мал үргээх, туйлуулах, өөрөө мөргүүлэх, бөмбөгөө хөөж гэрээсээ холдохоос болгоомжилж сануулаарай.
- Бөмбөгөөр тоглох үедээ унаж бэртэх, бусдын толгой, нүүр лүү цохихоос болгоомжлуулаарай.
- Өөрийн ээлжийг хүлээх, шударга, эвтэй тоглохыг зөвлөөрэй.

## ХӨГЖИЛТЭЙ ТООЛОЛ

### Зорилго:

- Хүүхэд тоог юутай төсөөтэй байгааг ажиглаж ярих
- Хүүхэд дүрсийг тоолж, цифртэй холбох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Ном, тоглоомын багц
- Балын харандаа

### Дасгал 1.

Та хүүхдээр дасгалын зургийг ажиглуулаарай.

- Тоог танилцуулна. Юутай төстэй байна вэ? харахад ямар амьтан шиг байна гэх мэт асууж ярилцана.
- Хэдэн ширхэг юмсыг, хэдийн тоогоор тэмдэглэж байгааг ажиглуулж, дүрсийг тоолуулна.

### Дасгал 2.

Хүүхдээр 1-р зургийг ажиглуулаад дүрсийг тоолж, тохирох цифрийг бичүүлээрэй.

### Дасгал 3.

Хүүхдээр 2-р зураг дээрх дүрсийг тоолуулж, дүн тоог нэрлүүлээд, тохирох тоотой зураасаар холбуулаарай.

### САНАМЖ

- Хүүхэдтэйгээ тоглох, аялах, ажил хөдөлмөрт туслуулах үедээ орчны юмсын хэлбэр, хэмжээ, өнгө, байршлыг асууж, тоолуулж, аль нь олон, цөөн, тэнцүү байгаа эсэхийг асууж, ярилцаарай.

**Зорилго:**

- Хүүхэд сэнс бүтээж, тоглох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- 14x14 см хэмжээтэй дөрвөлжин, өнгийн цаас
- Цавуу, өнгийн харандаа, зургийн дэвтэр (Цаас байж болно.)
- Дуут тоглоом: “Сэнс”

**Дасгал 1.**

1. Та хүүхдээр зураг дээрх аргачлалын дагуу 14x14 см хэмжээтэй дөрвөлжин өнгийн цаасаар сэнс хийлгээд салхинд эргүүлэн тоглуулаарай.

**Сэнс хийх дараалал:**

- Дөрвөлжин цаас бэлдэнэ.
  - Тасархай зураасын дагуу нугална.
  - Тод зураасын дагуу хайчилна.
  - Зурагт үзүүлснээр нугална.
2. Хүүхэдтэй хамтран 5x5 хэмжээтэй жижиг цаасаар сэнс хийж, ширээн дээр тавиад эгц дээрээс нь үлээж тоглоорой. Сэнсийг яаж хийсэн, үлээхэд хэрхэн эргэлдэж байгааг яриулаарай.
  3. Сэнс хийх аргачлалыг ашиглаж, цэцэг бүтээж болно.

**Дасгал 2.**

Та хүүхэдтэйгээ хамт мэддэг дууны аянд нь тааруулан дараах дуут тоглоомоор тоглоорой (Сайн уу, муу юу аль нь вэ? хө дууны аянд тааруулан дуулаарай).

Сэнс сэнс эргээрэй

Салхи татуулан эргээрэй

Сэнс сэнс эргээрэй

Сэрүү татуулан эргээрэй



**Зорилго:**

- Хүүхэд "Дээс" дуу дуулах
- Хүүхэд дээсэнд үсэрч тоглохдоо хөлийн өлмий дээрээ зөөлөн буух, тэнцвэрээ олох

**Бэлтгэх зүйл:**

- "Би чадна" дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №12 - "Дээс" дуу
- Дээс, олс

**Дасгал 1.**

1. Та хүүхдэдээ "Дээс" дууны бичлэгийг сонсгоорой.
2. Хүүхдэд давтан сонсох, хамт дуулах, дагуулан дуулуулах зэргээр сургаарай.

*Үг Ш.Бадарч*

*Ая С.Батболд*

**ДЭЭС**

Гарын аясыг дагаад  
 Галуун цуваанд үсрээрэй  
 Газраас өндөрт хөөрөөд  
 Баясалтайхан үсрээрэй  
     Дээс дээс эргээрэй эргээрэй  
     Дээш дээшээ үсрээрэй үсрээрэй  
     Дээс дээс эргээрэй эргээрэй  
 Авхаалж самбаа гаргаад  
 Ар араасаа үсрээрэй  
 Агаар мандалд хөөрөөд  
 Авхаалжтайхан үсрээрэй  
     Дээс дээс эргээрэй эргээрэй  
     Дээш дээшээ үсрээрэй үсрээрэй  
     Дээс дээс эргээрэй эргээрэй  
 Хожлын дээсэнд баясаад  
 Хурдан хурдан үсрээрэй  
 Хөлийн өлмий дээрээ  
 Хөгжилтэйхэн үсрээрэй  
     Дээс дээс эргээрэй эргээрэй  
     Дээш дээшээ үсрээрэй үсрээрэй  
     Дээс дээс эргээрэй эргээрэй

**Дасгал 2.**

1. Зургийг ажиглуулж, хүүхдүүд юугаар яаж тоглож байгааг яриулаарай.
2. Дээсээр олон янзаар тоглож болохыг биечлэн үзүүлж, хүүхэдтэй хамтран тоглоорой. Тухайлбал:
  - Газарт тавьсан олс, дээсийг давж үсрэх
  - Олсон дээгүүр гараа алдлан тэнцвэрээ олж алхах
  - Хоёр, гурвуулаа дээсэнд орж үсрэх

**САНАМЖ**

- Хүүхдэд дээсээр тоглох үедээ хөлийн өлмий дээр зөөлөн үсрэхийг сануулаарай.

**ШАГАЙ****Зорилго:**

- Хүүхэд шагайн 4 талыг нэрлэх, ялгах, орхиж тоглох
- Хүүхэд оноож тоолох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- 50 ширхэг шагай
- Балын харандаа

**Дасгал 1.**

1. Шагай орхиж тоглох, буусан шагайгаа нэрлэх, оноож тоолно (Дөрвөн бэрхийг нэрлүүлэх).

**Дасгал 2.**

Хүүхэдтэйгээ хамтдаа дараах тоглоомоор тоглоорой. Тоглоомын нэр, яаж тоглох аргыг тайлбарлаж өгөөрэй.

**Шагай таалцах**

Таалцаж тоглоход хоёроос гурван хүүхэд оролцох бөгөөд тэд шагайг тэнцүү хуваан авч түүнээс нөгөө тоглогчдодоо мэдэгдэхгүй (10-аас илүүгүй) атгаж:

- Би хэдэн шагай атгав?
- Мэргэн юм бол мэдээд таагаач
- Цэцэн юм бол цээжээр хэлээч гэж харилцан хэлээд нийлээд хэд болсон нийлбэр тоог онож таасан нь авч, олон шагайтай хүүхэд хожно. Хожсон хүүхэд:  
Бүх шагай минийх  
Бүх мал манайх гэж хэлнэ.

**САНАМЖ**

- Шагай таалцах тоглоом бол хүүхдийг тоолж сургах тооны хэлд (арав, хорь гэх мэт) сургах ардын сурган хүмүүжүүлэх ухааны нэг арга юм.
- Хүүхэд нэг тоглоомыг сайн тоглож сурсны дараа өөр тоглоом зааж тоглуулаарай.
- Хүүхдэдээ шагайг амандаа хийх, хамаагүй шидэхээс болгоомжлох, тоглож дууссаны дараа гараа угаахыг сануулаарай.

## "ТА БИТГИЙ УУРЛААРАЙ" МИНИЙ ТОГЛООМ

### Зорилго:

- Хүүхэд эсрэг утгатай үгийг нэрлэх, зургаас эсрэг утгатай зүйлсийг олж холбох
- Хүүхэд тоглохдоо ээлж дараагаа хүлээж тоглох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Шагай, шоо хайчилбар №3
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Үгийн эсрэг утгатайг нь олж, холбож зуруулаарай. Жишээлбэл: Хүнд – хөнгөн, тарган-туранхай

### Дасгал 2.

Тоглоомын хөлгийг хайчилж аваад хүүхэдтэйгээ хамтдаа дараах тоглоомоор тоглоорой. Тоглох арга, дүрмийг тайлбарлаж өгөөрэй.

## УУЧЛААРАЙ

### Тоглоомын дүрэм:

Дөрвөн бэрх орхиж, морь буусан тоогоор өөрийн дугуйг урагшлуулан нүүнэ. Морь буусан шагайг зөв нэрлэх, оноож тоолох, шударгаар, өөрийн ээлжийг хүлээж тэвчээртэй тоглох чадварыг дэмжинэ.

### Тоглоомын явц:

Тоглогчид 4 бэрх орхиж, морь буусан тоогоор өөрийн дугуйг урагш ахиулна. Хэрэв тоглогчид хөлөг дээрх нэг дугуйны зурагтай буудалд зэрэгцэн очвол сүүлийн хүүхэд “Уучлаарай” гэж хэлээд байрандаа зогсох ба түрүүлж очсон нь нэг нүдээр ухарна.

Хэрэв хоёр дугуйны зурагтай нүдэнд зэрэгцвэл бие биедээ “Баярлалаа” гэж хэлээд хамт буудаллана.

Дахин цааш тоглож, хэн түрүүлж барианд хүрсэн нь хожно.

### САНАМЖ

- Хүүхдэд тоглоомын дүрмийг биелүүлж, шударга тоглоход үлгэрлээрэй.

## БӨМБӨЛӨГ ХӨӨРГӨЖ ТОГЛОХ

### Зорилго:

- Хүүхэд тоглох бөмбөлгөө өөрөө бүтээж тоглох

### Бэлтгэх зүйл:

- 2 ш бөмбөлөг
- Хүн бүрт сонин

### Дасгал 1.

Сонингийн цаасаа 3 см-ийн диаметртэй, 50 см-ийн урттайгаар хуйлж скочоор нааж бэлтгэнэ. Хүүхэд бөмбөлгөө үлээж амыг нь бооно. Үлээсэн бөмбөлгийг хуйлсан цаасаараа хүчтэй үлээж, агаарт хөөргөн тоглоно.

### Дасгал 2.

*Үг Ш.Бадарч, Ая С.Батболд*

“Дээс” дууг давтах

## УНАГА

### Зорилго:

- Хүүхэд амьтны үр төлийн нэрийг мэдэх, оньсого таах
- Хүүхэд баримлын шавраар унага барих хэсгийг бэлтгэх, барих

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Баримлын шавар, хулдаас, хайч, алчуур
- Балын харандаа

### Дасгал 1.

1. Бөжин, бөөдий, бамбарууш, унага, гөлөгний зургаас оньсогын тайллыг олж дугуйлан зуруулаарай.
2. Дараах оньсогыг уншиж өгөөд таалгаарай.

Ган дөрвөн туурайтай  
Газар товчлох хурдтай  
Товор товор алхаатай  
Түмэн сайхан сүрэгтэй (унага)

### Дасгал 2.

1. Та хүүхэдтэйгээ хамтран зурагт үзүүлсэн аргачлалын дагуу “Унага” бариарай.
  - Цагаан өнгийн 2 том дугуй, 1 том гонзгой, 9 жижиг дугуй хэлбэртэй баримлын шавар, 4 ширхэг чүдэнзний мод бэлтгэнэ (Зураг 1-3).
  - Цагаан өнгөтэй гонзгой баримлын шаврын дунд хэсэгт нь дарж хонхойлгон, зурагт үзүүлсний дагуу үзүүр хэсгийг урагш болгосноор унаганы их бие, толгой бэлэн болно (Зураг 4).
  - Толгойн оройн хэсгээс эхлэн хүзүүг дагуулж жижиг гонзгой хэлбэртэй баримлын шавар наагаад, шулуун чиглэлээр хайчилж дэлийг дүрсэлнэ (Зураг 5).
  - Цагаан өнгийн 2 жижиг дугуй баримлын шавар авч гурвалжин хэлбэрт оруулан, гол хэсгийг хурууны өндгөөр хонхойлсноор чих, хар болон хөх өнгийн жижиг дугуйг хавтгайлан давхарлаж нүд бэлэн болно. Чих, нүдийг толгойн хэсэгт нааж бэхэлнэ. Өөрийн сонирхлоор бусад чимэглэлийг хийж болно (Зураг 6).
  - 4 ширхэг чүдэнзний модоо баримлын шавраар бүрж үзүүр хэсгийг улаан өнгийн жижиг баримлын шавраар чимэглэн, их биед бэхэлснээр хөл бэлэн болно (Зураг 7).

**УНАГА**

- Улаан өнгийн баримлын шаврыг бөөрөнхий → гонзгой → хавтгай болгон тохом хийнэ (Зураг 8).
  - Цагаан өнгийн 1 жижиг дугуй дүрсээ гонзгойлж конус хэлбэрт оруулан, үзүүрийг бага зэрэг дээш эргүүлж сүүл болгоод их биед залгана (Зураг 9).
  - Ингээд унага бэлэн боллоо (Зураг 10).
2. Хүүхдийнхээ янз бүрийн хөдөлгөөнтэй унага дүрслэн барих сонирхлыг дэмжээрэй.

## ШҮР ХЭЛХЭХ

### Зорилго:

- Хүүхэд шүрээр хүзүүний зүүлт, бугуйвч хэлхэх
- Хүүхэд зүй тогтлыг олж, хээ зурах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Төрөл бүрийн өнгө хэмжээтэй шүр, зөөлөн утас

### Дасгал 1.

Та хүүхдэд төрөл бүрийн шүрээр хүзүүний зүүлт, бугуйвч хэлхэж, гоёж болохыг ажиглуулж хэлүүлээрэй.

### Дасгал 2.

Тууз бүрийн хээг ажиглаж, хэрхэн дараалсан тухай ярилцаарай. Хоосон нүдэнд зүй тогтлоор ямар хээ байхыг олж зураарай.

### САНАМЖ

- Хүүхдийг хэт удаан хугацаагаар суулгаж, ядрааж, шахаж болохгүйг анхаараарай.



**МИНИЙ НАЙЗ****Зорилго:**

- Хүүхэд зохиолыг сонсоод асуултад хариулах, зохиолыг яагаад ийнхүү нэрлэсэн тухай ярих
- Хүүхэд найзынхаа тоглоомыг зөвшөөрөлгүй авч болохгүйг мэдэх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хайчилбар №4 “Ниссэн хүүхэлдэй”
- Зургийн хэрэгслүүд

**Дасгал 1.**

1. Та хүүхдэдээ “Ниссэн хүүхэлдэй” номыг уншиж өгөөрэй. Номыг уншихын өмнө “Яагаад “ниссэн” гэсэн юм бол?” уншиж мэдье гэж анхаарлыг татаарай.

*Х.Батхүү*

**Ниссэн хүүхэлдэй**

Зулаа миний хамгийн сайн найз. Тэр манай хөрш айлын охин. Зулаа надаас арай л дүү. Би цэцэрлэгт явж ангийн нөхөдтэйгөө тоглодог, харин Зулаа гэртээ эмээтэйгээ үлддэг.

Зулаагийн эмээ нь таягтай явдаг тул тэр гэрээ цэвэрлэж, бас хоол хийхэд нь тусалдаг. Тэгэхдээ Зулаа шиг сайн найз надад үгүй.

Би жижигхэн сагсанд цөөхөн тоглоомоо хийгээд Зулаагийнд очдог. Зулаа зөндөө олон хүүхэлдэйтэй, түүгээр тоглох үнэхээр сайхан. Би өдөр бүр цэцэрлэгээ тараад Зулаагийнх руу яаран очдог. Намайг тэднийд очиход эмээ нь дөнгөж жигнэсэн, амттай жигнэмгээр дайлдаг.

Зулаа бид хоёр хөөрхөн хүүхэлдэйнүүдээрээ тоглодог. Зулаа минь хүүхэлдэйгээр тоглох үнэхээр дуртай. Зулаа хүүхэлдэй бүртээ маш их хайртай. Тэднийг амьд юм шиг нэрээр нь дууддаг.

- Энхээ, Бямбаа, Жаргал, Алимаа бас Батаа гэж дуудахад би өөрийн эрхгүй инээмсэглэдэг.

Харин Бат бол миний хамгийн хайртай хүүхэлдэй. Түүний алтан шаргал үс, үл ялиг инээмсэглэсэн цэнхэр нүд нь жинхэнэ нисгэгч шиг харагддаг. Баттай тэнгэрээр нисэж байгаа шиг итгэн тоглох дуртай.

Зулаагийн хайртай хүүхэлдэй Бат хэдий боловч надаас огтхон ч харамладаггүй нь их сайхан байдаг.

Гэтэл нэг өдөр би Батыг гэртээ аваад ирчихсэн... Өөрийнхөө гэрт Баттай тоглох бүр их сайхан байлаа. Баттай цэлмэг хөх тэнгэрээр нисэж удаан зугаалж, олон

## МИНИЙ НАЙЗ

сайхан зүйлтэй учирч байсан. Маргааш өглөө нь цэцэрлэгт явахдаа хэн ч олохооргүй газар Батыгаа нуучихлаа. Тэр одоо минийх болсон.

Би цэцэрлэгээсээ ирэхдээ Зулаагийнх руу биш гэрлүүгээ яардаг боллоо. Энэ нь Батдаа л хурдан очих гэсэн хэрэг.

Гэвч хэдэн хоногийн дараа Зулаагаа санаж эхлэв. Иймээс гэрт нь очихоор шийдлээ. Урьдын адил Зулаа эмээтэйгээ угтлаа. Намайг амтлаг жигнэмэг, сүүгээр дайллаа. Харин би Зулаа юу ч идэхгүй байхыг ажиглалаа. Түүнийг гайхан "Яасан бэ? амттай л байна шүү дээ" гэхэд "Би их гунигтай байна. Бат яваад өгсөн. Хаана байгааг огтхон ч мэдэхгүй." гэв.

Би уртаар шүүрс алдан дуугүй л суув. Эмээ над руу инээмсэглэн ширтэж "Бат харь гаригт нисчихсэн юм болов уу? Эсвэл ойрхон байгаа юм уу?" гэх нь тэр.

Гэтэл жигнэмэг амтгүй ч юм шиг болж эхэллээ. Харин Зулаа минь уйлж амандаа "Бат минь эргээд ирдэг ч болоосой. Би яасан их санаж байна вэ?" гээд алга хавсран залбирч байв.

Би жигнэмгээ тавиад бас л уйллаа. Тэгээд өөрийн мэдэлгүй гэрлүүгээ гүйлээ. Зөвхөн хурдан л очихыг хүссэн... Яаран яаран гүйсээр нэг гартаа Батыг, нөгөө гартаа Зулаагийн дуртай чихрийг барин буцаж ирлээ. Зулаа чанга хашхиран Батыгаа тэврэн авч "Наддаа хүрээд ирэв үү? Гэртээ тавтай морил доо." гэв.

Би "Зулаа намайг уучлаарай." гэж үнэн сэтгэлээсээ хэлэв. Эмээ хацрыг минь зөөлөн илж, дахиад жигнэмэг өглөө. Энэ бол хамгийн амттай жигнэмэг байсан юм.

2. Хавсралтад байгаа зургийг ашиглан ойлгосон зүйлийг яриулахдаа дараах асуултаар чиглүүлээрэй.

- Зулаа охин найзтайгаа юугаар тоглодог байсан бэ?
- Охины тоглох дуртай хүүхэлдэйн нэр нь бэ?
- Охин яагаад гэр рүүгээ яардаг болсон бэ?
- Зулаа яагаад уйтгарласан бэ?
- Эмээ охинд юу гэж хэлсэн бэ?
- Хүүхэлдэй үнэхээр ниссэн үү?
- Зулаа охин найздаа ямар үгийг чин сэтгэлээсээ хэлсэн бэ?
- Эмээгийн өгсөн жигнэмэг яагаад хамгийн амттай байв?
- Бусдын эд зүйлд зөвшөөрөлгүй хүрч, авч болох уу?

### САНАМЖ

- Хүүхдэд ном уншиж өгөхөд их баярладаг тул үлгэр, зохиол уншиж, ярьж өгч байгаарай.
- Хүүхдэдээ бусдын юмыг зөвшөөрөлгүй авах нь хулгайлахтай адил буруу үйл гэдгийг ойлгуулаарай.

**ЭВТЭЙ ТОГЛОЁ****Зорилго:**

- Хүүхэд бусадтай эвтэй тоглох, найзалж нөхөрлөхийн сайхныг ярилцах өөрийн бодлоо хэлэх
- Хүүхэд дууг сонсож, хөгжмийн хэмнэлд тохируулан дуулах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №13 - “Тоогүй ч юм болов уу даа” дуу
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

1. Та дасгалын зургийг хүүхдээр ажиглуулж, дараах асуултаар ярилцаарай.
  - Бат, Энхээ нар бөмбөг булаалдаж байна. Чи ийм тохиолдолд яах байсан бэ?
  - Анхбаяр ууттай чихрээ найзуудтайгаа хуваалцах болов уу?
2. Найзууд чихэр, ном, тоглоомоо өгч, хамтран тоглож, найзлахаас гадна “Өөр юуг хуваалцаж болох вэ?” гэсэн асуултаар баяр хөөр, уйтгар гунигаа хуваалцаж нөхөрлөдөг тухай ярилцаарай.

**Дасгал 2.**

1. Дараах дууг сонсгоорой. Дууг хүүхдэд давтамжтай сонсгох, дагуулж, хамт дуулах зэргээр сургаарай.

*Үг Ш.Бадарч*

*Ая Б.Баярсайхан*

**Тоогүй ч юм болов уу даа**

Айлын маамуу надаас  
 Алаг бөмбөгөө өгөөч гээд  
 Гуйгаад байхад нь харамлаад би  
 Нуугаад байсан юм даа  
     Тоогүй ч юм болов уу даа  
     Тоглодог байж үү дээ  
 Маамуу дараа надтай  
 Машинаараа тоглоё гээд  
 Гуйгаад байхад нь тоолгүй би  
 Гүйгээд ирсэн юм даа

## ЭВТЭЙ ТОГЛОЁ

Тоогүй ч юм болов уу даа

Тоглодог байж үү дээ

Буруугаа би хүлээгээд

Буцаад очдог байж дээ

Одоо хоёулаа тоглоё гээд

Очоод гуйх нь зөв л дөө

Тоогүй ч юм болов уу даа

Тоглодог байж үү дээ

### Дасгал 3.

Хүүхдүүдийн зургаас нэгийг сонгуулж будах, нүүрний хувирлыг баяр баясгалантайгаар дүрсэлж зураарай.

### САНАМЖ

- Хүүхдэдээ аливаа сайн, сайхныг хуваалцах нь бусдыг ч, өөрийгөө ч баярлуулдаг тухай ярьж өгөөрэй.

**ДУГУЙТАЙ ЖААЛ****Зорилго:**

- Хүүхэд зохиолоос Төмөрийн зан авир, Тогоог юунд шоолсон тухай ярилцаж, хүмүүс нэгнээ шоолоход сэтгэл санаа нь эвгүй байдалд ордог талаар ойлгох, хүүхдүүдтэй тоглохдоо бие биенээ шоолж гомдоохгүй байхыг хичээх
- Хүүхэд байгалийн болон гарын доорх материалаар эд зүйл зохиож, урлан бүтээх, хийсэн бүтээлээ тайлбарлан ярих

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Том, жижиг, хавтгай, бөөрөнхий янз бүрийн чулуу
- Тосон харандаа, усан будаг, бийр

**Дасгал 1.**

1. Та хүүхдэдээ дараах зохиолыг уншиж өгөөрэй.

*Ч.Доржгочоо*

**ДУГУЙТАЙ ЖААЛ**

Манай хөрш айлд Төмөр хотоос ирж амарсан юм. Гялалзсан хар дугуйтай. Дугуйгаараа өөдөө уруугаа зогсоо зайгүй жирийлгэнэ. Хотон дундуур давхиж, хонь үргээнэ. Түүгээр ч барахгүй нэг удаа үхрийн эзлэн дундуур давхин орж Цэвээн эгчийн хувинтай сүүг дайрч асгаад, бөөн хэл ам болсон. Түүнээс хойш “Чойжав гуайнд ирсэн дугуйтай жаал үймүүлээд болохоо байлаа” гэсэн яриа дэгдэх болов. Нэг удаа би гуйж байж дугуйг нь унаж үзэх болов. Төмөр тачигнатал инээж:

- Үгүй ээ! Энэ муу Тогоогийн хөглөж байгааг. Дугуй ч унаж чадахгүй шүү гээд л бараг тэр оройжингоо шоолж хөхрөв.

Нэг өдөр Төмөр:

- Тогоо! Би чиний морийг унаж үзье гэхэд:

- Чи морь унаж чадах уу? гэв. Чадахаар барах уу хотод хүүхдийн парк гэж байдаг юм. Тэнд би сайн өдөр бүр шахам эргүүлэгт тоглоом дээр морь унадаг гэхэд нь би толгой дохив. Удсан ч үгүй Төмөр уйлах нь тэр. Юу болсныг гарч харвал тэр маань тушаатай морин дээр мордоод дэгэнцэхээр нь ойчжээ.

- Чи морины тушааг нь авч мордохоо мэддэггүй юм уу? гэж асуухад:

- Үгүй ээ, би жинхэнэ ийм амьд морь унаж үзээгүй гээд л үргэлжлүүлэн уйлав. Би түүнийг өчүүхэн ч шоолсонгүй. Харин Төмөрөөг буцахаас нь өмнө морь унуулж сургасан билээ.

2. Зохиолын агуулгыг хүүхэдтэйгээ дараах асуултаар ярилцаарай.

- Хотын хүүхэд, хөдөөний хүүхэд хоёрт ямар ялгаа байсан вэ?

## ДУГУЙТАЙ ЖААЛ

- Тогоо, Төмөр хоёрын гаргаж байгаа зан авир, үйлдлийг чи юу гэж бодож байна вэ?
- Хүүхдийнхээ очсон хот, сумын төвийн тухай ярилцаарай.

### Дасгал 2.

Та хүүхэдтэйгээ голын усанд болон эргэн тойронд байгаа чулууг хооронд нь өнгө, хэлбэр, хэмжээ, хуурай, нойтон гэх мэт шинж чанараар нь ялгаж, дээр нь юу дүрслэн зурж, яаж тоглож болохыг ярилцаарай. Зураг зурахдаа голын нойтон чулууг хуурай болтол арчина. Эсвэл хуурай чулууны шороог цэвэрлэн угааж бэлдсэн байна. Бэлдсэн чулуун дээрээ тосон харандаа, усан будгаа ашиглан (Номын зургаас санаа аваарай) зураарай.

Хүүхдийн хийсэн бүтээлээ ашиглан:

- Чулуугаар гэр барьж айл болох, мал сүрэг бэлчээж тоглох, хот суурин газар гэх мэтээр баяжуулан тоглуулаарай.
- Жижиг чулууг няслах, шүүрэх, хөлөгт тоглоомын хүү болгох, чулуу таалцах, усны мандал дээгүүр чулуу шидэж ойлгох гэх мэтээр тоглуулж, урамшуулаарай.

### САНАМЖ

- Тоглох үедээ чулууг амандаа хийх, том чулууг хөл дээрээ унагах, шидэхдээ санамсаргүй хүн, амьтан онох зэргээс болгоомжлохыг сануулаарай.

## АЖИЛ МЭРГЭЖИЛ

### Зорилго:

- Хүүхэд хүмүүсийн ажил мэргэжлийн тухай ярилцах, онцлогийг хэлэх, ажлын орчинг таних, ажил мэргэжил ба орчинг тохируулан холбох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа

### Дасгал 1.

Зурган дээрх хүмүүс ямар мэргэжилтэй хүмүүс бэ? Чи яаж таньсан бэ? Тэд ямар ажил хийдэг бэ? Өөр ямар мэргэжил байдаг тухай ярилцаарай

### Дасгал 2.

Хэн, ямар машинд суухыг холбож зуруулаарай. Яагаад?

### САНАМЖ

- Хүүхэд хүмүүсийн ажил хөдөлмөр, харилцааг шууд тусган дуурайдаг тул тоглож буй үйлийг нь хянаад муу зүйл байвал засахад анхаараарай.

## ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ

### Зорилго:

- Хүүхэд тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг ямар мэргэжлийн хүмүүс ашигладаг болон тохирох мэргэжлийн хүнтэй нь холбох
- Хүүхэд яаралтай тусламжийн тусгай дугаарыг ямар үед дууддагийг мэдэх, таних

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

- Та хүүхдээр зургийг ажиглуулж, дараах асуултаар ярилцаарай.
- Эдгээр хүмүүс ямар ажил хөдөлмөр хийдэг вэ?
- Эмч, цагдаа, гал сөнөөгчийн машин техник ямар ялгаатай байна вэ? (Цагдаагийн машин дуут дохиотой, галын машин шаттай, эмнэлгийн машин + тэмдэгтэй гэх мэт)

### Дасгал 2.

- Хүүхэдтэйгээ хамтран 101, 102, 103 зэрэг тусгай дугаарын утасны учрыг ярилцаж, цээжлүүлээрэй.
- Тусгай дугаарыг тохирох машины урд бичээрэй.

### САНАМЖ

- Шаардлагагүй үед тусгай дугаар луу залгаж, тоглож болохгүй гэдгийг сануулаарай.



## ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ

### Зорилго:

- Хүүхэд хөдөлмөрийн багаж хэрэгслийг таних, нэрлэх, ямар үйл хийдэг тухай ярилцах
- Хүүхэд дасгал хөдөлгөөн хийх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа, бахь
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Зургийг ажиглаж, дараах асуултын дагуу ярилцаарай. Ямар мэргэжлийн хүмүүс байна вэ? Ямар багаж байна вэ? Ажлаа хийхэд хэнд, юу хэрэгтэй вэ? Хоорондоо холбоо хамааралтайг холбон зуруулаарай. Яагаад хамааралтай болохыг асуугаарай. Тухайлбал: Эмчийг чагнууртай гэх мэт. Өөр ямар ажил мэргэжил байдаг талаар дэлгэрэнгүй ярилцаарай.

### Дасгал 2.

Зураг дээрх багажнууд хэнд хэрэгтэй вэ? Яагаад? Та хүүхдэдээ гэртээ байгаа мужааны болон бусад хөдөлмөрийн багажийг харуулж, хэрхэн, хэрэглэдэг талаар танилцуулаарай.

### Дасгал 3.

Дасгал хийхэд зориулж, дэвсгэр бэлдэж тавина. Дасгалын аргачлалыг уншаад зургийн дагуу хамтдаа хийгээрэй.

### БАХЬ

(Сунгалтын дасгал)

### Аргачлал:

1. а. Нуруугаар хэвтэж гараа дээш өргөнө.  
б. Гараа урагш барин өндийж сууна.  
в. Бөхийж гараа өлмийд хүргэнэ.
2. а. Хөлөө салган гараа өргөн сууна.  
б. Бөхийж баруун хөлийн өлмийд гараа хүргэнэ. Эсрэг тал руу давтан хийнэ.
3. а. Хөлөө салган гараа өргөн сууна.  
б. Бөхийж хөлийн өлмийд хүргэнэ.

**ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ**

4. а. Хөлөө нийлүүлэн сууж, гараа урагш өргөнө.  
б. Баруун тийш эргэж гараар тулан хэвтэнэ. Гараа эгцлэн тулж, өндийн сууна.  
Эсрэг тал руу давтан хийнэ.

**САНАМЖ**

- Хүүхдэд өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, дасгал хөдөлгөөнийг хөгжмийн аянд тохируулан хийхэд нь дэмжлэг үзүүлж урамшуулаарай.

## ЗУРААЧ

### Зорилго:

- Хүүхэд зургийн хэрэгслийг нэрлэх, хэрэглэх
- Хүүхэд зургийн хэрэгслийг цэвэрлэх, эмхэлж хураах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Зургийн хэрэгслүүд

### Дасгал 1.

1. Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой.

*Б.Пүрэвдолгор*

#### БИ ЗУРААЧ

Өнгийн харандаа богинохон болжээ  
 Эзэн надад тусалсаар тэр шүү дээ  
 Өөрөө би зураач болжээ  
 Энгүй хичээж зурсаар тэр шүү дээ

2. Зураачид хэрэгтэй зүйлийг нэрлээрэй. Чамд эдгээрээс аль аль нь байгаа вэ? асуултын дагуу ярилцаарай.

### Дасгал 2.

Цэгийн дагуу амьтдын явсан замыг зуруулаад ялгааг ярилцаарай.

### Дасгал 3.

Усан будаг, бийр ашиглан, чөлөөт сэдвээр зуруулаарай.

## НИСЭГЧ

### Зорилго:

- Хүүхэд тэнцвэрийг хөгжүүлэх дасгал хөдөлгөөнийг хийж, тоглох
- Хүүхэд дугуй дүрсийг нэрлэх, тоолох, дэс дугаарыг мэдэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын ба өнгийн харандаа

### Дасгал 1.

1. “Нисэгч” дасгалын зургийг ажиглуулаарай. Хүүхдээр дасгалыг эхлэн хийлгэхдээ тайлбарлана. Дасгалын хөдөлгөөнийг тогтоосны дараа 1-12 хүртэл тоолж, гүйцэтгүүлээрэй.

#### “НИСЭГЧ”

(Дасгал)

1. “Онгоц нислээ” - Гарыг хоёр тийш алдлан хөлийн өлмий дээр зогсоно.
2. “Онгоц хазайлаа” - Баруун зүүн тийш хазайна.
3. “Онгоц өндрөө авлаа” - Нэг хөл дээр тэнцвэрээ хадгалж зогсоно.
4. “Онгоц үүлэн доогуур шумбалаа” - Тэнцвэрээ хадгалж зогсоод тонгойно.
5. “Онгоц өндрөө авлаа” - Нэг хөл дээрээ зогсоно.
6. “Онгоц газардлаа” - Явган сууна.

### Дасгал 2.

1. Хүүхэд дугуй дүрсийг зурах, будах дасгал хийнэ.
  - Хүүхдээр дугуй дүрсийг сумны дагуу тодруулан зурна.
  - Нэг, гурав, тав, долоо дахь дүрсийг будах даалгаврыг гүйцэтгүүлнэ.

### САНАМЖ

- Тэнцвэрийг хөгжүүлэх дасгалыг тайван хийлгэж, хөдөлгөөнийг зөв тогтоолгоорой.
- Дасгалыг өдөр бүр хийлгэж хэвшүүлээрэй.

**Зорилго:**

- Хүүхэд гарын доорх материал ашиглан машин зохион бүтээх
- Хүүхэд зүйр үгийн утгыг ойлгох, тогтоох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Сүүний (усны) сав, өнгийн цаас, хатуу цаас, шугам, хайч, цавуу, наалдамхай тууз (скоч), сүүний (усны) савны бөглөө
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

1. Та хүүхэдтэйгээ машин хийх аргачлалыг ажиглаж, машин бүтээгээрэй. Машиныг юугаар хийсэн, их бие, урд толгой хэсэг, суудлын болон ачааны хэсэг, тэвш, цонх, хаалга, дугуй нь хаана, ямар хэлбэр, байрлалтай байгаа зэргийг асууж ярилцана.
2. Хүүхэдтэйгээ хамтран аргачлалын дагуу машин зохион бүтээгээрэй. Та хүүхдэдээ машин бүтээхэд тусалж чиглүүлнэ. Харин өөрөө барьж хийхээс зайлсхийгээрэй. Дараах асуултаар чиглүүлээрэй.
  - Эхлээд машины аль хэсгийг хийх вэ?
  - Машины их бие болон бусад хэсгүүдийг яаж хийх вэ?
  - Чи хаалга, цонх, ачааны тэвшийг машины хаана байрлуулах вэ?
  - Яаж чимэглэх вэ? зэргээр ярилцана.

**Дасгал 2.**

Хүүхдэд зүйр үгийг тогтоолгоорой. Зүйр үгийн утгыг хүүхдийн хийж байгаа дасгалтай нь холбон тайлбарлаж өгөөрэй.

Оролдвол нэгийг бүтээнэ

Уралдвал нэг нь түрүүлнэ

**САНАМЖ**

- Хүүхдийн юу хийж байгааг асууж сонирхон, санаа өгч туслах нь тэдэнд урам өгч, бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлдэг гэдгийг санаарай.

## МАЛЧИН

### Зорилго:

- Хүүхэд тоолоод дүн тоог хэлэх, цифр бичиж сурах
- Хүүхэд дууг сонсоод хэмнэлд тааруулан алгаа таших, дуулах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №14 - “Хургачин”
- Өнгийн харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Та хүүхдээ зургийг ажиглахыг хүсээрэй.

- Зурган дээр байгаа хурга, ишгийг тоолуулаарай. Хэдэн хурга, хэдэн ишиг байгааг (дүн тоог) хүснэгтэд бичүүлээрэй.
- Хургачин хүүхдүүдийн дээлийг дуртай өнгөөр будуулаарай.

### Дасгал 2.

Дараах дууг сонсгоод зааж сургаарай. Бичлэгийг давтамжтай сонсгож, утга санааг нь ярилцаарай. Дууны үгийг мөр мөрөөр, бадаг бадгаар нь тод хэлж, цээжлүүлээрэй.

*Үг Б.Бааст*

*Ая С.Гончигсумлаа*

## ХУРГАЧИН

Ногоон торгон дээр  
 Сувд байгаа шиг  
 Ногоон талдаа  
 Хургаа бэлчээнэ  
 Хургаа хариулахад  
 Унтаж болохгүй  
 Яагаад гэвэл чоно ирнэ  
     Хурга минь өсөөд  
     Хонь минь нэмэгдэнэ  
     Би өсөөд  
     Баатар болно.  
     Өвсний сайханд  
     Хургаа хариулна  
     Үдэш ирээд  
     Таргаа ууна.

### САНАМЖ

- Хүүхдээ зөв сууж, хоолойгоо шахалгүй дуулахад сургаарай.

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

### Зорилго:

- Хүүхэд тээврийн хэрэгсэл ямар зориулалттайг мэдэх
- Хүүхэд тээврийн хэрэгслийг олон янзын эд юмс ашиглаж, бүтээх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Дүрст самбар, өнгийн утас, балын харандаа

### Дасгал 1.

1. Зургийг ажиглаад асуултын дагуу ярилцаарай.
  - Ямар, ямар тээврийн хэрэгсэл байна вэ?
  - Юу тээвэрлэдэг вэ?
  - Тээврийн хэрэгсэл бидний амьдралд ямар ач тустай вэ?
2. Тээврийн хэрэгсэл юу тээвэрлэдгийг олж, тохирох зурагтай нь холбуулаарай.

### Дасгал 2.

1. Тээврийн хэрэгслийг дараах зүйлсийг ашиглаж дүрслэн бүтээгээрэй.
  - Нүхтэй болон хадаасан самбар ашиглаж, өнгийн утас, резинээр бүтээх
  - Савх, шагайг өрж бүтээх
  - Дөрвөлжин нүдтэй цаасанд зурж дүрслэх

### МЭДЭЭЛЭЛ

Тээвэр хийх зорилгоор ашигладаг хэрэгслийг “Тээврийн хэрэгсэл” гэнэ. Одоо цагт хүмүүс автомашин, галт тэрэг, нисэх онгоц, усан онгоц гэх мэт олон янзын тээврийн хэрэгслийг зохион бүтээж, зорчигч тээвэр, ачаа тээврийн аль алинд өргөнөөр хэрэглэж байна.

Машин зам дээр тоглож болохгүй, машинд явж байхдаа цонхоор толгойгоо, гараа гаргаж болохгүй гэдгийг сануулаарай.



**Зорилго:**

- Хүүхэд цаасаар онгоц бүтээх, тоглох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн болон бичгийн цаас

**Дасгал 1.**

Хүүхдээр дасгалын зургийг ажиглуулаад онгоц бүтээлгээрэй. Хүүхэд өөрөө санаачлан, өөр аргаар онгоц эвхэж тоглохыг дэмжээрэй. Хийсэн онгоцыг хөөргөж тоглуулаарай.

**Дасгал 2.**

Үг Б.Бааст, Ая С.Гончигсумлаа “Хургачин” дууг давтаарай.

**САНАМЖ**

- Цаасныхаа тэгш хэмийг олж, ирмэгийг давхцуулж нугалаарай. Цаасаа урахаас болгоомжлоорой.



**Зорилго:**

- Хүүхэд “Завьтай аялал” үгэн тоглоомыг хэлэх, цаасыг эвхэх гэсэн хоёр үйлийг хослуулан хийж тоглох
- Хүүхэд усанд тоглоом, эд юмсыг хөвүүлэх, живүүлэх туршилт хийх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн болон балын харандаа
- Түмпэнтэй ус, завь, амны халбага, чүдэнзний мод, чулуу, навч, модны холтос, хомоол, шагай

**Дасгал 1.**

Та хүүхдэдээ үгэн тоглоомын зургийг ажиглуулж, дарааллын дагуу тайлбарыг хэлж, цаасыг эвхэж тоглоорой.

**ЗАВЬТАЙ АЯЛАЛ (ЗАВЬ ЭВХЭХ АРГАЧЛАЛ)**

*(Үгэн тоглоом)*

1. Би найзуудтайгаа аялалд явлаа.
2. Өндөр сайхан уул харагдаж байна.  
Өврөөрөө дүүрэн цэцэг навч дэлгэрсэн  
Араараа дүүрэн адуу мал багширсан, аятайхан сайхан уул байна.
3. Нар маш ихээр шарж байсан учраас том малгайгаа өмслөө (Толгой дээрээ тавина).
4. Алчуураа гарган хөлсөө арчлаа.
5. Гэдэс их өлсчээ. Ээжийнхээ өгсөн (Нэг талыг нь гурвалжилж нугална.)  
Эмээгийнхээ өгсөн хуушуурыг идлээ (Эргүүлж нөгөө талыг нь гурвалжилж нугална. Идэх хөдөлгөөн хийнэ).
6. Цааш аялахдаа жижиг малгайгаа өмслөө (Толгой дээрээ тавина).
7. Өмнө маань томоос том далай харагдана. Эрэг дээр нь нэгэн завь байв.  
Аяллаа, хөвлөө.  
Завь маань тэнцвэрээ алдаж явсаар урд талаараа хад мөргөж эвдэрлээ (Урд талын хамрын хэсгийг нь урна).  
Завь маань тэнцвэрээ алдаж явсаар ард талаараа хад мөргөж эвдэрлээ (Ард талын хэсгийг нь урна).
8. Бидний сууж явсан завь бүрэн сүйрч далайн усанд унасан учраас аврах хантаазаа өмслөө (Задална).
9. Бүх хувцас усанд норсон учраас урт ханцуйтай цамцаа өмслөө (Эсрэг тал уруу нугалж барина).

10. Нар гарч хувцас хатсан учраас богино ханцуйтай цамцаа өмслөө. (Урт ханцуйг нь урна).
11. Бүгдээрээ эсэн мэнд аяллаа өндөрлүүлсэн учраас баясгалантайгаар зургаа татууллаа. Чик, чик (Тэнийлгэж дундах нүхээр нь харж бие биенийхээ зургийг авч тоглоно).

### Дасгал 2.

Хүүхдээрээ зураг дээрх зүйлс (завь, амны халбага, чүдэнзний мод, чулуу, навч, модны холтос, хомоол, шагай)-ийг ажиглуулж нэрлүүлээд, усанд аль нь живэх, аль нь хөвөх вэ? туршилтыг хийлгээрэй.

### САНАМЖ

- Гол горхи, усны ойролцоо тоглохдоо усанд бохир зүйл оруулахгүй байх тухай сануулж хэлээрэй.

**Зорилго:**

- Хүүхэд зургийг ажиглан, бусдаасаа өөр зургийг олох
- Хүүхэд зургийг ажиглан ялгааг олох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

Хүүхэд нүд бүрд байгаа зурагнууд ижил байгаа эсэхийг ажиглаж бусдаасаа өөр зүйлийг олж дугуйлах даалгавар хийнэ. Яагаад өөр байгааг тайлбарлаарай.

Тухайлбал: 1-р нүдэнд бусдаасаа ялгаатай нь цох хорхой байна. Цох нисдэг бусад амьтад нь нисдэггүй, толбот шүрэн цох шавжны төрөл гэх мэт.

**Дасгал 2.**

Хүүхэд 2 ижил зургийг ажиглаж, 6 ялгааг олж дугуйлна. Тухайлбал: Зураг дээрх охины үсний боолт нэг зураг дээр нь ногоон, нөгөө дээр нь хөх байна гэх мэт. Ямар ялгаа байгааг ярилцаарай.

**Зорилго:**

- Хүүхэд улирлын нэрийг хэлэх, мод яагаад 4 өөр байгааг тайлбарлах
- Хүүхэд зохиол сонсох, асуултад хариулах улирлын нэрийг хэлэх, ямар онцлогтой байдгийг ярихцах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №15 - “Дөрвөн хүсэл” өгүүллэг

**Дасгал 1.**

1. Та хүүхдээр зургийг ажиглуулж, дөрвөн улирал, байгалийн үзэгдлийг нэрлэхийг хүсээрэй.
2. Хүүхдээр байгалийн ямар үзэгдэл үзэсгэлэнтэй сайхан, ямар үзэгдэл сүртэй, аюултай болохыг яриулаарай.

**Дасгал 2.**

Та хүүхдэдээ дараах зохиолыг уншиж өгөөрэй. Боломжтой бол зохиолын бичлэгийг хүүхдэдээ үзүүлээрэй.

*К.Д.Ушинский*

**ДӨРВӨН ХҮСЭЛ**

Митя ууланд чаргаар, гол дээр тэшүүрээр гулгаж, улаан хацарлачихаад, гэртээ ирэн аавдаа: “Өвөл яасан сайхан юм бэ? Би үргэлж л өвөл байгаасай гэж бодох юм.” гэв.

Аав нь: “Чи тэгвэл өөрийнхөө хүслээ миний өврийн дэвтэрт бич.” гэхэд Митя бичжээ.

Хавар болов. Митя ногоон нугаар эрээн эрвээхий дураараа хөөж, цэцэг түүж яваад аавдаа ирж “Энэ хавар яасан гоё юм бэ? үргэлж л хавар байдаг болоосой гэж би хүсэх юм.” гэж хэлэв. Аав нь тэмдэглэлийн дэвтрээ гаргаад, Митягаар өөрийн нь хүслийг бичүүлэв.

Зун болов. Митя аавтайгаа хадланд гарчээ. Хүү бүхэл өдрийн турш загас барьж, жимс түүж, сайхан үнэртэй ногоонд өнхөрч зугаалаад орой нь аавдаа: “Өнөөдөр ч харин дураараа зугааллаа даа. Болдогсон бол дандаа л зун байгаасай билээ?” гэж хэлэв. Митягийн энэ хүсэл ч мөн аавынх нь тэмдэглэлийн дэвтэрт бичигджээ.

Намар болов. Жимсний цэцэрлэгээс улаахан алим, шар лийр түүцгээв. Митя баяр хөөр болж, аавдаа: “Намар ч бүх улирлын хамгийн сайхан нь юм аа.”

гэжээ. Аав нь өөрийнхөө тэмдэглэлийн дэвтрийг гаргаж, түүнд өвөл, хавар, зуны тухай мөн л ингэж ярьдаг байсныг үзүүлжээ.

1. Хүүхэдтэйгээ доорх асуултаар ярилцаарай.
  - Аавын дэвтэрт Митягийн хэдэн хүсэл бичигдсэн бэ?
  - Митя ямар улиралд дуртай вэ? Яагаад?

**САНАМЖ**

- Хүүхдийн яриаг сонсон дэмжиж, хамтдаа ярилцаарай.
- Хүүхдэдээ цаг агаарт тохируулж хувцаслахгүй бол өвдөх аюултайг хэлж ойлгуулаарай.

## НАР БА СҮҮДЭР

### Зорилго:

- Хүүхэд “Нар, салхи” зохиолоос тэдний ялгааг мэдэх
- Хүүхэд солонго үүсгэх туршилт хийх, солонго будах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №16 - “Хоёр нар” дуу
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Дараах зохиолыг уншиж өгөөрэй. Дараа нь асуултын дагуу ярилцаарай.

*Л.Толстой*

### НАР САЛХИ

Нар салхи хоёр маргалдаж, хэн нь урьтаж хүний хувцсыг тайлуулж чадахаа үзэхээр болжээ. Салхи хүний хувцсыг хуу татахаар үлээж гарав. Салхи хүний малгай, дээлийг хичнээн дэрвүүлсэн ч тэрээр малгайгаа дарж өмсөөд хормойгоо хумьчихсан учир салхи хувцсыг нь тайлж чадсангүй. Нарны ээлж болоход хүчтэйхэн ээв. Хүн товчоо тайлж, малгайгаа гэдрэг болгов. Нар бүр хүчтэй төөнөхөд хүн хувцсаа тайлжээ.

- Нар юу хийсэн бэ?
- Салхи юу хийсэн бэ?
- Нар, салхи хоёрын нөлөөнд хүн яаж өөрчлөгдсөн бэ?
- Хэн нь хүний хувцсыг тайлуулж чадсан бэ?

### Дасгал 2.

1. Нарны гэрэл, сүүдрийг ажиглуулан, дараах байдлаар тоглуулан туршуулаарай.
  - Солонго яаж үүсэж байгааг ажиглан ярилцана. Нартай өдөр жижиг түмпэнд ус хийж, нар туссан газар тавиад дотор нь толь хийнэ. Зурагт үзүүлсэн шиг цагаан цаасыг толь руу харуулан барина. Нар толь руу тусаад буцаж цаасанд ойно. Цаасыг удаан барихад түүн дээр солонго үүссэн байна. Та үүнийг хүүхэдтэйгээ хамт туршаад үзээрэй.
  - Мөн өөрсдийн гар хуруу, биеэ хөдөлгөхөд сүүдэр яаж даган өөрчлөгдөж байгааг харуулж тоглуулаарай. Юмсын сүүдрийг тэмдэглээд, хэсэг хугацаа өнгөрсний дараа байрлал нь хэрхэн, яаж өөрчлөгдсөнийг ярилцаарай.

**НАР БА СҮҮДЭР**

2. Борооны дараа татсан сайхан солонгыг ажиглан дуурайлган зураарай.

**Дасгал 3.**

Дууны бичлэгийг сонсгоорой. Хүүхдэд давтан сонсгох, хамт дуулах, дагуулан дуулуулах зэргээр сургаарай.

Үг С.Даяндорж Ая Б.Цэвээнсүрэн

**ХОЁР НАР**

Ааваа, би нар зурлаа  
 Адилхан болж уу энэ  
 Ээжээ, би нар зурлаа  
 Ижилхэн болж уу энэ  
     Дэвтэр дээр зурсан нар  
     Дэлхий дээр мандсан нар  
     Угаас ижил хоёр нар  
     Урд урдаасаа харсан нар

Ахаа, би нар зурлаа  
 Адилхан болж уу энэ  
 Эгчээ, би нар зурлаа  
 Ижилхэн болж уу энэ  
     Дэвтэр дээр зурсан нар  
     Дэлхий дээр мандсан нар  
     Угаас ижил хоёр нар  
     Урд урдаасаа харсан нар

Аав ээжийг адилхан гэрэлтүүл  
 Алтан нараа  
 Наран доор бид цөмөөрөө  
 Наадан жаргаж байна  
     Дэвтэр дээр зурсан нар  
     Дэлхий дээр мандсан нар  
     Угаас ижил хоёр нар  
     Урд урдаасаа харсан нар

**САНАМЖ**

- Юмсын туссан сүүдрийг хүрээлүүлэн зурж, бүтээл хийхэд нь тусалж дэмжээрэй.
- Сүүдрийн хэмжээ өглөө, өдөр, оройд хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглуулан, ярилцаарай.

**Зорилго:**

- Хүүхэд шүлгийн утгыг ойлгож, цээжлэн урнаар унших
- Хүүхэд “цас” гэдэг үгийг олон янзаар нэрлэх, шинж тэмдгийг тодорхойлох, үйл үгээр баяжуулах тоглоом тоглох

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн харандаа

**Дасгал 1.**

1. Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой.


*Ж.Дашдондог*

**АНХНЫ ЦАС**

Анхны цас, шинэхэн цас  
 Агаар тэнгэрээс бужигнан орлоо  
 Хөрш айлын хүүхдүүд цөмөөрөө  
 Хөл алдан хөгжилдөн гүйлдэнэ.  
 Шинэхэн орсон сонихон цасыг  
 Өнхрүүлж тойруулж, өвгөн босголоо  
 Том өнхрүүшиндээ толгой залгаад  
 Өндөр цагаан өвгөн босголоо.


**Дасгал 2.**

“Цас” гэдэг үгийг нэр үг, шинж тэмдэг, үйл хөдлөл заасан үгээр баяжуулан тоглуулаарай.





**ЦАС**



**Дасгал 3.**

1. Таван хошуу малын мөрийг олж холбон зураарай. Яагаад ингэж холбосны учрыг тайлбарлуулаарай. (Адуу битүү, үхэр салаа туурайтай байдаг гэх мэт).
2. Хүүхэдтэйгээ цасан дээгүүр явж, мөр гарган тоглож, ажиглуулан ярилцаарай.

**САНАМЖ**

- Хүүхдийг цас цэвэрлэх, зөөх, овоолох ажилд оролцуулаарай.

**Зорилго:**

- Хүүхэд шүлгийн утгыг ярилцах
- Хүүхэд цаасаар дарцаг хийж тоглох
- Хүүхэд түргэн хэллэг хэлж “р, с, ш” авиа тод дуудах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн цаас, саваа мод, цавуу

**Дасгал 1.**

1. Дараах шүлгийг уншиж, өгч ярилцаад тогтоолгоорой.

*Н.Өлзийбат*

**ТУСЧ ХҮҮ**

Өвөөгийн бүрхийг  
 Салхи хийсгэж  
 Өшиглөсөн бөмбөг шиг  
 Өнхрүүлж одлоо  
     Хөл муутай өвөө  
     Малгайгаа гүйцэлгүй  
     Хойноос нь харин  
     Харсаар хоцорлоо ....

Салхи хөлөглөсөн  
 Өвөөгийн малгайг  
 Сайн барьсаар  
 Авчирч өглөө  
     Салхинаас түрүүлдэг  
     Хурдан хүү гэж  
     Өвөө намайг  
     Өхөөрдөн магтлаа

2. Өвөө хүүг яагаад магтсан бэ? асуултын дагуу шүлгийн агуулгыг ярилцаарай.

### Дасгал 2.

1. Зургийг ажиглуулан байгалийн салхинд хийсэж, хөдөлж байгаа эд юмсыг нэрлүүлж ярилцаарай.
2. Аргачлалын дагуу дарцаг хийлгэж, салхины зүг, чигийг тодорхойлж тоглоорой.

### Дасгал 3.

Хүүхдэдээ дараах түргэн хэллэгийг тод, түргэн хэлж сонсгоорой. Дараа нь 2-3 удаа дагуулан давтаж хэлүүлээрэй. Хүүхэд р, л, с, ш авиа орсон үгийг хэрхэн зөв, цэвэр дуудаж байгааг ажиглаж, анхаараарай.

Уулын салхи сэр сэр сэвнэ

Улаан сэрх шир шир хэвнэ

### МЭДЭЭЛЭЛ

- Агаар нэг газраас нөгөө газар руу урсан шилжихэд салхи салхилдаг. Бидэнд салхи харагддаггүй, гэхдээ салхи салхилж байгаа нь мэдрэгддэг.
- Салхи олон төрөл байдаг. Жишээлбэл: Хуй, хар, зөөлөн, халуун, хүйтэн салхи гэх мэт.
- Хүчтэй салхи шуургатай үед болгоомжтой, гэрээсээ хол явахгүй байх нь чухал.
- Монголчууд салхи хөгжөөж исгэрэхийг цээрлэдэг.

**Зорилго:**

- Хүүхэд амьд байгалийг хайрлан хамгаалах тухай ойлгох, зохиолыг өөрийн үгээр ярих
- Хүүхэд ургамал ургах дарааллыг ойлгох, ургамал ургах явцыг зөв дараалалд оруулах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №17 - “Мөчирхөн” өгүүллэг
- Ном, тоглоомын багц
- Хавсралт Хайчилбар № 5
- Балын харандаа, хайч

**Дасгал 1.**

1. Та дараах зохиолыг уншиж өгөөрэй.

*Ч.Лувсандэндэв*

**МӨЧИРХӨН**

Нэг өдөр Болдоо цэцэрлэгт очив. Хаврын урт өдөр наран таатайяа ээж сэвэлзүүр салхи модны мөчрийг хөдөлгөх төдий сэрчигнүүлж, бор бялзуухайнууд энд тэнд жиргэхэд нэг л таатайхан байлаа. Болдоо явсаар нэгэн жижиг зулзаган модны дэргэд очвол хумхиатай байгаа бяцхан навч дэлгэрэх гээд л дөнгөж ан цав гарчихсан харагдах бөгөөд өндрөөрөө түүнээс яльгүй өндөр байв. “Үгүй мөн гоё оо. Үүгээр чинь Баярынх шиг гоё чавх хийе.” гэж тэр бодов. Тэгээд тэр зулзаган модны нэгэн мөчрийг огтолж гарав аа. Гэтэл цэцэрлэгч авгай дэргэд нь ирж:

- За хүү минь яаж байгаа юм бэ? гэж асуугаад Болдоог хариу хэлэхийг ч хүлээлгүй,
- Өөр шигээ хөөрхөн урган өсөж байгаа модыг огтолж болохгүй. Чамайг хутгаар огтолбол өвдөх үү?
- Өвдөнө.
- Цус гарах уу?
- Гарна.
- Тэгвэл энэ модноос шүүс гарч байна уу?
- Тиймээ.
- Энэ мод та хоёр яг адил бага балчир байна шүү дээ.
- Энэ олон өндөр модыг эцэг эх нь гэж бодож болно.
- Тэгэхлээр хүүхдийнх нь нэг мөчрийг ёо, ёо болгочихож дээ. Чи үүнээс хойш битгий ингэж байгаарай гээд явчихжээ.

Болдоо тасалж авсан мөчрөө нэг хараад, зулзаган модоо нэг хараад жаахан бодол болов. Нээрээ л тусгүй юм болж дээ. Тэгээд ингэж шийдэв. “Огтолж авсан мөчрөө байранд нь цавуугаар наагаад үлдээчихье, хөөрхий мөчир ургаг” гэж санаад бушуухан гүйж гэртээ харив. Мөчиртөө цавуу түрхэж нөгөөх байранд нь тогтоох гэсэн чинь ер тогтсонгүй.

Өглөөнөөс үд болтол Болдоо оролдоод болсонгүйд: “Өө энэ мөчир надад гомдчихоод ингэж байна. Яаж аргадыя даа.” гэж бодсоноо урьд гараа эсгэхэд ээж нь түүнийг маарлаар боож тогтоосноос хойш эдгэснийг санаж, хариад маарал авчрав. Тэгээд ээж шигээ мөчрийг үлээж: “Удахгүй эдгэнэ. Мөчирхөн минь. Битгий гомд.” гээд боов. Түүнээс хойш Болд мөчрөө боолгосон модны дэргэд байн байн ирж “Ургаж байна уу, үгүй юу? Эдгэх нь үү, үгүй юу?” гэж хардаг байв. Гэвч ургасангүй. Олон хоног өнгөрчээ, харин бусад мөчрийн навч цөм дэлбээлж гүйцээд байхад боолттой мөчирхөн уйтгартай нь аргагүй хатаж ганджээ.

1. Зохиолд юуны тухай өгүүлснийг ярилцаарай.
  - Огтлогдсон мөчир яагаад дахин ургаагүй вэ?
  - Чавх ямар хэрэгтэй юм бол?

## Дасгал 2.

Хүүхэдтэйгээ хамтдаа дараах тоглоомоор тоглоорой. Тоглох арга, дүрмийг тайлбарлаж өгөөрэй.

### МИНИЙ ТАРЬСАН МОД

(Хөзрөн тоглоом)

#### Тоглоомын дүрэм:

- Номын хавсралтаас зургаа хайчилж авна.
- Хүүхдүүд хөзөр болгосон зургаа ээлжлэн авна.
- Найз нөхөдтэйгөө хамтран ярилцана.

#### Тоглоомын явц:

Тоглоомд 2-3 хүүхэд оролцоно. Хүүхдүүд бэлдсэн хөзрөн зургаа нэг нэгээрээ ээлжлэн тавина. Ургамал ургах явцыг харуулсан зургийг дарааллаар нь байрлуулж, ярилцана.

#### МЭДЭЭЛЭЛ

- Газар сэндийлэх, мод ургамал таслахыг цээрлэнэ.
- Ганц мод бариад гэрт орохыг цээрлэнэ. Үл хэрэгсвээс модоо барьсан гуйлгачны шинж үзүүлнэ муу хэмээнэ.
- Гантай жил хуурай өвс, бут, модтой газар гал түлэх, түүдэг асаахыг цээрлэнэ. Үл хэрэгсвээс гал алдана, түймэр тавина гэдэг.

**Зорилго:**

- Хүүхэд улирал, цаг агаартай холбоотойгоор навч өөрчлөгддөг тухай мэдэх
- Хүүхэд навчийг давтамжтай байрлуулж, зүй тогтлыг мэдэх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №18 - “Навчис” зохиомж
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №19 - “Алтан навчис” дуу
- Төрөл бүрийн мод, цэцэг, ургамлын навчны зураг

**Дасгал 1.**

1. Та хүүхдээр зураг дээрх моддын навчсыг ажиглуулаад, нэрлүүлээрэй.
2. Модны навч, шилмүүсийн өнгө, хэлбэр, хэмжээ, зах хүрээ ямар байгааг асууж яриулаарай.
3. Ургамлын навчис улирал, цаг агаараас шалтгаалан хэрхэн хувирч өөрчлөгддөгийг харуулсан “Навчис” бичлэгийг үзүүлж ярилцаарай.
  - Зуны навч номин ногоон, намар алтан шаргал, улаан шар өнгөтэй болдог, намар орой навчис гандаж хатаж унадаг; өвөл мод нүцгэрч, хавар болоход шинэхэн навчис нахиалан дэлгэрдэг тухай
  - Мод, ургамлын навчийг түүж цаас, номон дунд хавчуулан хатаагаад наамал хийж болдог тухай
  - Ногоон, хатаж шарласан навч ялгаатай гэх мэт.

**Дасгал 2.**

Та загварыг хараад, хүүхдэдээ төрөл бүрийн навч зурж өгөөрэй. Хүүхэд навчийг будаж номын хавчуурга хийнэ.

**Дасгал 3.**

Дараах дууг сонсгоод зааж сургаарай. Бичлэгийг давтамжтай сонсгож, утга санааг нь ярилцаарай. Дууны үгийг мөр мөрөөр, бадаг бадгаар нь зөв, тод хэлж цээжлүүлнэ. Хүүхэдтэй юуны тухай дуулж байгааг ярилцаарай.

Үг, О.Сундуй

Ая, Б.Цэвээнсүрэн

**АЛТАН НАВЧИС ДААРАА ЮМ УУ**

Мөчир мөчрөө орхин

Шаргал навчис уналаа

Мөнгөн цасны түрүүчээр

Ийш тийшээ гүйлдлээ

Алтан шаргал навчис минь

Алган дээр минь буугаарай

Намрын салхинд даарсан

Навчис бүхэн дулаацаарай

Бөмбөн бөмбөн өнхрөөд

Бөмбөрч цаашаа одлоо

Шариган шариган дуугараад

Сандарч цаашаа яарлаа

Алтан шаргал навчис минь

Алган дээр минь буугаарай

Намрын салхинд даарсан

Навчис бүхэн дулаацаарай

Улбар улбар навчис

Улам улам дэгдлээ

Ачлал нөмөр үгүйлэн

Арван зүгтээ хийслээ

Алтан шаргал навчис минь

Алган дээр минь буугаарай

Намрын салхинд даарсан

Навчис бүхэн дулаацаарай

**САНАМЖ**

- Хүүхдэдээ өдөр тутмын ажил хөдөлмөрийн явцад орчныхоо цэцэг ургамлыг ажиглуулан, цаг агаараас хамааран хувирч өөрчлөгдөж байгаа учир шалтгааныг тайлбарлан яриулж байгаарай.

**Зорилго:**

- Хүүхэд цэцгийн нэр тогтоох, таньж ялгах, цэцгийн гадаад бүтцийг нь нэрлэх
- Хүүхэд зүй тогтлыг олох, давтамжтайгаар дүрсийг зурах
- Хүүхэд гарын сарвуу, тохойны хөдөлгөөнийг дэмжсэн хэмнэлтэй дасгал хийх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

Та орон нутагтаа ургадаг өөрийн мэддэг цэцгийг хүүхдэдээ ажиглуулан нэрлэж өгөөрэй.

Цэцгийн иш, навч, дэлбээ, дохиур гэсэн гадаад бүтцийг нэрлүүлж, ач холбогдлыг хэлж өгөөрэй.

**Дасгал 2.**

1. Та хүүхдээрээ зураг дээр байгаа гурван цэцгийн доор ямар дүрс байгааг сайн ажиглуулаарай.
2. Цэцэг бүрд харгалзах дүрсийг зуруулаарай.

**Дасгал 3.**

Хүүхэдтэйгээ хамтдаа дараах тоглоомоор тоглоорой. Тоглох арга, дүрмийг тайлбарлаж өгөөрэй. Үгийг нь хөдөлгөөнтэйгөө хослуулахад анхаараарай.

**ТАШ ТАШ**

“Цэцэг, цэцэг” гэж хэлэхдээ гарыг тохойгоор нугалан дээш өргөж сарвууг хөдөлгөж “Таш таш” гэхэд алга ташна.

“Цацаг, цацаг” гэж хэлэхдээ гарын сарвууг доош буулган цацаг мэт хөдөлгөж “Таш таш” гэхэд алга ташна.

- Цэцэг цэцэг таш таш
- Цацаг цацаг таш таш
- Цэцэг таш
- Цацаг таш
- Цэцэг цацаг таш

**САНАМЖ**

- Та хүүхдээ хөдөлгөөнөө хянаж сурахад нь туслаарай.



**Зорилго:**

- Хүүхэд “Мөөг” зохиолыг сонсох, асуултад хариулах, өөрийн үгээр ярих
- Хүүхэд мөөгийг баримлаар барих, толбыг будах зэрэг дүрслэн урлах үйл хийх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №20 - Мөөгөн болон цэцгэн малгай
- Улаан, шар өнгийн харандаа

**Дасгал 1.**

1. Та хүүхдэдээ дараах зохиомжийг уншиж өгөөрэй.

**МӨӨГ**

Манай нутагт мөөг элбэг ургадаг. Нэгэн өдөр нартай солонго татуулсан намираа зөөлөн бороо орлоо.

Борооны дараа Наран бид хоёр мөөгөнд явлаа. Ээж бидэнд: “Мөөгний үндсийг үлдээж түүгээрэй, үндэстэй нь ухаж түүвэл дахиад ургахгүй шүү.” гэж захив.

Наран бид хоёр жижиг сав дүүрэн мөөгтэй ирэв. Бид түүсэн мөөгөө угааж, өрөмтэй хуурч идэхээр бэлтгэв.

Ээж хэдэн мөөгийг ялган авч, бусдыг нь хуурахаар хэрчив. Тэгээд ялгаснаа харуулж энэ чинь иддэг мөөг биш, тэнгэрийн дүлий гэдэг юм. Ямар ялгаатай байгааг хардаа гэв.

Үнэхээр өөр байлаа. Бид тэнгэрийн дүлийг мөөгнөөс ялгаж таньдаг болов.

2. Зохиомжийн агуулгыг дараах асуултаар ярилцаарай.

- Яагаад “Тэнгэрийн дүлий”-г ялгаж авсан юм бол?
- Хортой, хоргүй мөөгийг хэрхэн таньж болох вэ?

**Дасгал 2.**

1. “Мөөг” сэдэвт баримал барих
2. Мөөгний зургийг ажиглуулж, ижилхэн болгож будуулаарай

**МЭДЭЭЛЭЛ**

Мөөг хурц, гоё өнгөтэй байх тусмаа хортой байх магадлал өндөр.

Хортой мөөгийг таних энгийн арга:

- Мөөгийг зүсэж наранд тавихад хэсэг хугацааны дараа өнгө нь хувирч эхэлдэг.
- Хортой мөөг чанасан уусмалд мөнгөн халбага хийж үзэхэд харладаг.

Мөөг хөгшрөхөд түүнд агуулагдаж буй бодисууд задарч эхэлдэг учир удаан хадгалсан хүнсний мөөгөнд ч хордож болох талтай.

## АМЬТАД

### Зорилго:

- Хүүхэд гэрийн тэжээмэл болон зэрлэг амьтдыг ялгах
- Хүүхэд гар хуруугаараа сүүдэр зураг үүсгэж, тоглох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа

### Дасгал 1.

1. Хүүхэд зураг дээрх амьтдыг ажиглаж нэрлэнэ.
2. Эдгээр амьтад хаана амьдардаг, юугаар хооллодог тухай ярилцаад, холбож зураарай.

### Дасгал 2.

1. Та хүүхэдтэйгээ гар хуруугаараа сүүдэр зураг үүсгэж, тоглоорой.
2. Амьтдыг юугаар нь таньсныг асууж яриулаарай. Тухайлбал: Туулайг урт чихээр, бугыг эврээр нь таньсан гэх мэт. Энэ амьтныг харж байсан уу?, Хаана харсан бэ? Хамгийн том, хамгийн жижиг ямар амьтныг мэдэх вэ? зэргээр ярилцаарай.

### Дасгал 3.

Үг О.Сундуй, Ая Б.Цэвээнсүрэн "Алтан навчис даараа юм уу" дууг давтаарай.

### МЭДЭЭЛЭЛ

Эх туулай бүжингээ төрүүлээд нэг л удаа өтгөн сайхан сүүгээ хөхүүлээд бутны ёроолд хаяад явчихдаг амьтан учраас “Алиа хөөрхөн хүү” нь эх туулай, “Аяга” нь бөжин гэх мэтээр оньсогыг тайлбарлан ярилцаарай. Хэрэм 3-15 метр өндөрт модны хонгилд үүрээ засдаг, дуртай хоол нь самар, шилмүүст модны үр, мөөг, нахиа, модны холтос, жимсээр хооллодог. Гоёмсог, сагсгар сүүл нь модноос дүүлэн нисэхэд биеийг тэнцүүлж өгдөг. Үр зулзагыг нь хувдай гэж нэрлэдэг бөгөөд эх хэрэм ганцаараа асарч тэжээдэг. Үнэгний зулзагыг гавар гэдэг. Модны хонгил, агуйд амьдардаг. 1-10 гавар төрүүлдэг. 14-20 жил амьдардаг. Хүүхдэдээ нутгийнхаа амьтдын тухай ярьж өгөөрэй.

## АМЬТДЫН ЦЭЦЭРЛЭГ

### Зорилго:

- Хүүхэд шүлгийг сонсоод, зохиолч шүлгээ яагаад “Ээж” гэж нэрлэсэн тухай ярих, амьтдын үр төлийн нэрийг тогтоох
- Хүүхэд амьтдыг шүлэгт гарсан дарааллаар нь дугаарлан цифрийг бичих

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хавсралт -Наадаг зураг № 7

### Дасгал 1.

1. Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой.

*Т.Галсан*

### ЭЭЖ

Хараач  
 Ойн цэцэрлэг тарж байна  
 Хаа сайгүй орон гэрээ зорьж явна  
 Өөдөсхөн зараа жаахан тэрэг түрж явна  
 Өргөстэй хоёр бут задгай бүхээгээс цухуйж явна  
     Хөх чоно ав адилхан зургаан бэлтрэгээ  
     Гүзээнд хийгээд амандаа зууж явна.  
     Байрныхаа дөрвөн илийг цөмөөрөнг нь  
     Бяртай согоо нуруун дээрээ үүрч явна

Амьсгаадсаар туулай

Сүйх тэрэг чирч явна.

Арван дэлдэн чих

Сүйхэн дотроос дэлдэгнэж байна

    Үр ачаа зөөж яваа амьтан бүхэнд би

    Өөрийнхөө ээж шиг, эмээ шиг хайртай

2. Шүлгийн утгыг дараах асуултаар ярилцаарай.

- Шүлгийг яагаад “ЭЭЖ” гэж нэрлэсэн юм бол?
- Хэрвээ “Амьтдын цэцэрлэг” гэж байсан бол амьтад үр төлөө өгөх байсан болов уу?
- “Амьтдын цэцэрлэг”-ийн багш хэн байх бол?

### Дасгал 2.

1. Амьтдыг шүлэгт гарсан дарааллаар нь дугаарлаарай. Дугаарыг ○ дүрсэнд тэмдэглээрэй.
2. Бөжингүүдэд юу дутуу байна вэ? Сүйхэн дотор хэдэн бөжин байсан бол? Хавсралтад байгаа наадаг зурагнаас олж гүйцээгээрэй.

### МЭДЭЭЛЭЛ

Туулайн сонор, мэдрэмтгий дэлдэн чихийг судалж байж хүн төрөлхтөн тавган болоод дамжуулах антенн бүтээсэн түүхтэй.

## БАМБАРУУШ

### Зорилго:

- Хүүхэд, бамбарууш яагаад өөрийгөө бодсон, дүүгээ шоглосон зан ааш гаргаж байгааг тодорхойлон ярих
- Хүүхэд, бамбаруушаа өнгө ялгаж будахдаа шооны өнгийг сайн ажиглаж ижил өнгөөр будах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Өнгийн харандаа
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Дараах зохиомжийг уншиж өгч ярилцаарай.

#### Хэнэггүй бамбарууш

Толгой нь өвдөж ядарсан ээжийгээ  
 Тоолгүй бамбарууш хоол нэхэв.  
 Харанхуйгаас айдаг дүүгээ  
 Хаалганы ард орхин  
 Хачин чимээ гаргаж  
 Хэнэггүй бамбарууш шоглов  
 Дүүгээ асраад завгүй найзыгаа  
 Дэндсэн бамбарууш тоглоё гэж шалав

2. Бусдыг хүндлэх гэдгийг ардын уламжлалт ёсонд хэрхэн зүйрлэж ирсэн талаар ярилцаарай.

Ахаа алд (👦) хүндэл

Дүүгээ дэлэм (👧) хүндэл зүйр үгийг хэлж өгнө.

### Дасгал 2.

Бамбаруушийн зургийг ажиглуулаад шооны нүдний тоо, түүний өнгийн дагуу будуулаарай.

### САНАМЖ

- Та хүүхдэдээ бусдыг хайрлах, туслах, ойлгоход үлгэр дуурайл үзүүлээрэй.
- Хүний тусыг ойлгож, бусдад туслахыг дэмжээрэй.

## ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТАД

### Зорилго:

- Хүүхэд, зэрлэг ба гэрийн тэжээвэр амьтдыг ялгах
- Хүүхэд, амьтдыг нэрлээд хөдөлгөөнийг хийх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хөгжим, CD

### Дасгал 1.

1. Зургийг ажиглуулан амьтдыг нэрлүүлээрэй. Зургаас гэрийн тэжээвэр амьтдыг олж дугуйлуулаарай.

### Дасгал 2.

Хүүхдийнхээ сайн мэдэх хэмнэлт ая эсвэл дуртай дууг нь сулхан тавиарай. Та хөгжмийн аянд амьтдын нэрнээс ээлжлэн хэлэхэд хүүхэд тохирох хөдөлгөөнийг хийнэ.

## АМЬТДЫН ХӨДӨЛГӨӨН

(Тоглоом)

### Тоглоомын дүрэм:

- Хэлж байгаа үгийг анхааралтай сонсоно.
- Амьтдын хөдөлгөөнийг аргачлалын дагуу дуурайн хийнэ.

### Аргачлал:

- Туулай – Хоёр гараа урдаа нугалан барьж дэгдэн харайна.
- Морь – Хөлөө ээлжлэн шал товшино.
- Үхэр– Хоёр гарыг дээш өргөж баруун, зүүн тийш ээлжлэн хазайна.
- Шувуу – Гараа алдлан дэлгэж, нисэх мэт хөдөлгөөн хийнэ.
- Гахай – Нэг гараа атган хамран дээрээ барьж, нөгөө гарын долоовор хуруунаас бусдыг атган сүүл болгон бариад дороо эргэлдэнэ.
- Нохой – Хоёр гараа цээжний харалдаа урагш тохой, бугалгаар нугалан хэлээ унжуулна.
- Тахиа – Хоёр гарыг нурууны ард зөрүүлэн барьж, мөрөө урагш хойш хөдөлгөн өвдөг өндөр алхана.

### САНАМЖ

Гэрийн тэжээмэл амьтдыг эрүүл байлгах нь гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндтэй холбоотой төдийгүй, тухайн орчны эрүүл ахуй, ариун цэвэртэй холбоотой юм. Тиймээс та гэртээ нохой муур, жижиг амьтан тэжээдэг бол мал эмнэлгийн хяналтад тогтмол байлгаж, урьдчилан сэргийлэх тарилга, туулгалтыг тогтмол хийлгэн, өвчний шинж мэдэгдсэн даруй эмчид үзүүлж байх хэрэгтэй.

## ХОТОЧ НОХОЙ

### Зорилго:

- Хүүхэд шүлгийн утгыг ойлгон цээжлэх
- Хүүхэд сэдэвт зураг зурах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Зургийн дэвтэр, өнгийн харандаа

### Дасгал 1.

1. Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад, тогтоолгоорой.

*Н.Доржсүрэн*

### ХОТОЧ НОХОЙ ЮУ ГЭЖ ХУЦАВ?

Хавийн бараа харагдахгүй  
Харий бүрий болжээ  
Хонь мал хотолсон байхад  
Хоточ нохой юунд хуцав?

Ганц нэгээрээ мал  
Гадаа хөдөө хоцорчих вий  
Дуу чимээг минь сонсоод  
Дулаан хэвтэртээ ирэг гэж

Холын чимээ анирлан  
Хоточ нохой хуцдаг юм

Хав харанхуй шөнөөр  
Харагдах бараагүй байхад  
Хон хон дуугарч  
Хоточ нохой юунд хуцав?

Эрлийн хүн төөрч  
Эзгүй хээр хонох вий

Манайх энд байна шүү гэж  
Малчин эзнийдээ урин  
Хоточ нохой хуцдаг юм  
Холын зочноо угтдаг юм.

### Дасгал 2.

Гэрийнхээ нохойны тухай ярилцаарай. “Би нохойтойгоо хамт” сэдвээр зураг зураарай. Нохой зурах аргачлалыг ашиглаж, зургаа баяжуулахад нь туслаарай. Зургаа ашиглаж, шүлгийн утга санааг ярилцаарай.

### САНАМЖ

- Нохойгоо нэрээр нь дуудах, аятай зөөлөн харьцах, уурлуулахгүй байхыг сануулаарай.
- Нохойны биед хүрсний дараа гараа угааж хэвших, хазахаас нь болгоомжлох, ам руу нь гараа ойртуулахгүй, айлын болон тэнэмэл нохой руу хамаагүй ойртож очихгүй байхыг сануулаарай.

## ТООЧИН ГӨЛӨГ

### Зорилго:

- Хүүхэд нэрлэсэн тоог олох, бөмбөлгийг тохирох цифртэй холбох
- Хүүхэд харандааг өгсөх дарааллаар дугаарлах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Балын харандаа
- 1-10 тооны дүрс
- Шагай 50 ширхэг
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхдээрээ дасгалын зургийг ажиглуулаарай.
2. 1, 3, 5, 7, 9 дэх тоотой бөмбөлгийг олж, нохойтой холбож, зуруулаарай.

### Дасгал 2.

Та хүүхдээрээ зураг дээр байгаа харандааг тоолуулж, хамгийн богино харандаанаас нь эхлэн дарааллын дагуу дугаарлуулаарай.

### САНАМЖ

- Та хүүхдэд тоог нүдлүүлэхдээ оноож, тоолуулж сургаарай

**Зорилго:**

1. Хүүхэд баримлыг туулай хийхэд хэрэгтэй хэмжээгээр нь хуваах, хуваасан баримлаа бөөрөнхийлэн, зууван болгож, туулай барих

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Баримлын шавар, ажлын болон бүтээлийн суурь хулдаас, шавар зүсэгч (нэг удаагийн хуванцар хутга)
- Ном, тоглоомын багц

**Дасгал 1.**

1. Эхний зургийг ажиглуулаад хүүхдээр мэддэг биет дүрсийг нь нэрлүүлээрэй. Хүүхдэд шавраар хийсэн дүрсээ бүтээлийн суурь хулдаас дээр тавихыг зөвлөөрэй.
  - Гэрт эдгээр дүрстэй ижил юу байна вэ?
  - Бөөрөнхий, шоо дөрвөлжин дүрсээр юуг дүрсэлж болох вэ? зэргээр ярилцаарай.
2. Хүүхдээр баримлын шавраар бүтээл хийхэд ашигладаг багаж хэрэгслийг нэрлүүлж, хэрхэн хэрэглэх тухай ярилцаарай. Тухайлбал: Баримлын шавар, ажлын суурь хулдаас, шавар зүсэгч, гарын алчуур гэх мэт.
3. Зургийг ажиглуулж, туулайны их бие, толгой, дөрвөн хөл, сүүл ямар хэлбэр, хэмжээтэй болохыг ярилцаарай.
4. “Туулай”-г баримлын шавраар дуурайлган бариулаарай.
5. Барьж хийсэн “Туулай”-г бүтээлийн суурь (хатуу цаас) дээр байрлуулаад бут, өвс нэмж дүрслэн чимэглэхийг зөвлөөрэй.

**Дасгал 2.**

Н.Доржсүрэн “Хоточ нохой” шүлгийг давтаарай.

**САНАМЖ**

- Шавраар нямбай ажиллуулахаас гадна хийж дуусаад гарыг нь сайтар савандаж, угаалгаж хэвшүүлээрэй.



## БОР ТУУЛАЙ

### Зорилго:

- Хүүхэд алчуураар туулай эвхэх дарааллын дагуу эвхэж тоглох
- Хүүхэд “Туулай дэгдүүлдэг” аман наадам хэлэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цагаан эсвэл бор өнгийн алчуур
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

1. Та хүүхдэдээ зураг дээрх аргачлалын дагуу алчуураар туулай эвхэхэд туслаарай.
  - Гурвалжин хэлбэртэй нугалж, хуйлж орооно.
  - Үзүүрээс 1 см хэмжээтэй үлдээж хуйлна.
  - Зүүн баруун талын үзүүрийг нийлүүлж, тэнцүү нугална.
  - Хоёр үзүүрийг дээш нугална.
  - Дээш нугалсан үзүүрийг 4 см урттай илүү гаргана.
  - Амны доогуур уяа болон резинээр боож өгнө.
  - Амны хэсгийн 2 үзүүрийн доод талынхыг дотогш түлхэж оруулна.
  - Үлдсэн үзүүрийг бага зэрэг татан дотогш нугална.
  - Толгойн ар талын 2 үзүүрийг чангалан хэлбэржүүлж, чих хийх ба амны хэсгийн 2 үзүүрийг бага зэрэг нээж өгнө.
  - Туулай бэлэн боллоо.
2. Хүүхэд санаачилгаараа өөр амьтан эвхэж дүрслэхийг дэмжээрэй.

### Дасгал 2.

Хийсэн туулайгаа ашиглан дараах аман наадмаар наадахыг нь дэмжээрэй.

### ТУУЛАЙ ДЭГДҮҮЛДЭГ АМАН НААДАМ

Туулай туулай тонгос  
 Туулайн бөгс ондгос  
 Хоёр чих нь дэлдгэс  
 Хоёр нүд нь бүлтгэс

### САНАМЖ

- Та хүүхдэд алчуурын ирмэг, өнцгийг давхцуулж, амьтдыг нямбай эвхэхийг зөвлөөрэй.
- Дүр бүтээж тоглох нь хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлдэг учраас тэдний хийж буй үйлийг дэмжээрэй.

## ӨНДӨГ БА ТАХИА

### Зорилго:

- Хүүхэд оньсого таах, зүйрлэлийг ойлгох
- Хүүхэд амьтны хөгжлийн үе шатыг мэдэх, дэс дарааллыг олох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хавсралт - Наадаг зураг № 8
- Цавуу, хайч, өнгийн харандаа

### Дасгал 1.

1. Та хүүхдээрээ оньсого таалгаж, тогтоолгоорой. Яагаад “мөлгөр”, “мөнгөн” гэж хэлсэн болохыг санамжаас харж тайлбарлаж өгөөрэй.

Мөлгөр хүү

Мөнгөн өнгөтэй (өндөг)

### Дасгал 2.

Хавсралтын цуврал зургуудыг ажиглан тохирохыг сонгон авч хоосон нүдэнд нааж ярилцаарай.

### Дасгал 3.

Зургийг ажиглуулж ярилцаарай. Хэдэн дэгдээхий байгааг тоолуулан, тохирох өнгөөр будуулаарай.

### САНАМЖ

Мөлгөр – хурц ирмэг, ир байхгүй зүйл

Мөнгөн – цагаавтар өнгө

Хүүхэд зургийг харж ойлгон бие дааж дарааллаар нь байрлуулах, бүтээх, тоолоход дэмжлэг үзүүлээрэй.

**Зорилго:**

- Хүүхэд амьтны хөгжлийн үе шатыг мэдэх, дэс дарааллыг олох
- Хүүхэд цаасаар "Загас" эвхэж тоглох

**Бэлтгэх зүйл:**

- "Би чадна" дасгал ажлын дэвтэр
- Өнгийн цаас, бичгийн төмөр үдээс буюу хавчаар
- Соронз, саваа мод (Савх байж болно.)
- Наадаг зураг №9

**Дасгал 1.**

Хавсралтын цуврал зургуудыг ажиглан тохирохыг сонгон авч хоосон нүдэнд нааж ярилцаарай.

**Дасгал 2.**

Та хүүхдээрээ загас эвхэх дарааллыг эхлээд, дараа нь, хамгийн сүүлд яаж нугалах вэ? гэсэн дөхүүлэх асуултын дагуу ажиглуулаарай. Хүүхэд дарааллын дагуу бие дааж, эвхэж сурахад туслаарай. Та өөрөө эвхэж өгөхөөс татгалзаарай. Хүүхдийг уснаас загас барьж тоглуулаарай.

**Тоглохдоо:**

- Цаасаар эвхсэн загасаа бичгийн хавчаараар хавчих, эсвэл үдээсээр үднэ.
- Нарийн савх модны үзүүрт утас уяад, утсандаа соронз бэхэлж загасны уурга хийнэ.
- Уургаараа загас дэгээдэж тоглоно.
- Хэрэв соронз байхгүй бол наалдамхай тууз (скоч)-ыг уурганы үзүүрт бэхлээд тоглож болно.

**САНАМЖ**

- Орон нутагт байгаа гол ус, нуурын усны загас жараахайг ажиглуулахдаа болгоомжтой байхыг сануулаарай.
- Бичгийн хавчаар, үдээс зэргийг амандаа хийхгүй байхыг сануулаарай.

## ШУВУУД

### Зорилго:

- Хүүхэд шувуудыг нисдэг, нисдэггүйгээр нь ангилах
- Хүүхэд зохиолын утгыг ойлгон, зан чанарын тухай ярилцах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Ном, тоглоомын багц
- Наадаг зураг №10

### Дасгал 1.

Зургийг ажиглан шувуудын талаар ярилцаарай.

Шувуудыг нисдэг, нисдэггүйгээр нь ангилан хүснэгтэд наагаарай.

### Дасгал 2.

1. Дараах зохиол уншиж өгөөрэй.

*Х.К Андерсен*

### НУГАСНЫ МУУХАЙ ДЭГДЭЭХИЙ

Нэгэн өвсөн үүрэнд долоон өндөг байжээ. Зургаан өндөг нь жижигхэн, харин голд нь байх нэг өндөг бусдаасаа илүү том юмсанжээ. Өндөгнүүд нэг нэгээрээ ан цав гарч хагарч эхэлжээ. Жижиг өндөгнөөс гарч ирсэн дэгдээхийнүүд нь зөөлөн өдтэй, бас “Жив, жив” гэж жиргэдэг гэнэ.

Ээж нугас долоо дахь өндгөө хагарахыг хүлээгээд л, хүлээгээд л байж гэнэ. Эцэст нь долоо дахь өндөг хагарч гэнэ. Бусдыгаа бодвол маш том, удаан мөлхдөг, хөвсгөр өдтэй тэр дэгдээхий бусадтайгаа огт адилгүй байлаа.

Түүнийг ах, эгч дэгдээхийнүүд: “Чи бол царай муутай” гэж шоглоход, тэднийг ээж нугас: “Чимээгүй бай!” гэж зэмлээд “Та нар бүгдээрээ миний хөөрхөн дэгдээхийнүүд, гаднаасаа ч тэр, дотроосоо ч тэр үзэсгэлэнтэй.” гэж хэлэв.

Ээж нугас дэгдээхийнүүддээ өдөр бүр хичээл зааж өгч байв. Эхний өдөр өвсөн дунд хэрхэн нуугдахыг зааж өгөв. Зургаан дэгдээхий сайн нуугдаж байсан боловч царай муутай нугасны дэгдээхий нуугдахад хэтэрхий том байлаа.

Дараа өдөр нь ээж нугас тэдэнд ус руу хэрхэн доош шумбах, хэрхэн жижиг загас барихыг зааж өглөө. Түүнийг усны ургамал замагнаас зажилж эхлэхэд ах эгч нугасны дэгдээхийнүүд түүний урт хүзүүг болон ховдоглохыг шоолон инээлдлээ.

Гурав дахь өдөр тэдэнд хэрхэн нисэхийг зааж өгөв. Ээж нугас тэдэнд "Та нар дээш хөөрөхдөө, мөн газар буухдаа маш чимээгүй байх ёстой, тэгвэл биднийг анчид сонсож чадахгүй." гэж болгоомжлуулав. Гэтэл удалгүй нугасны муухай дэгдээхий агаарт гарчихсан хошуугаараа чанга дуу гарган жиргэж байлаа.

Гэртээ ирснийхээ дараа тэр шөнө нь нугасны муухай дэгдээхий сэтгэлээр унаж гэнэ. "Би юуг ч зөв хийж чадахгүй юм байна." гэж боджээ. Бүх нугасны дэгдээхийнүүдийг унтсан хойно тэр цөөрөм рүү буцаж очоод олон өдөр, олон шөнө аялжээ. Тэр өсөж томорсоор өөрөө ч гайхахаар үзэсгэлэнтэй болсон байв.

Нэгэн өдөр алсаас ер бусын дуу сонсогдож олон нугас, галуунууд ямар нэгэн аюулаас зугтаж байхыг харж гэнэ.

"Анчид ирж байна!" гэж нугас гуаглав. Үзэсгэлэнтэй цагаан хун өөрийн төрсөн гэртээ буцаж нисэн ирэв. Ээж болон ах эгч нугаснууд нь түүнийг хараад уулга алдацгаав. Би царай муутай юм чинь тэдний уулга алдах нь зөв гэж тэр боджээ.

Тэр цөөрөмдөө дахин хөвж байхдаа усны толион дээрх өөрийнхөө дүрсийг харлаа. Тэр одоо нугасны муухай дэгдээхий биш үзэсгэлэнтэй сайхан хун болжээ.

Чанга яригчийн дуунаар нугаснууд гүйлдэн ирж, өвсөн дунд түүний далавчны ард нуугджээ. Анчид ч нугаснуудыг харалгүй явж өнгөрөв. Зургаан нугас үзэсгэлэнтэй цагаан хун дүүдээ талархав.

Нугаснууд үзэсгэлэнт хун шувууг шоглож байсандаа уучлалт гуйж, өөр ямар ч шувууг шоглож байхгүй гэж амлав. Ингээд бүх нугаснууд үзэсгэлэнт цагаан хунтай үргэлж хамтдаа аз жаргалтай амьдарч гэнэ.

2. Үлгэрийн санааг тодруулж зургийг ашиглан дараах асуултаар ярилцаарай.
  - "Нугасны муухай дэгдээхий" ямар шувуу байв?
  - Ээж нугас дэгдээхийнүүдэд юу гэж хэлсэн бэ?
  - Нугаснууд ямар учраас уучлалт гуйж, амлалт өгсөн бэ?
  - Бусдыг шоолж, шоглох зөв үү? Буруу бол яагаад?
3. Хүүхэдтэйгээ хүнтэй эелдэг харилцах, найз нөхдөө хүндэтгэх, эв найртай байх сайхан зан чанарын талаар ярилцаарай.

**Зорилго:**

- Хүүхэд амьтны хөгжлийн үе шатыг мэдэх, дэс дарааллыг олох
- Эрвээхийний үр хөврөл өмнөх амьтдаас ямар ялгаатайг харьцуулах

**Бэлтгэх зүйл:**

- "Би чадна" дасгал ажлын дэвтэр
- "Өлссөн Авгалдай" зохиол

**Дасгал 1.**

Зургийг ажиглан эрвээхийн амьдралын мөчлөгийн тухай ярилцаж дугаарлаарай.

**Дасгал 2.**

"Өлссөн авгалдай" зохиолыг уншиж өгөөрэй

**"Гэдэс нь өлссөн авгалдай"**

(Америкийн хүүхдийн зохиолч, зураач Эрик Карл)

"Сарны гэрэлд навчин дээр нэгэн жижигхэн өндөг харагдана". Нар мандлаа. Бүтэн сайн өдрийн дулаахан өглөө боллоо. Өнөөх өндөгнөөс пөг гээд нэгэн жижигхэн авгалдай гарч ирэв. Авгалдайн гэдэс маш их өлсч байлаа. Гэдэс нь өлссөн авгалдай юм олж идэхээр мөлхлөө.

**Нэг дэх өдөр** нэг алим нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлсөөд л байлаа.

**Хоёр дахь өдөр** хоёр лийр нүхэлж идлээ. Гэвч бас гэдэс нь өлсөөд л байлаа.

**Гурав дахь өдөр** гурван чавга нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлссөөр байлаа.

**Дөрөв дэх өдөр** дөрвөн гүзээлзгэнэ нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлссөөр л байлаа.

**Тав дахь өдөр** таван жүрж нүхэлж иджээ. Гэвч гэдэс нь өлссөн хэвээрээ л байв" харин хагас сайн өдөр авгалдай нэг зүсэм шоколадтай бялуу, нэг зайрмаг, нэг өргөст хэмх, нэг зүсэм бяслаг, нэг хэрчим хиам, нэг модон чихэр, нэг зүсэм интоортой боов, нэг зайдас, нэг жижиг кекс, тэгээд бас нэг зүсэм тарвас нүхэлж иджээ.

Орой болоход авгалдайн гэдэс маш их өвдөж гэнэ"

**Бүтэн сайн өдөр** боллоо. Авгалдай амттай ногоон навч олж иджээ. Тэгээд гэдэс нь зүгээр болж гэнэ. Ашгүй нэг юм авгалдайн гэдэс өлсөхөө болилоо. Жижигхэн байсан авгалдай одоо ийм том, тарган болжээ. Удалгүй авгалдай өөртөө жижиг бүрхүүлэн гэр барилаа. Авгалдай гэр дотроо хоёр долоо хоног гаруй амьдарчээ. Дараа нь гэрийн бүрхүүлээ цоолж нүх гаргалаа. Тэгээд хамаг чадлаараа зүтгэсээр байгаад гадагшаа гартал ийм гоё эрвээхий болчихсон байлаа".

## ТАВАН ХОШУУ МАЛ

### Зорилго:

- Хүүхэд таван хошуу малын тухай ярих, төл малыг нэрлэх, малын зүсийг ярилцах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Төл малын зураг

### Дасгал 1.

1. Дараах шүлгийг уншиж өгч ярилцаад тогтоолгоорой.

*М.Энхжаргал*

### ТАВАН ЭРДЭНЭ

Малчин манай хотонд таван хөөрхөн эрдэнэ бий  
Таван хөөрхөн эрдэнэ минь тавтай сайхан бэлчдэг  
Хундан цагаан хурга минь майлсаар ижийдээ хүрнэ  
Хув цэнхэр ишиг минь хашаа, саравч өөд цоройлно  
Хул алаг унага минь уяан дээр цовхчино  
Хүрэн улаан тугал минь мөөрөн мөөрөн ирнэ  
Ховорхон цагаан ботго минь бөн бөн тэшээд буйлна  
Малчин манай хотонд таван хөөрхөн эрдэнэ бий  
Таван хөөрхөн төлөө талыг дүүргээд өсгөнө дөө

2. Хүүхэдтэйгээ зургийг ажиглан төл малын төрх байдал, онцлогийн тухай ярилцаарай.
  - Шүлгийг яагаад “Таван эрдэнэ” гэж нэрлэв?
  - Чи хайртай төл малаа юу гэж өхөөрддөг вэ? гэх зэрэг асуулт тавьж ярилцаарай.

### Дасгал 2.

**Эх, төл малыг нэрлэх, эхтэй нь холбож зурж, ярилцаарай.**

Хүүхдээр ишиг, унага, тугалын зургийг (хув цэнхэр ишиг, хул алаг унага, хүрэн улаан тугал) өнгө ялган будуулж, яагаад ингэж зүсэлсний учрыг тайлбарлаж өгөөрэй.

## ТАВАН ХОШУУ МАЛ

### МЭДЭЭЛЭЛ

**Мал зүслэх** - малыг зүсээр нь оноон зааж өгөх, сонгох

**Хонь:** хар, харандан, харлаг, бор, борондон, борлог, шарандан, халзан, хар халзан, шар халзан, бор халзан, хөх, хөх хүзүүт, хар хүзүүт, улаан хүзүүт, хөх шанаат, шар нүдэн, хар нүдэн, бор нүдэн, улаан нүдэн, хөх нүдэн, цахир, хялман, улаан, хар түрүүт, бор түрүүт, хөх түрүүт, хундан, хув, таг, хар толгойт, бор толгойт, улаан толгойт

**Ямаа:** хөх, хар, улаан, хөх, орог саарал, цагаан, цоохор, сарман, орог, зэгэл, манхан, хар халзан (бүх бие хар зөвхөн магнай халзан), хөх халзан

**Адуу:** хүрэн, хээр, халтар, ухаа, зээрд, хул, хул алаг, хонгор, цавьдар, шарга, саарал, бор алаг, бор/хөх/, бор алаг/борлог/, цоохор, харлаг, борлог, загал, буурал, халиун, халзан, хээр алаг, хар, шаазгай, хар халтар, улаан буурал, бүүдэн, цагаан, цэгээн

**Үхэр:** цагаан, ягаан, хөх алаг, хар тарлан, улаан тарлан, бор тарлан, ухаа, халзан, хүрэн, бидэртэй хүрэн, улаан

**Тэмээ:** улаан, цагаан, хар, бор, зандан хүрэн гэж зүсэлдэг байна.



### Зорилго:

- Хүүхэд зохиолын үйл явдлыг харуулсан зургийг дарааллын дагуу байрлуулж ярих
- Хүүхэд шагайн наадам тоглох дүрэм баримтлах ээлжилж тоглож сурах, гарын хөдөлгөөний эвсэлтэй болох

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Хавсралт - Наадам зураг №11
- Шагай

### Дасгал 1.

1. Та хүүхдэдээ дараах зохиолыг уншиж өгөөрэй.

*Х.Батхүү*

### ЭРХ ЦООХОР

Хавар ирлээ. Цас мөс хайлж, байгаль дэлхий өнгөө засаж эхэллээ. Хадан дээгүүр ишигнүүд мөргөлдөн тоглох нь хөөрхөн.

Алтангэрэл хүү зургаан настай. Ишиг хургандаа хэзээний эзэн нь болжээ. Хүү ишиг, хургаа хариулж явахдаа бахаа ханатал эрхлүүлж тоглоно. Тэр нь хүүд жаргалын дээд болдог байв. Ишиг болгон хөөрхөн ч өвөөгийнхөө зүсэлж өгсөн цагаан ямааны цоохор ишгийг бусдаас илүү хайрлана. Ишиг нь эзэндээ тун их дасчээ. Алтангэрэлийг хаа л явна майлсаар дагаж гүйнэ.

Цоохор ишиг, хүү хоёр өдөр өнгөрөх бүр дассаар л байлаа. Тэр эрх цоохортойгоо хамт байхын тулд өдөр бүр ишиг, хургаа хариулдаг болов. Миний хүү малч шүү! гэж ээж магтана. Эхийнхээ үгэнд урамшсан Алтангэрэл том хүн шиг хэвлүүн харагдана. Бүр өвөө шигээ малчин болсон мэт маадгар алхална.

Тэр салхитай нэгэн бүүдгэр өдөр хурга, ишгээ бэлчээв. Эрх цоохор нэг л адтай сүргээ манлайлж явна. Ишигнүүд яргуй хөөсөөр холджээ. Алтангэрэл ишигнийхээ араас хөөцөлдсөөр гэрээсээ холдсоноо анзаарсангүй. Ишгээ гүйцээд, хадны нөмөрт түр амсхийв. Эрх цоохор дэргэд нь ирлээ. Шөнтгөр хошуугаараа бяцхан хурууг нь хөхөхийг оролдоно. Хүү хуруугаа холдуулж, ойртуулж наадна.

Гэтэл салхи исгэрэх мэт хачин чимээ гарлаа. Тайван идээшилж байсан хурга ишиг хуйлран бөөгнөрөх нь тэр ээ. Тоглож байсан хүү сандран, ишиг, хургаа хурдаллаа.

Аймшигт бүргэд тэртээ дээрээс хоёр далавчаа хумин, хурц хумстай савраа

дэлгэн, хурга, ишиг рүү дайран орлоо. Шунгинан доошлох нь сум шиг л харагдана. Бяцхан хүү чадал мэдэн, хашхирах гэтэл айснаас дуу нь гарсангүй. Бүргэд жижигхэн хар ишгийг яах ийхийн зуургүй шүүрэн орилуулсаар хөөрлөө.

Ишигний өрөвдөлтэй майлах дуу гарсаар хадтай толгойг давав. Түүний дуу чихэнд нь "Намайг авраач ээ" гэх шиг сонсогдсоор л байлаа. Гэнэт ээжийнх нь үг бодогдов. Хүү шилбүүрээ дээр өргөн чанга атгаад, бүргэдийн хойноос хар хурдаараа гүйлээ. Алтангэрэлийг очиход, бүргэд ишгийг газарт наалдуулаад дарчихсан байв. Зориг орж чанга хашхиртал, бүргэд ашгүй ишгийг орхиод нислээ.

Хар ишиг хүүгийн энгэрт наалдан уйлах мэт аяархан майлав. "Саяхан л бүргэдэд идүүлэх гэж байсан шүү" гэж бодохоос өрөвдмөөр. Хүү ишгээ улам чанга тэврэв.

Энэ өдрөөс эхлэн, хув хар ишиг Алтангэрэлийн хамгийн хайртай ишиг нь болов оо.

2. Зохиолын үйл явдлыг харуулсан зургийг хавсралт хэсгээс авч хүснэгтэд дарааллын дагуу байрлуулаарай.

3. Дараах асуултаар ярилцаарай.

- Хүү ишгээ яагаад "Эрх цоохор" гэж нэрлэсэн бэ?
- Чи ишгээ хэрхэн аврах байсан бэ?

## Дасгал 2.

Хүүхэдтэйгээ хамтдаа дараах тоглоомоор тоглоорой. Тоглох арга, дүрмийг тайлбарлаж өгөөрэй.

- Тоглоомын явцад хүүхэд шагай орхих, дөрвөн бэрхийг нэрлэх, ажиглахад сургаарай.
- Тоглох явцад 10 - 20 дотор оноож тоолох чадварыг дэмжээрэй.

### ХУРГА ИШГЭЭ БЭЛЧЭЭ

(Шагайн тоглоом)

#### Тоглоомын дүрэм:

- Дөрвөн бэрх орхиж, буусан шагайг зөв нэрлэх, оноож зөв тоолох, шударга тоглох, өөрийн ээлжийг хүлээж, тэвчээртэй тоглох чадварыг дэмжинэ.

#### Тоглоомын явц:

- Тоглогчид өөрсдийн арав, арван шагайг нийлүүлж, олбог дээр тараан орхино.
- Ээлжээр "Дөрвөн бэрх" орхиж, зөвхөн хонь, ямаа буусан шагайг авч өөрсдийн бэлчээр болгож буй газартаа өрж байрлуулна.

- Тоглогчид дэвсгэр дээрх шагай дуусахад өөрсдийн бэлчээсэн хонь, ямааг тоолно.
- Хэн олон хонь, ямаа бэлчээсэн нь хожно.
- Хүүхэд хэдэн хонь, ямаа бэлчээснээ тоолох, мөн тоглогч бүрийн хонь, ямаа тус бүрдээ хэд, нийлээд хэд байгааг тоолж тоглож болно.

### **САНАМЖ**

- Та чөлөөт цагаараа хүүхэдтэйгээ шагайн тоглоом тоглоорой.
- Хүүхдэдээ тоглонгоо оноож тоолох, нэмэх хасах үйлдэл хийж сурахад туслаарай.
- Дуу цахилгаантай бороо орох үед шагайн тоглоомоор тоглож болохгүйн учрыг хэлж өгөөрэй.



## БҮТЭЭЛЧЭЭР СЭТГЭЭ

### Зорилго:

- Хүүхэд зурах хялбар аргаас сурах, зургаа баяжуулах, сэтгэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Зургийн дэвтэр, усан будаг, бийр, өнгийн харандаа

### Дасгал 1.

Та хүүхдэдээ мөр, толбоор зурах дарааллыг хэлж өгч зуруулаарай.

- Гарын алга, хурууны өндгийг усан будагтай бийрээр будна.
- Будсан алга, хуруу, өндгөөр цаасан дээр дарж, мөр гаргана.
- Гарсан мөрийг дүрс болгон зурж "амилуулна". Жишээлбэл: Гарын алганы мөрийг шувуу болгон баяжуулж зурах гэх мэт.
- Гарсан мөрийг дүрс болгон тодруулах, онцлог шинжийг хэрхэн гаргаж зурахыг хэлж, зөвлөн чиглүүлээрэй.

### Дасгал 2.

Өөр бусад зүйл ашиглан мөр гаргаж зурж туршаарай.

### САНАМЖ

- Хүүхдийн бүтээлийг магтаж, хананд байрлуулж, бусдад үзүүлж, урамшуулаарай.
- Усан будгаа хэт шингэн найруулж болохгүй гэдгийг сануулаарай.
- Зурж дуусаад гараа савандаж угаахыг хэлж өгөөрэй.

**Зорилго:**

- Хүүхэд соронзоор энгийн туршилт хийх
- Хүүхэд бүтээлчээр сэтгэж зурах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Соронз, хайрцаг
- Зургийн хэрэгсэл, өнгийн цаас, хайч, ундааны сав

**Дасгал 1.**

Та хүүхдэдээ соронзны тухай ярьж өгөөрэй. Ширээн дээр байгаа зүйлүүдийг (түлхүүр, товч, хадаас, бөглөө, үсний боолт гэх мэт) соронз татах уу, түлхэх үү гэж асуугаад туршилт хийгээрэй. Соронзод татагдаж байгаа зүйлийг “Тийм”, татагдахгүй байгаа зүйлийг “Үгүй” гэсэн хайрцагт ялгаж хийгээрэй.

**Дасгал 2.**

Зургийн дэвтрээ хээлнэ. Гялгар уутаа хийлж, бөмбөлөг хэлбэртэй болгож, усан будгаараа будаад, зургийн дэвтэр дээрээ дарахад янз бүрийн хэлбэр бүхий хээ үүснэ. Мөн ундааны савны ёроол хэсэгт усан будаг түрхээд цаасан дээрээ дарвал цэцэгний дүрс, хээ үүсгэх гэх зэргээр янз бүрийн аргаар хээ, угалз үүсгэн цаасаа чимэглэж үзээрэй.

**САНАМЖ**

- Хүүхэд янз бүрийн зүйл ашиглан хээ тавьж туршиж үзэхэд нь дэмжиж туслаарай.

**Зорилго:**

- Хүүхэд 12 жилийг нэрлэх, дарааллыг мэдэх, өөрийн төрсөн жилээ ялгах
- Хүүхэд 12 жилийн магтаалыг дуулах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн №2 – Арван хоёр жил (магтаал)
- Хавсралт - Наадаг зураг №12

**Дасгал 1.**

Та хүүхдээр зураг дээрх арван хоёр жилийн амьтдыг нэрлүүлээрэй. 12 жилийн магтаалыг хамтдаа сонсоод дуулаарай.

**Арван хоёр жилийн магтаал**

Эрдэнийн зүйлээр бөөлжөөд байдаг  
Эрүү цагаан хулгана нэгэн жил

Эвэр сүүл нь тэнцүүхэн байдаг  
Эзэндээ ээлтэй үхэр хоёр жил

Арын модонд алаглаад байдаг  
Алаг эрээн бар гурван жил

Дэлхий дээгүүр дэгдээд байдаг  
Дэлдэн чихтэй туулай дөрвөн жил

Хөх тэнгэрт хүржигнээд байдаг  
Хүч ихтэй луу таван жил

Цаг үргэлж цагриглаад байдаг  
Цагаан эрээн могой зургаан жил

Холын газрыг товчлоод байдаг  
Хомбон туурайтай морь долоон жил

Хотгор газрыг хорголоор дүүргэдэг  
Хотондоо ээлтэй хонь найман жил

Харсан бүхнээ элэглээд байдаг

**12 ЖИЛ**

Илбэчин эрдэмтэй бич есөн жил

Үүрийн жингээр донгодоод байдаг  
Эвэр хошуутай тахиа арван жил

Хортон дайсныг хоргоогоод байдаг  
Хон хон дуутай нохой арван нэгэн жил

Хөрст газрыг сэндийлээд байдаг  
Хөндлөн соёотой гахай арван хоёр жил

Хүүхдэдээ дараах зүйлийг тайлбарлаарай. Үүнд:

- Жил, сар, цагийг арван хоёр жилийн амьтны нэрээр нэрлэдэг.
- Жил, сар, цагийн дараалал өөрчлөгддөггүй.
- Миний хүү/ охин ямар жилтэй вэ?

**Дасгал 2.**

12 жилийн дарааллаар нь нааж байрлуулаарай.

**САНАМЖ**

Хүүхдэд арван хоёр жилийн нэр, дарааллыг тогтоолгож тоглуулаарай.



**Зорилго:**

- Хүүхэд бяцхан ном бүтээх аргачлалын дагуу эвхэж, бүтээх
- Хүүхэд цаг хугацааг заасан үгийг ойлгох, яриандаа зөв хэрэглэх

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- 10x10см хэмжээтэй 4 ширхэг ам дөрвөлжин цаас
- 20x20 см хэмжээтэй 1 ширхэг цаас
- Бичгийн болон өнгийн цаас, цавуу, хайч, өнгийн харандаа

**Дасгал 1.**

1. Та хүүхдээр зураг дээрх бяцхан ном хийх аргачлалыг ажиглуулаад ярилцаарай.

2. Аргачлалын дагуу ном эвхэж бүтээхэд туслаарай.

“Бяцхан ном” хийх дараалал

А) Өнгийн том цаасыг голоор нь тэнцүү нугалан бэлтгэнэ. Энэ нь номын хавтас болно.

- Бэлтгэсэн 4 ширхэг ам дөрвөлжин цаасыг гурвалжин болгон хошуулдаж нугална.
- Хошуулдсан цаасаа зураг дээрх шиг өнцгүүдийг нийлүүлж наагаад ном болно.

Б) Дээрхтэй ижил аргаар нэг том цаасаар хийж болно.

- 20x20 см хэмжээтэй ам дөрвөлжин цаасны ирмэгүүдийг давхцуулан 4 тэнцүү дөрвөлжин үүсгэж нугалаад тэнийлгэнэ. Цаасны 4 өнцгийг цаасны гол цэг (нугалаасны уулзвар) дээр давхцуулан нугална.
- Нугалсан дөрвөлжин цаасаа хавтас болох том цаасны дотор талд нааж ном бэлэн болно.

Хүүхдэдээ номондоо нэр өгөх зураг дүрсээр чимэглэхэд тусалж нэрийг томоор бичиж өгөөрэй. Хүүхдээр номыг яаж хийсэн тухай нь яриулж, магтан урамшуулаарай.

**Дасгал 2.**

Өнгө өнгийн дүрсүүдийг ашиглан дараах тоглоомыг тоглуулаарай.

Хүүхэд асуусан асуултад зөвхөн “Өчигдөр, өнөөдөр, маргааш” гэсэн хариултуудын аль тохирохыг хэлнэ.

- “Өчигдөр” гэсэн хариулт бүхий асуултад зөв хариулбал хөх дүрс
- “Өнөөдөр” гэсэн хариулт бүхий асуултад зөв хариулбал улаан дүрс
- “Маргааш” гэсэн хариулт бүхий асуултад зөв хариулбал шар дүрс авч өмнө талдаа тавина. Улаан, шар, хөх өнгийн дүрс тус бүр 3, нийт 9 ширхэгийг цуглуулснаар ялагч болно.

**Асуултууд**

- Өглөө болоход газар нойтон болсон байлаа. Бороо хэзээ орсон бэ? (Өчигдөр)
- Өчигдөр би иштэй чихэр идсэн. Өнөөдөр ишгүй чихэр идэж байна. Би хэзээ зөөлөн чихэр идэх вэ? (Маргааш)
- Өнөөдөр би Хүслэнтэй тоглож байна. Маргааш Дөлгөөнтэй тоглоно. Анартай хэзээ тоглох вэ? (Өчигдөр)
- Ээж одоо хоол хийж байна. Би хэзээ идэх вэ? (Өнөөдөр)
- Өчигдөр би усанд явсан. Маргааш ах усанд явна. Эгч хэзээ усанд явах вэ?(Өнөөдөр)
- Өчигдөр би цэнхэр цамцаа өмссөн. Маргааш би ногоон цамцаа өмсөнө. Улаан цамцаа хэзээ өмсөх вэ? (Өнөөдөр)
- Өчигдөр ээжийнхээ хээр морийг унасан. Өнөөдөр өөрийнхөө хул морийг унаж байна. Аавынхаа бор морийг хэзээ унах вэ? (Маргааш)
- Өчигдөр бууз идсэн. Өнөөдөр цуйван идэж байна. Хэзээ банш идэх вэ? (Маргааш)
- Өглөө босоход гэдэс өлссөн байв. Би хэзээ хол идсэн бэ? (Өчигдөр)

**САНАМЖ**

- Хүүхдийнхээ сурсан, мэдсэн зүйлийн тухай яриулан, суралцах хүслийг нь дэмжээрэй.

### Зорилго:

- Хүүхэд цүнх урлан бүтээх
- Хүүхэд шүр хэлхэхдээ давтамж үүсгэх

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Янз бүрийн өнгө хэлбэр, хэмжээтэй резинэн суурь, шүр, утас, хуванцар зүү
- Өнгийн харандаа (улаан, хөх, шар)

### Дасгал 1.

1. Та хүүхэдтэйгээ хамтран зурагт үзүүлснээр цүнх хийгээрэй (Даавууны өөдөс, цаасан хайрцаг, бусад материал ашиглан доорх аргачлалаар төрөл бүрийн эд зүйлс хийж болно).
  - Утсандаа өнгийн шүрээ хэлхэж, зүүндээ утсаа сүвлэж, бэлтгэсэн байна.
  - Цүнхний 2 талыг давхцуулан барина.
  - Хуванцар зүүгээ ашиглан нүхний дагуу хөших оёдлоор оёно.
  - Цүнхний бариулыг бэхэлж, үзүүрийг зангидна.
  - Чимэглэлийн зургийг авч цүнхний нүүрэн хэсэгт наана.
2. Хүүхэд хийсэн цүнхээрээ гоёж, загвар үзүүлж, эгч болон дүүдээ бэлэглэж, тоглохыг дэмжээрэй.
3. Цүнх хэрхэн хийсэн аргачлалаас санаа авч сонирхсон зүйлийг нь хийлгээрэй.

### Дасгал 2.

1. Шүрэн хэлхээг ажиглуулан улаан, шар, хөх өнгөөр зүй тогтлыг олж будуулаарай.

### САНАМЖ

- Хүүхэд шүрийг ам, хамар, чихэндээ хийхээс сэргийлж, аюулгүй ажиллахыг сануулаарай.
- Хүүхдэдээ шүр, товч болон өөрийн сонирхсон жижиг зүйлсийг хадгалах сав, хайрцагтай болоход туслаарай.

**Зорилго:**

- Хүүхэд зохиолын утгыг ойлгож, ярилцах
- Хүүхэд “Олуулаа” дууг дуулах

**Бэлтгэх зүйл:**

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- “Гавар сурагч болсон нь”
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн № 21 - “Олуулаа” дуу
- Балын харандаа

**Дасгал 1.**

1. Та хүүхдэдээ дараах зохиолыг уншиж өгөөрэй.

*Д.Доржсүрэн*

**ГАВАР СУРАГЧ БОЛСОН НЬ**

Үнэгний гавар сургуульд орж, нэгдүгээр ангийн сурагч болжээ. 1-10 хүртэлх тоог заалгаж гэнэ. 1-ийн ард 0 бичвэл 10 болно. 3-ын ард 0 нэмбэл 30 болно гэж хичээлдээ ирэх замдаа үргэлж цээжилж явдаг байв. Гэртээ очоод даалгавраа хийхээр дэвтрээ гаргаж, хавтсан дээрээс нэгдүгээр ангийн сурагч Гавар гэж үсэглэн уншжээ. Түүний сэтгэлд нэгэн сонин бодол төрөв. Дандаа нэгдүгээр ангийн сурагч байх ямар хэрэгтэй юм бэ?. Түрэгхэн шиг аравдугаар ангийн сурагч больё. Нэгийн тооны ард ганцхан тэг тавихад л болох нь тэр гэж бодов. Гавар ингэж хоромхон зуур аравдугаар ангийн сурагч болсондоо баярлажээ. Маргааш болж хичээлдээ очоод өөрийн олсон мэргэн аргаа нөхдөдөө гайхуулан ярив. Гаварууд түүнийг дуурайж, дэвтрийнхээ хаягийн нэгийн тооны ард тэг нэмж, бүгд аравдугаар ангийн сурагчид болцгоолоо. Багш орж ирээд нэгдүгээр ангийнхаа хичээлийг зааж эхлэв. Гаварууд ихэд гайхацгаажээ. Тэд өөрсдийгөө аравдугаар ангийн сурагчид болсон гэж үнэнээсээ итгэсэн байжээ.

2. Хүүхэдтэйгээ зохиолын утгыг “Гаварууд яагаад гайхсан вэ?” асуултын дагуу ярилцаарай.

**Дасгал 2.**

Дасгалын зургийг ажиглуулаад, хүүхдүүдийн цүнхийг олж, холбон зуруулаарай.

**Дасгал 3.**

Дараах дууг сонсгоод зааж сургаарай. Бичлэгийг давтамжтай сонсгож утга санааг нь ярилцаарай. Дууны үгийг мөр мөрөөр, бадаг бадгаар нь зөв, тод хэлж цээжлүүлээрэй.

*Үг. Д.Содномдорж*

*Ая. С.Батболд*

**ОЛУУЛАА**

Хүүхдүүд бид нар сургуурь дээрээ

Хөгжилтэйхэн байдаг даа

Олуулаа бид дуулдаг даа

Олуулаа бид бүжиглэдэг

Дахилт: Олуулаа

Олуулаа

О-луу-лаа

Багачууд бид нар сургууль дээрээ

Баясалтайхан байдаг даа

Олуулаа бид уншдаг даа

Олуулаа бид хөгжимддөг

Дахилт: Олуулаа

Олуулаа

О-луу-лаа

Жаалууд бид нар сургууль дээрээ

Жаргалтайхан байдаг даа

Олуулаа бид авьяастай

Олуулаа бид авхаалжтай

Дахилт: Олуулаа

Олуулаа

О-луу-лаа

**САНАМЖ**

- Та хүүхдэд хичээлдээ хоцролгүй очдог, бусдаас зөвшөөрөл авч эд зүйлсийг нь авч хэрэглэдэг зэргээр сургуулийн дүрмийг танилцуулаарай.

## БИ ЧАДНА

### Зорилго:

- Хүүхэд ариун цэвэрч байх энгийн дадал хэвшилтэй болох
- Хүүхэд найзтайгаа хамтарч тоглох, тоглоомын дүрэм баримтлах

### Бэлтгэх зүйл:

- “Би чадна” дасгал ажлын дэвтэр
- Зурагт карт
- Хавсралт - Хайчилбар №6
- Ном, тоглоомын багц

### Дасгал 1.

Хүүхэдтэйгээ хамт зургийг сайтар ажиглаад, үйл явдлын дагуу ярилцаарай.

#### Зураг 1:

- Бамбарууш юу хийж байна вэ?
- Бамбарууш яагаад гараа угааж байгаа юм бол?
- Чи гараа ямар тохиолдолд угаадаг вэ?
- Гараа савандаж угаахгүй бол яах вэ?

#### Зураг 2:

- Хоёр зургийн хооронд ялгаа байна уу? Хараад ярилцаарай.
- Чи өдөрт хэдэн удаа шүдээ угаадаг вэ?
- Хэрэв шүдээ угаахгүй бол яах вэ?
- Шүд өвдвөл бид хэнд хандах хэрэгтэй вэ?

#### Зураг 3:

- Хоёр зургийн хооронд ялгаа байна уу? Сайн ажиглаарай.
- Чи хэдэн цагт унтдаг вэ?
- Өглөө хэдэн цагт босдог вэ?
- Яагаад тогтмол цагт унтах нь сайн бэ?

#### Зураг 4:

- Чи долоо хоногт хэдэн удаа усанд ордог вэ?
- Усанд орохдоо юуг анхаарах вэ?
- Хэрэв усанд орохгүй бол яах бол?

#### Зураг 5:

- Хогоо хаана хаях хэрэгтэй вэ?
- Цэвэр цэмцгэр орчинд амьдрахыг хүсэж байгаа бол бид юу хийх хэрэгтэй вэ? гэх мэтээр харилцан ярилцаарай.

**Дасгал 2.**

**НАЙЗАЛЪЯ**

(Хөзрөн тоглоом)

**Тоглоомын хэрэглэгдэхүүн:**

- Хайчилбар №6 зурагнаас зурган картаа хайчилж авна.

**Тоглоомын дүрэм:**

- Хүүхдүүд ээлжлэн картаа сөхөж авна.
- Өөрийн картыг тайлбарлаж, чадаагүй нь дараагийн хүүхдэд шилжүүлж тоглоно.
- Найз нөхдөө сонсож, бусдад саад болохгүй байна.

**Тоглоомын явц:**

Тоглоомд 2-3 хүн оролцоно. Оролцогчид тойрч суугаад хайчилж бэлдсэн зурган картаа доош харуулан хольж тавина. Нэг нэгээрээ ээлжлэн картыг дээш харуулан зургийг ажиглан, миний найзад ямар тусламж хэрэгтэй болсон, хэрхэн туслахаа бусдад ярьж өгнө. Харин тусламж шаардлагагүй хүүхдийн зурагт хуудас авсан бол юу хийж байгааг нь тайлбарлаад, яагаад тусламж хэрэггүй талаар ярилцана.

**Дасгал 3.**

Дараах дууг зааж сургаарай. Утга санааг нь ярилцаарай. Дууны үгийг мөр мөрөөр, бадаг бадгаар нь зөв, тод хэлж, цээжлүүлээрэй.

*Үг, ая Д.Энхтуяа*

**БҮХНИЙГ БИ СУРЛАА**

Өнгө өнгөөр ялгаж сурлаа  
 Өөрөө би зурж сурлаа  
 Цэцэг навч нар сарыг  
 Цэвэр гоё будаж сурлаа даа  
     Сурлаа би сурлаа  
     Бүхнийг би сурлаа  
 Нэг хоёроор тоолж сурлаа  
 Нэмж хасаж бодож сурлаа  
 Аав ээжийн өгсөн мөнгөөр  
 Алим авч чаддаг боллоо доо  
     Сурлаа би сурлаа  
     Бүхнийг би сурлаа

**САНАМЖ**

- Хүүхдийнхээ сурсан, мэдсэн зүйлийн тухай яриулан, суралцах хүслийг нь дэмжээрэй.

## ХҮҮХЭДТЭЙГЭЭ АЖИЛЛАХДАА ДАРААХ ЗӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭЭРЭЙ

### Нэг. Хүүхэдтэйгээ хамтарч тоглоё.

- Хүүхэдтэйгээ тоглох цаг, зав гаргаарай.
- Хүүхдийн оюун сэтгэхүйг хөгжүүлэх даам, шатар, шагай, угсарч бүтээх тоглоомоор хамтдаа тоглож, зааж сургаарай.
- Хүүхэд хүмүүсийн ажил хөдөлмөр, үг яриа, үйл хөдөлгөөнийг дуурайн тоглохыг нь дэмжээрэй. Болно, болохгүй зүйлийг ойлгуулаарай.
- Хүүхэд найз нөхөд болон бусадтай эвсэг найрсаг, хамтарч тоглоход туслаарай.

### Хоёр. Хүүхэдтэйгээ хамт тоолж, хэмжье.

- Эд зүйлсийг тоолохдоо оноож тоолуулаарай.
- Тухайн тооны өмнөх ба дараагийн тоог нэрлүүлж, тоо бүхий хөзрөөр тоглоорой.
- Орчны эд юмсын хэлбэрийг асууж ярилцаарай.
- Эд юмсыг хэмжих, харандаа, савх, мод зэрэг стандарт бус хэмжүүр ашиглаж болдгийг мэдүүлээрэй.
- Нэг юмны байрлалаар нөгөө юмсын байрлалыг тодорхойлуулаарай.
- Үйл явдлыг цаг хугацаатай холбож асууж, тайлбарлаж, ярилцаарай.

### Гурав. Хүүхэдтэйгээ хамт үлгэр уншицгаая.

- Хүүхдэд номын нүүр, хавтас, хуудас, тал, нуруу зэргийг тайлбарлаарай.
- Ном уншиж өгөхийн өмнө хүүхдийн сонирхлыг татаж, ажиглуулаарай.
- Уншиж дуусаад ойлгосон зүйлийг зуруулж, тайлбарлан ярилцаарай.
- Хүүхдэд үлгэр, зохиолыг байнга уншиж, ярьж өгөөрэй.
- Хүүхдэд дөхүүлэх асуулт тавих, сануулах, хариулах боломж олгох зэргээр ярилцаарай.
- Хүүхдийн яриаг таслахгүй, анхааралтай, тэвчээртэй сонсоорой.
- Хүүхдийн хэл ярианы хөгжилд аав ээж, орчны хүмүүсийн ярианы соёл онцгой нөлөөлдөг болохыг санаж, сайнаар үлгэрлээрэй.



### **Дөрөв. Хүүхдийг ажил хөдөлмөрт оролцууля**

- Хувцсаа өмсөх, солих, зөв хооллох, нүүр гараа угаах, үсээ самнах, шүдээ угаах, тоглоомоо хураах гэх мэт “Өөртөө үйлчлэх хөдөлмөр”-ийг хийлгэж хэвшүүлээрэй.
- Хүүхдийн “Би”, “Би чадна” гэсэн хүсэл эрмэлзлэлийг дэмжээрэй.
- Хүүхдэд хэт хүндэдсэн ажил хийлгэхээс татгалзаж хөдөлмөрийг нь урамшуулаарай.

### **Тав. Хүүхэдтэйгээ хамтран дуулж, хөгжимдөж, бүжиглэе.**

- Дууг олон дахин сонсож, аялгууг нь хоногшуулж, дагаж дуулуулаарай.
- Дуу, шүлгийн үгийг зөв тод хэлүүлээрэй.
- Сурсан дуу, шүлгээ бусдад дуулж, уншиж сонирхуулахыг дэмжиж урамшуулаарай.
- Хүүхэд сурсан дууныхаа аялгуунд хөдөлгөөн хийх, бүжиглэхийг дэмжээрэй.
- Хүүхдийн хоолойн цар хүрээнд тохирсон, хүүхдийн дууг дуулуулаарай.
- Хүүхдийг дуулах, хөгжимдөх, шүлэг унших, бүжиглэхэд шоолж болохгүй.

### **Зургаа. Хүүхэдтэйгээ хамт зурья, урлан бүтээе.**

- Усан будгийг найруулах, бийрэнд тохируулан авах, бийрийн нэг удаагийн даралтаар зураасыг өргөн, нарийн гаргах, будахад туслаарай.
- Янз бүрийн зураг, дүрсийн хүрээ, нугалаасыг дагуулан хайчлах, тодорхой цэг хүртэл хайчлахад дэмжлэг үзүүлээрэй.
- Шаврыг хэсэглэн хуваах, алганы хооронд өнхрүүлэн бөөрөнхийлөх, гонзгойлох, хавтгайлах, сунгаж татах дүрслэхэд туслаарай.
- Хүүхэд бүтээлээ хадгалах, бусдад танилцуулах боломж олгоорой.
- Хэрэглэсэн эд зүйлээ байранд нь хураахад туслаарай.

### **Долоо. Хүүхдийг цэвэр, нямбай байдалд сургацгаая.**

- Орчноо цэвэрхэн байлгах, юмсыг байранд нь буцааж тавих, чадах зүйлээ угааж сурахыг дэмжээрэй.
- Түүхий сүү, ус уух, жимсийг угаалгүй идэхгүй байхад сургаарай.

- Хувийн ариун цэврийг сахих чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж үлгэрлээрэй.
- Байгаль орчин, голын усанд хог хаяхгүй байхыг зөвлөөрэй.

#### **Найм. Хүүхэдтэйгээ эелдэг харилцъя.**

- Хүүхдийн таатай, таагүй байдлыг мэдэрч, хүсэл сонирхлыг хүндэтгээрэй.
- Хүүхдийн хүсэлт, гуйлтыг анхааран сонсож, тусалж дэмжих ба боломжгүй зүйлийг тайлбарлаарай.
- Аав ээж, ахан дүүс, ахмад хүмүүс, үеийнхнээ хүндэлдэг, мэндэлдэг, бусдад туслахад үлгэрлээрэй.
- Баярлаж талархсанаа илэрхийлэх, бусдыг уучилж сурахад үлгэрлэн дагуулаарай.
- Бусдын юмыг зөвшөөрөлгүй авч, оролдож болохгүйг ойлгуулаарай.
- Айх, гайхах үедээ бусдад мэдэгдэх, асуух, тусламж хүсэхийг хэлж тайлбарлаарай.
- Бусадтай эв найртай, аливааг хуваалцаж, хожиж, хожигдож хамтран тоглохыг дэмжээрэй.

#### **Ес. Хүүхдээ аюулгүй байлгая.**

- Нүд, шүд, чих, хамар ам, гар, хөл зэрэг бие эрхтнээ хайрлан хамгаалах тухай ойлгуулаарай.
- Халуун хоол, цай, цахилгаан хэрэгслээс болгоомжлохыг сануулж, тэдгээртэй харьцахдаа томчуудаас туслалцаа авахыг зөвлөөрэй.

## ТА ХҮҮХДЭЭ СУРАГЧ БОЛОХОД НЬ ДАРААХ ЗҮЙЛИЙГ АНХААРЧ, ТУСЛААРАЙ.

- **Бие даан өөрийгөө авч явах**

Сургуулийн сурагч болмогц цүнх, дэвтэр номдоо эзэн болохоос эхлээд хувцсаа өмсөж тайлах, бие засах гээд л бүх зүйл хүүхдийн толгой дээр ирнэ. Тиймээс та эхлээд хүүхэд маань өөрийгөө бие даан авч явахад ямар хүндрэл гарах билээ гэдгийг эрэгцүүлэн хянаж шаардлагатай зүйл дээр нь туслаарай.

- **Тэвчээртэй болох**

Мөн сурагч хүнд хийж буй зүйлээ дуусгах, тэсвэр тэвчээр шаардана. Үүний тулд эхлээд богино хугацаанд гүйцэтгэх яваандаа арай удаан хугацаанд гүйцэтгэх дасгал даалгавар хийлгээрэй.

- **Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж сурах**


Хэл ярианы хөгжил сайтай хүүхдүүд өөрийгөө чөлөөтэй илэрхийлдэг, нөхцөл байдалд хурдан үнэлэлт, дүгнэлт өгдөг, насанд хүрэгчид шиг аливаа зүйлд ултай ханддаг бол харин үг дуу цөөтэй зарим хүүхэд бусдын царай хардаг, аливаа зүйлд амархан шантардаг, нийтэч биш байх нь ажиглагддаг. Иймд та хүүхэдтэйгээ болсон явдлын тухай ярьж, түүнийг сайн дэмжиж, яриулж байгаарай.

- **Урамшуулж дэмжих**

Шинэ зүйл бүхэн хүүхдийн сонирхлыг татдаг бөгөөд тэдний сурч мэдсэн зүйл бүрийг урамшуулан магтаж, урмын үгээ харамгүй хэлж байгаарай.

- **Сурагч болох**

“Миний хүү, охин удахгүй сургуульд орно, энэ чиний орох сургууль.” гэх мэтээр “Сургууль” гэсэн сэдвийг хэдэн сарын өмнөөс хөндөж байвал зүгээр. Гэхдээ өдөр бүр энэ тухай яриад байвал тэд бас залхах болно. Цүнх, ном, дэвтэр, хувцсыг нь бэлтгэхдээ дагуулж явах, сургуулиар хамт орж үзэх нь тэдэнд сургуульд яарах хүсэл төрүүлнэ.



## НОМ ЗҮЙ

1. Банди.М, Монгол ёс заншлын тайлбар толь, УБ
2. Батаа.Б нар Оюуны хөгжил 4, 5 нас УБ, 2008
3. Батхүү.Х, Ниссэн хүүхэлдэй, УБ
4. Батхүү.Х, Эрх цоохор, УБ
5. БСШУЯ, Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр УБ, 2015
6. Дулмаа.П, Сургалтын орчинд хийх энгийн туршилт, дасгал, тоглоом” УБ, 2013
7. Мон судар, Билэг дэмбэрлийн үгс,АДМОН 2010 он
8. Нарантуяа.Б, Өндөр эгч УБ
9. Наранцэцэг.Ц, Хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх аргагүй УБ, 2008, 2014,2015
10. Болормаа.З, Мөнхтуул. Ц нар Бага насны хүүхдийг хөгжүүлэх хувилбарт сургалтын хөтөлбөр УБ, 2009
11. Шинэбаяр.Ж нар Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн хөтөлбөр УБ, 2015
12. Хэлний боловсрол, УБ
13. Ч.Чогдон, Монгол гэр, УБ,2010
14. Энхтуяа.Я, Цэрэннадмид.Ш, Гэрээ барьж сурцгаая, УБ
15. Экимто, Багачуудын нэвтэрхий толь цуврал УБ
16. Эмпати-Ертөнц” ХХК “Зан харилцааны цуврал” УБ